

Монголын Улсын Боловсролын Тогтолцоо ба Сургалтын Төрийн Сан: Тогтвортой Ирээдүйг Бий Болгох

**Монгол улсын Засгийн Газар
Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яаманд
зориулав.**

2004 оны 5 дугаар сар

**Норман Лароке ба Брайн Ии
nlarocque@nzbr.org.nz
brian@dyconsulting.co.nz**

Хураангуй

- 1990 оны эхэн үеэс хойш Монголын дээд боловсролын салбарт нилээд томоохон хэмжээний шинэчлэлт өөрчлөлт хийгдсэн. Монголын их дээд сургуульд суралцагчдын тоо ихээр нэмэгдэж, 1990-ээс 2002 оны хооронд 33,000-гаас 100,000 болж өсч гурав дахин нэмэгдсэн байна.
- Сургалтын төрийн сан (СТС) нь оюутны санхүүгийн тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бөгөөд буцаан төлөгдөх ба буцаан төлөгдөхгүй олон төрлийн зээл тусламжийг олгодог. Энэ нь дээд боловсролын салбарын өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэсэн нь эргэлзээгүй юм. Зөвхөн 2004 он гэхэд 40,000 гаруй оюутан сурагчид Сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид хамрагджээ.
- Тайлан нь СТС-гийн хүрээнд олгогдсон зээл, буцалтгүй тусламжийн хөтөлбөрийг түүхэн хөгжлийнх нь хувьд тоймлон дүн шинжилгээ хийлээ. Мөн түүнчлэн, тайлан нь СТС-тай холбоотой бодлогын шийдэл болон үйл ажиллагааны зарим нэг дутагдалтай талуудыг судалж, уг хөтөлбөрийн үр ашиг, өгөж болон үйл ажиллагааг дээшлүүлж, тогтвортой байдлыг нь хангах зарим шинэчлэлийн хувилбаруудыг тодорхойлсон.
- Ерөнхийд нь аваад үзэхэд СТС-ийн зээл, буцалтгүй тусламжийн 4 үндсэн хэлбэр байна. Үүнд: сургалтын зээл, сургалтын буцалтгүй тусламж, сургалтын тэтгэлэг болон төрөс санхүүждэг хэлбэрүүд багтана. Эдгээрийг Засгийн газрын хэд хэдэн тогтоолуудаар хэрэгжүүлж эхэлсэн. Тусламжийн эдгээр хэлбэрүүд нь өр хоорондоо дараах нилээд олон хүчин зүйлсээр ялгагдаж байна. (Хүснэгт 3).
- Сургалтын зээл, буцалтгүй тусламжийг зохицуулахад БСШУЯам болон их, дээд сургууль, коллежууд бас чухал үүрэг гүйцэтгэдэг.
- СТС нь Монголын дээд боловсролын хамрагсадын тоог нэмэгдэхэд дэмжлэг үзүүлсэн ч гэсэн түүний санхүүгийн тогтвортой байдалд сөргөр нөлөлөх, Засгийн газрын бодлогын зорилт, зорилгыг биелүүлэхэд саад учруулах бодлогыг болог үйл ажиллагааны загварын олон сул талтай тулгарч байна. Бүлэг 6-д тоочсон эдгээр сул талуудыг дор дурьдав.
 - Сонгон авах шалгуур үзүүлэлтүүдийг өргөжүүлж, улам боловсронгуй болгох
 - Шалтгаан нь тодорхой бус янз бүрийн эрх үүрэг хүлээх нөхцөлтөйгөөр хэт олон төрлийн тусламжийн хэлбэрийг тусгасан төсөл
 - Төслийн зээлийн хүүгийн тогтолцоо нь сул
 - Төслийн зээлийн дахин төлөлтийн механизм сул
 - Төслийн чиглүүлэх механизм сул
 - Зээлийн хэмжээ нь гачигдалтай оюутнуудын хувьд сургалтын төлбөрө бүрэн төлөх боломжгүй.
- СТС нь үлэмж хэмжээний сул талуудтай тулгарч байна. Эдгээрийн зарим нь үндсэн бүтэц муугаас болж, нөгөө хэсэг нь практикт тэр болгон хэрэглэглээд байдаггүй журмуудын нарийвчлал муугаас үүсч байна. Эдгээр дутагдалтай талуудыг дор дурьдав.
 - Үйл ажиллагааны журам нь хэтэрхий нарийн төвөгтэй боловч олон талаар дутуу;
 - Харьцангуй олон тооны ядуу өрх амьдардаг хөдөө, орон нутагт мэдээллийг хангалтгүй тарааж байна;
 - СТС нь оюутны сэтгэл ханамжийн судалгаа хийхгүй;
 - Их, дээд сургууль, коллежууд нь хамрагдах оюутнаа тогтоохын тулд мөрддөг журмууд нь тодорхой бус байна;
 - Өргөдлийг боловсруулах хугацаа маг удаан байна;

- Удирдлагын мэдээллийн систем (УМС) хангалтгүй бөгөөд муу хөгжсөн байна;
 - Сангийн үйл ажиллагааны талаар хяналт, тайлагнал хязгаарлагдмал байна;
 - СТС-гийн захиргааны чадавхи болон тогтолцоонд хөрөнгө оруулалт хийхгүй байна;
 - БСШУЯ болон СТС-гийн үүргийн ялгаа тодорхой бус байна.
- Монгол улсын СТС нь зөвхөн дээрх дурьдсан бэрхшээлүүдтэй тулгарч байгаа бус бөгөөд нилээд олон хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын хувьд үр ашигтай болон санхүүгийн тогтвортой оюутны зээлийн тогтолцоог нэвтрүүлэх нь тийм ч амар биш байна.
 - Ийнхүү амжилттай байхын тулд дараах хэдэн зүйлс нь маш чухал байна. Үүнд:
 - Оюутны зээлийн хөтөлбөрийг сурталчилаж, хамрагдаж болох сургууль, оюутнуудын дунд өргөнөр таниулахын тулд маш сайн боловсруулсан мэдээллийн болон маркетингийн стратеги,
 - Ямарваа нэгэн татаасын хэлбэрийн тусламжийг хамгийн хэрэгцээтэй (чадварлаг ба ахуйн хувьд хэрэгцээтэй) байгаа оюутнуудад чиглүүлэх тийм ил тод шалгуур үзүүлэлт,
 - Зээл, буцалтгүй тусламжид хамрагдаж буй оюутнуудын сурлагын амжилтийг нарийн шалгах, хянах механизм,
 - СТС-гийн урт хугацааны санхүүгийн тогтвортой ажиллагааг хангах зорилго бүхий нарийвчилан боловсруулсан зээлийн хүү болон татаасын бодлого,
 - Зээлийг эргэн төлүүлэх үр ашигтай тогтолцоо, ялангуяа төлөгдөхгүй байгаа зээлийг багасгах зорилго бүхий хууль, эрх зүйн орчин,
 - Бүрэн компьютержсэн удирдлагын мэдээллийн систем дээр суурилсан бүхий л чухал үйл ажиллагаа (оюутныг үнэлэх, шалгаруулах, сурлагыг хянах, зээл эргэн төлүүлэх ба санхүүгийн удирдлага)-ны үр ашигтай байгууллагын удирдлага,
 - Тогтвортой удирдлагын баг.¹
 - Энэхүү тайланд оюутны сургалтын туслалцааны хөтөлбөрийн үр ашиг, эрх тэгш байдал болон үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн бодлогын асуудлуудыг шийдвэрлэх зорилго бүхий бодлогын өөрчлөлт шинэчлэлтийн хувилбаруудыг санал болгоно. Шинэчлэгдэж өрчлөгдсөн СТС нь төрд өрийн нийгэм, эдийн засгийн бодлогын зорилтуудаа биелүүлэхийн тулд илүү оновчтой, сайн механизмыг бүрдүүлж өгнө.
 - Энэхүү санал болгож буй өөрчлөлтийн хамгийн чухал зарчим бол Монголын сургалтын төрийн сангийн хөтөлбөрүүд нь сурах чадвартай боловч ядуу оюутнуудад чиглэгдэж санхүүгийн дэмжлэг үзүүлж байх ёстой. Ямарваа нэгэн шинэчлэлт нь цогц байх ёстой.
 - Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааг үлэмж хэмжээгээр сайжруулахын тулд бодлогын болон үйл ажиллагааны шинэчлэлтийг хоёуланг нь хэрэгжүүлэх ёстой. Гэхдээ өнөөгийн бодлогын хэрэгжилтийг хангахгүйгээр (зээлийн эргэн төлөлт болон хүүг тооцох механизм) ямарваа нэгэн ахиц, өөрчлөлт гарах боломжгүй.
 - Бүлэг 7-д дурьдсан СТС-гийн хөтөлбөрийг сайжруулах санал болгож буй бодлогын өөрчлөлтүүдийг дор дурьдав:
 - СТС-гийн чиглэлийг ядуу боловч сурах чадвартай оюутнуудыг дэмжих тал руу эргүүлэн оруулах;
 - ТАХ-д үзүүлдэг төрийн санхүүжилтийг болих буюу хязгаарлах;
 - СТС-гийн хэв загварыг хялбаршуулах шаардлагатай;

¹ Салми, Жамил (2003) *Оюутны зээлийн олон улсын Хандлага: Дэлхийн Банкны Туршлага*, Дэлхийн Банк, Вашингтон хот, х 14.

- Зээлийн хүүг тогтоох механизмыг үлэмж сайжруулах шаардлагатай;
 - Оюутны зээлийн эргэн төлөлтийн механизмыг сайжруулах;
 - СТС-гийн санхүүгийн туслалцааг үргэлжлүүлэх нэг шалгуур болох сургалтын амжилтыг хангах үзүүлэлтийг эргүүлэн мөрдөх шаардлагатай;
 - СТС-гийн хамрагдах хүмүүс чиглэх явдлыг сайжруулах хэрэгтэй;
 - СТС-гийн хүрээнд хамрагдаж буй эмзэг бүлгийнхэнд үзүүлж буй санхүүгийн тусламжийн хүрэлцээг эргэн харах ёстой.
- Үйл ажиллагаатай холбоотой санал болгож буй өөрчлөлтүүдийг дараах 5 ангилалд хуваасан. Үүнд СТС-гийн хамрах хүрээг сайжруулахад зорисон, эрх тэгш байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн, санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулахад чиглэсэн, СТС-гийн удирдлагыг илүү стратегийн арга барилтай болгоход зорисон болон хүний нөц, материаллаг баазыг дээшлүүлэхэд чиглэсэн зэрэг багтана.
 - Тайлан нь Бүлэг 8-д дурьдсан доорх үйл ажиллагааны шинэчлэлийг санал болгож байна:
 - Судалгаа, шинжилгээний чадавхийг буй болгож, нэгдсэн мэдээллийн баазыг бий болгох;
 - Зээл, буцалтгүй тусламжийн ангилал болон ангилалын тоог оновчтой болгох;
 - Хөдөө, орон нутагт СТС-г сурталчлах маркетингийн стратегийг боловсруулах;
 - Оюутны сэтгэл ханамжийг судалгааг байнга хийж байх;
 - Илүү үр ашигтай чиглүүлэх механизмыг нэвтрүүлэх;
 - Өргөдөл гаргах үйл явцыг стандартжуулах, давхардлыг арилгах;
 - Оюутны гомдлыг барагдуулах үйл явцыг оновчтой болгох;
 - Оюутныг хянах механизмыг нэвтрүүлэх;
 - Оюутнуудын зээлээ эрт төлөх явдлыг хангах зорилгоор хүүг тогтоох, тооцох механизмыг эргэн харах;
 - Зээлийн эргэн төлөлтийн хэмжээг эргэн харж, төлүүлэх журмыг чангатгах;
 - Шинэ УМС-ийг буй болгох;
 - СТС-гийн үйл ажиллагааны талаар бизнес төлөвлөгөө боловсруулж тогтмол тайлагнаж байх;
 - Бүтэц болон ажилчдын ур чадварыг уялдуулах;
 - Бодлогын болон үйл ажиллагааны үүрэг хариуцлагыг тодотгох;
 - Үйл ажиллагааны журмыг хялбаршуулах.

Гарчиг

Хураангуй

1. Оршил	7
2. Аргачлал	8
3. Тайлангийн бүтэц	9
4. Монгол улсын боловсролын тогтолцооны тойм	10
4.1. Их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан зээлийн тогтолцоо	10
4.2. Ерөнхий мэдээлэл.....	17
4.2.1. Хүн амын өсөлт	17
4.2.2. Ядуурал ба орлогын түвшин.....	18
4.2.3. Ажилгүйдэл.....	18
4.2.4. Сургуулийн Тогтолцоо	18
5. Хөтөлбөрийн зорилтууд ба шийдлийн үзүүлэлтүүд	20
5.1. Сургалтын төрийн сангийн зорилтууд	20
5.2. Шийдлийн үзүүлэлтүүд	20
5.3. Сургалтын зээл, буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн зохион байгуулалт	24
5.3.1. Оюутны тоог урьдчилан төсөлөх	24
5.3.2. Сургалтын төрийн сангийн санхүүжилтэд хамрагдах хүсэлт гаргах	24
5.3.3. Шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг тодорхойлох	25
5.3.4. Өргөдлийг баталгаажуулах	25
5.3.5. Сургуулиудад санхүүжилтыг шилжүүлэх.....	25
5.3.6. Гэрээг зохицуулах	26
5.4. СТС-гийн бүтэц зохион байгуулалт.....	26
6. Сургалтын төрийн сангийн загварын сул талууд	28
6.1. Бодлогын шийдлийн сул талууд.....	28
6.1.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд өргөжилт	28
6.1.2. Хөтөлбөрийн ярвигтай байдал.....	30
6.1.3. Зээлийн хүүг тогтоох.....	33
6.1.4. Эргэн төлөх механизм	34
6.1.5. Чиглэх Механизм	36
6.1.6. Санхүүжилтийн хүрэлцээ.....	37
6.2. Үйл ажиллагааны загварын сул талууд	40
6.2.1. Үйл ажиллагааны журам.....	40
6.2.2. Хөтөлбөрийг сурталчлан таниулах нь	40
6.2.3. Зээл тусламж хүртэгчийн сэтгэл ханамжийн түвшинг хэмжих.....	41
6.2.4. Нэн тэргүүнд зээл тусламж хүртэх оюутнуудын тодорхойлох нь	41
6.2.5. Өргөдлийн шийдвэрлэх хугацаа	42
6.2.6. Суралцагчдын Сурлагын амжилтыг хянах, их, дээд сургуулиудыг сонгох Удирдлагын Мэдээллийн систем (УМС)	42
6.2.7. Зээлийг эргэн төлүүлэх механизм	43
6.2.8. Хяналт ба Тайлан	44
6.2.9. Захиргааны үр ашиг	44
6.2.10. Аудитын үйл ажиллагаа.....	45
6.2.11. Бүтэц, зохион байгуулалт	45
7. Сургалтын төрийн сангийн тогтвортой ирээдүйг бүрдүүлэх: Санал болгож буй бодлогын шинэчлэлтүүд	46
7.1. Сургалтын төрийн сангийн зорилго бол ядуу боловч сурах чадвартай оюутнуудыг дэмжихэд чиглэгдэх ёстой	47
7.2. Сургалтын сангаас төрийн албан хаагчийн хүүхдэд олгодог санхүүжилтийг зогсоох буюу багасгах.....	47
7.3. Сургалтын төрийн сангийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг хэв загварыг хялбаршуулах.....	48
7.4. Сургалтын зээлийн хүүг тооцох арга хэлбэр үлэмж сайжруулах.....	48
7.5. Сургалтын зээлийн эргэн төлөлтийн механизмыг үлэмж сайжруулах	50
7.6. СТС-гийн тусламжийн хөтөлбөрт үргэлжлүүлэн хамрагдахын тулд сурлагын амжилтийг эргэн шалгуур болгон мөрдөх	54
7.7. СТС-гийн тусламжийг зөв чиглүүлэх явдлыг сайжруулах	54
7.8. Эмзэг бүлэгт үзүүлж буй тусламжийн хүрэлцээг эргэн харах	55

8.	Үйл ажиллагааны загварын шинэчлэл.....	57
8.1.	Хамралт - буюу санхүүгийн тусламжийн хөтөлбөрийг зээл тусламж авах эрхтэй оюутнуудад таниулах.....	58
8.1.1.	Судалгааны чадварыг дээшлүүлж, нэгдсэн мэдээллийн сан байгуулах	58
8.1.2.	Зээл тусламжийн төрлүүдийг оновчтой болгох.....	59
8.1.3.	Хөтөлбөрийг хөдөө орон нутагт хэрэгжүүлэхэд маркетингийн стратегийг ашиглах	59
8.1.4.	Оюутны сэтгэл ханамжийг үнэлж дүгнэх судалгаа тогтмол явуулах.....	60
8.2.	Шударга зарчим – Хэрэгцээтэй оюутнуудад хүрч ажиллах.....	60
8.2.1.	Илүү үр дүнтэй механизм нэвтрүүлэх	60
8.2.2.	Өргөдөл шийдвэрлэх процессийг стандартчилж, давхардсан үүргүүдийг хасах	60
8.2.3.	Оюутны санал гомдолыг шийдвэрлэх процессийг нэг хэвд оруулах	61
8.3.	Тогтвортой үйл байдал: Оюутнуудаар зээлийг нь хугацаанд нь төлүүлэх.....	61
8.3.1.	Оюутнуудыг хянах, түүнийг хэрэгжүүлэх механизм.....	61
8.3.2.	Оюутнуудаар зээлийг нь түргэн төлүүлэхийн тулд зээлийн хүүг тогтоох механизмыг сайжруулах	62
8.3.3.	Эргэн төлөлтийн шалгуурыг сайжруулах, албадан төлүүлэх горимыг чангатгах.....	62
8.3.4.	Удирдлагын мэдээллийн системийг шинээр хөгжүүлэх	63
8.4.	Стратегийн удирдлагын хандлагыг нэвтрүүлэх	63
8.4.1.	Бизнес төлөвлөгөө зохиох, сургалтын төрийн сангийн үйл ажиллагааг тогтмол тайлагнах.....	64
8.4.2.	Бүтэц, зохион байгуулалт болон ажиллагчдын чадавхийг уялдуулах	64
8.4.3.	Бодлогын болон үйл ажиллагааны үүргийн хоорондын хариуцлагыг тодруулах.....	65
8.4.4.	Үйл ажиллагааны журмыг хялбаршуулах.....	66
8.5.	СТС-гийн тогтвортой ирээдүйг бий болгоход хөрөнгө оруулалт хийх	67
9.	Дүгнэлт	68

Ашигласан материал

Хавсралт:

- 1. Сургалтын төрийн санг сайжруулах техник тусалцааны ажил үүргийн хуваарь**
- 2. Уулзсан хүмүүсийн жагсаалт**
- 3. Мониторингийн үзүүлэлтүүд**
- 4. Сургалтын төрийн сангийн сайжруулсан журам**
- 5. Сургалтын төрийн сангийн бүтэц, зохион байгуулалт**
- 6. Сургалтын төрийн сангийн нэг хуудас стратеги бүдүүвч**

1. Оршил

1. 1990 оны эхэн үеэс хойш Монголын дээд боловсролын салбарт нилээд томоохон хэмжээний шинэчлэлт өөрчлөлт хийгдсэн. Сургалтын төлбөрийн тогтолцоог нэвтрүүлж, оюутнуудад зориулагдсан зээл, тусламжийн хөтөлбөр бий болгосон, дээд боловсролын салбарт хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд үйл ажиллагаагаа явуулах бололцоог нээсэн гэх мэт шинэ өөрчлөлтүүд нь мэргэжлийн боловсролын тогтолцоог үлэмж хэмжээгээр шинэчилсэн. Энэ үеэс эхлэн их, дээд сургуулиудын тоо болон их, дээд сургуулиудад суралцагчдын тоо мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн.

2. Монголын их, дээд сургуульд суралцагсадын тоо ихээр нэмэгдэж, 1990-ээс 2002 оны хооронд 33,000-гаас 100,000 хүртэл өсч гурав дахин нэмэгдсэн байна. Эдгээр нь их, дээд сургуулийг төлбөртэй болгосноос үл хамааран гарсан өөрчлөлтүүд юм. Малчин ба бага орлоготой өрхийн хүүхдүүд ч мөн дээд боловсролын төвшинд хамрагдах явдал нэмэгджээ. Үүний зэрэгцээ, Монголд дээд боловсролын байгууллагуудыг тоо олширч, 2004 оны байдлаар 185-д хүрсэн байна.

3. Сургалтын төрийн сан (СТС) нь оюутны санхүүгийн тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бөгөөд буцаан төлөгдөх ба буцаан төлөгдөхгүй олон төрлийн зээл тусламжийг олгодог. Энэ нь дээд боловсролын салбарын өсөлтийг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн нь эргэлзээгүй юм. Зөвхөн 2004 он гэхэд Сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид 40,000 гаруй оюутан сурагчид хамрагджээ. Эдгээр амжилтаас гадна СТС зарим бодлого, үйл ажиллагааны шийдлийн сул талуудаас болж нилээд бэрхшээлтэй учирч байгаа бөгөөд эдгээр нь уг хөтөлбөрийн санхүүгийн тогтвортой байдал, хөтөлбөрийн зорилго, зорилтуудын хэрэгжилтэд сөргөр нөлөлж байна.

4. Тайлан нь СТС-гийн хүрээнд олгогдсон зээл, буцалтгүй тусламжийн хөтөлбөрийг түүхэн хөгжлийнх нь хувьд тоймлон дүн шинжилгээ хийлээ. Бодлогын болон үйл ажиллагааны явцын зарим нэг дутагдалтай талуудын талаар тайлбарлаж, уг хөтөлбөрийн тогтвортой, үр ашигтай байдлыг хангах зарим шинэчлэлийн хувилбаруудыг тодорхойлсон.

5. Энэхүү тайланг Монголын улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам (БСШУЯ) болон Дэлхийн банкинд зориулан боловсруулав.

2. Аргачлал

6. Энэхүү төсөлд шаардагдах тоо баримт, мэдээллийг Брайн Иигийн хоёр удаа, Норман Ларокийн нэг удаагийн Монголд ирж ажилласаны үр дүнд цуглуулсан болно. Брайн Ии нь 2004 оны 3 сарын 8-наас 20-н хүртэл, 2004 оны 4 сарын 19-нөөс 24-н хүртэл хоёр удаа Монголд ирж ажилласан. Норман Лароке 2004 оны 4 сарын 19-өөс 24 хүртэл Монголд ирж ажилласан.

7. Судалгааны ажлын хүрээнд эдгээр зөвлөхүүд нь Засгийн газрын холбогдох хүмүүс болон Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк зэрэг олон улсын байгууллагуудын төлөлөгчидтэй уулзсан (Нэрсийн жагсаалтыг Хавсралт 2-оос үзнэ үү).

8. Түүнчлэн, зөвлөхүүд нь судалгааны ажлын хүрээнд Монголын дээд боловсрол, сургалтын зээл, тусламжийн хөтөлбөрийн талаар хэвлэгдсэн олон тооны тайлан, материалууд зэрэг нэмэлт эх сурвалжуудыг судалж үзсэн болно.

3. Тайлангийн бүтэц

9. Энэхүү тайланг дараах бүтэцтэйгээр боловсруулав:

- Хэсэг 4 -т Монголын боловсролын салбарын тойм;
- Хэсэгт 5-д СТС-гаас үзүүлдэг санхүүгийн тусламжийн хөтөлбөрийн зорилтууд, тэдгээрийн бүтэц шийдлийн тойм;
- Хэсэг 6-д сургалтын төрийн сангийн үйл ажиллагаа болон хөтөлбөрийн бүтэцэд оршиж буй сул талууд, тэдгээрийн хөтөлбөрийн хамралт, тэгш байдал болон санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөлөл;
- Хэсэг 7 ба 8-д оюутнуудад зориулсан санхүүгийн тусламжийн хөтөлбөрийн бодлогын үр дүнг сайжруулах, мөн захиргааны үр ашиг, байгууллагын чадавхи болон үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилго бүхий бодлогын болон үйл ажиллагааны төрөл бүрийн өөрчлөлт шинэчлэлтүүд;
- Хэсэг 9-д тайлангийн товч дүгнэлт.

10. Хавсралт 1-д зөвлөхүүдийн ажил, үүргийн хуваарь, Хавсралт 2-т 2004 оны 3-р сараас 4-р сар хүртэлх хугацаанд уулзсан хүмүүсийн жагсаалт, Хавсралт 3-д үйл ажиллагааны зарим боломжит шалгуур үзүүлэлтүүд, Хавсралт 4-т СТС-ийн үйл ажиллагааны хурмын сайжруулсан хувилбарын загвар, Хавсралт 5-т СТС-ийн бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч, Хавсралт 6-т СТС-ийн зээл, буцалгүй тусламжийн хөтөлбөрийн нэг хуудсанд багтаасан стратегийг тус тус үзүүлэв.

4. Монгол улсын боловсролын тогтолцооны тойм

4.1. Их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан зээлийн тогтолцоо

1990 оноос өмнөх үе

11. Хятадын хараанд хэдэн зуун жил дарлагдсаны дараа Монгол улс ЗХУ-ын тусламжтайгаар тусгаар тогтнолоо олсон. 1924 онд социалист дэглэмтэй БНМАУ байгуулагдах хүртэл үндсэн хуульт тогтолцоо байсангүй. Хэдийгээр тусгаар улс хэвээр байсан боловч 1990-ээд оны эхээр ЗХУ задран унах хүртэл улс төр, эдийн засгийн хувьд ЗХУ-тай нягт холбоотой байжээ. 1986-1989 оны хооронд ЗХУ-аас ДНБ-ий 32%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө орж ирж байсан бөгөөд үүний дотор их, дээд сургуулиудад зориулагдсан ном, шинжлэх ухааны багаж, хэрэгсэлүүд багтаж байжээ².

12. МУИС нь 1942 онд Монголын анхны дээд боловсролын байгууллага болон сууриа тавьжээ. Дахин 4 дээд сургууль 1957, 1960 онуудад тус тус байгуулагдсан нь МУИС-иас салж биеэ даасан, мэргэжлийн чиглэлтэй сургуулиуд байсан ажээ. Социалист системийн үед эдгээр сургуулиуд нь үндсэндээ улсаас санхүүждэг, оюутнуудыг үнэ төлбөргүй сургадаг байжээ. Бүгд их, дээд сургуульд суралцах эрхтэй байсан бөгөөд суралцагчид амьжиргаа болон хичээлийн хэрэгсэлд зориулж улсаас стипенд авах боломжтой байсан байна.

13. Боловсролын систем нь төвлөрсөн төлөвлөгөөтэй, хяналттай байсан. Анх байгуулагдсан³ өдрөс нь эхлээд л Засгийн газар их, дээд сургуулиудын бодлого боловсруулах, төлөвлөх ба хөгжлийн явцад оролцож ирсэн. Боловсролын системд ЗХУ-ын нөлө хүчтэй байсан бөгөөд ЗХУ болон Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хорооноос их хэмжээний санхүүжилт авдаг байсан. Зөвхөн боловсролын тогтолцоо л гэхэд ЗХУ-ын дэмжлэгт суурилоод зогсохгүй, уг тогтолцоо өрө социалист загвартай байсан. Жишээ нь төгсөгчдийг улсад ажиллах хүч шаардлагатай байгаа газарт нь хуваарилдаг байжээ. Бичиг үсэг тайлагдлын өндөр төвшинд хүрсэн (90%) нь бараг бүх малчин өрхөд хүрч ажилладаг байсан тухайн үеийн боловсролын салбарын хүчтэй зохицуулалтын үр дүн юм.

1990 он

14. ЗХУ задран унаснаас хойш Монголын Засгийн газар төсвийн зарцуулалтаа их хэмжээгээр багасгах шаардлагатай болсон. 1990 онд боловсролд зарцуулах санхүүжилтийн хэмжээ нь ДНБ-ний 14%-тай тэнцэж байсан бол 1993 онд 3,5% болтлоо буурсан ба энэ санхүүжилтийн ихэнх нь ерөнхий боловсролын салбарт зарцуулагдаж байсан. Энэ үзүүлэлт нь 1995-1999 оны хооронд тогтворжиж ДНБ-ий 5,5%-д хүрсэн ба 2000 онд 7% болсон. Энэ тоо тогтвортой өсч байгаа бөгөөд 2004 онд ДНБ-ий 8,5%-ийг боловсролын салбарт зарцуулахаар төсөвлөжээ. Ерөнхийдө боловсролын салбарт зарцуулдаг төсвийн хэмжээ буурай орнуудад 2,8%, хөгжиж буй орнуудад 4,1%, өндөр хөгжилтэй орнуудад 5,3% байдаг⁴ байна. Хувьчлал болон төсвийн хөрөнгө дэд бүтцэд дахин хуваарилах зорилгоор Монгол улсын Засгаас нийгмийн салбарт зарцуулдаг төсвийн зардлыг бууруулах шаардлага нэмэгдэж байна. Боловсролын салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн үед нэмэгдэж байна. Үүний нилээд хувь нь Азийн Хөгжлийн Банкны зээлээр санхүүжилтээр хэрэгжиж буй “Боловсролын Салбарын Хөгжлийн Хөтөлбөр”-ийн⁵ хүрээнд хийгдэж байна.


² Вайдман, Жон (1995) Гуравдагч Орнуудын Дээд Боловсролын Системийн Санхүүгийн Асуудал: Кен ба Монголын жишээ, Боловсролын бодлогын шинжилгээний архив, 3 дугаар дэвтэр, Дугаар 5, 1995 оны 2 сарын 24, х. 2.

³ Алтанцэцэг, Содномцэрэн (2002) Монгол дахь Төрийн өмчийн Их Дээд Сургуулиудын Санхүү: Бэрхшээл ба Боломжууд, МУИС, Нээлтэй Нийгэмлэгийн Сан, х. 7.

⁴ ЮНЕСКО (1995), *ЮНЕСКО Статистикийн эмхэтгэл 1995*, ЮНЕСКО хэвлэлийн газар, Парис.

⁵ Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яам (1999), *Боловсролын Салбарын Стратеги 2000-2005*, Монгол улсын Засгийн газар, Улаанбаатар, х. 16.

Зураг 1: Боловсролын салбарт зарцуулж Монголын ДНБ-ний ба Улсын Төсвийн буй хувь, Монгол, 1990-2004



Эх сурвалж: БСШУЯ

1991 он

15. 1991 оноос хойш Монгол Улсын Боловсролын Хууль батлагдсантай холбогдон их, дээд сургуулиуд бие даан үйл ажиллагаагаа явуулах хууль эрх зүйн үндэс тавигдсан. Одоо их, дээд сургуулиуд өрсө бие даан дотоод бүтцээ тодорхойлох, төлбөр санхүүгээ тооцох, элсэлт авах, сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаа зохицуулдаг болсон. Гэхдээ Засгийн газраас элсэлт ба төгсөлт дээр зохицуулалт хийсэн хэвээр байна. Хувийн их, дээд сургуулиуд олноор бий болж, улс орон даяар хурдан тархсан.

16. 2002-2003 оны хичээлийн жилд, Монгол улсад 185 их, дээд сургуулиуд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс 42 нь төрийн өмчийн, 136 нь хувийн их, дээд сургуулиуд байгаа бөгөөд хувийн сургуульд 31000 оюутан (нийт оюутнуудын 32%) суралцаж байна. Үлдсэн 7 нь гадаадын их, дээд сургуулиудын салбарууд юм. Хувийн боловсролын байгууллага нь сургалтын үйл ажиллагаа явуулахын тулд БСШУЯ-наас зөвшөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлдэг байна.

1992 он

17. Засгийн газраас Мэргэжлийн Сургалтын Байгууллагуудыг Санхүүжүүлэх Хуулийг баталж, боловсролын байгууллагуудын төлбөрийн төвшинг тогтоосон. Үүний дагуу, сургалтын төлбөр, багш ажилчдын цалингийн доод төвшинг тогтоож, 1993 оноос төрийн өмчийн бүх их, дээд сургуулиуд түүнийг дагаж мөрдөж эхэлсэн. Засгийн газраас үзүүлдэг дэмжлэг тусалцаа нь сургуулиудын цахилгаан, дулааны зардлыг л дөнгөж нөхдөг учир төрийн өмчийн ба хувийн сургуулиудын сургалтын төлбөр бараг л адил хэмжээтэй байдаг. Уг хуульд төвлөрсөн төсвөс санхүүжүүлэх тогтмол зардлыг тусгасан хэдий боловч сүүлийн жилүүдэд Засгийн газраас түүнийг санхүүжүүлэхэд хүндрэлтэй байгаа юм. Түүнээс гадна “Төрийн өмчийн мэргэжлийн сургалтын байгууллагуудыг санхүүжүүлэх тухай” Засгийн газрын 107-р тогтоолын дагуу СТС байгуулагдаж, одоогийн сургалтын тусламжийн хөтөлбөрийн үндэсийг бий болгосон юм. СТС нь 1993 онд байгуулагдсан бөгөөд хуулийн дагуу дараах үүрэгтэйгээр ажиллаж байна:

- Засгийн газрын гэрээгээр (холбогдох яамдын зөвшөрлийн дагуу хуваарилагдсан байгууллагад ажиллахаар) суралцаж байгаа суралцагчдын сургалтын төлбөр;
- Санхүүгийн гачаалалттай оюутнуудад стипенд;
- Онцгой авъяастай оюутнуудын стипенд зэргийг хариуцна.

18. Хоёр улсын гэрээгээр суралцаж буй гадаадын оюутнуудын стипенд бий болгосон.

1993 он

19. 1990-ээд оны эхээр гадны санхүүжилт зогссоны улмаас боловсролын салбарын чанар, хамрах хүрээ доройтож, энэ нь зах зээлийн эдийн засгийн үед шаардлагатай хүний нөцийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээтэй давхцсан. Төсвийн хязгаарлагдмал байдлаас болж Засгийн газраас оюутнуудад олгодог байсан стипенд зогссон. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам (БСШУЯ) нь боловсролын салбарын гол асуудлуудыг судалж, боловсролын хөгжил ба шинэчлэлийн 6 чухал хүрээг тодорхойлсоны дотор дээд боловсролын салбарт шинэчлэлт өөрчлөлт хийх шаардлагатайг онцолж тэмдэглэсэн.

1994 он

20. Боловсролын салбарын тойм судалгаа болон Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр “Монголын Хүний Нөцийн Хөгжил ба Боловсролын Шинэчлэл Төсөл-Мастер Төлөвлөгөө”-г боловсруулсан. Түүний үндсэн дээр боловсролын дэд салбар бүрийг онцлон анхаарч, хөгжүүлэх асуудлын хүрээг тодорхойлсон. Мастер Төлөвлөгөөнд хандивлагчдын хөрөнгийг хуваарилах ерөнхий хүрээг тодорхойлсон.

1995 он

21. Мастер Төлөвлөгөөг үндэслэн боловсролын багц хууль (1995 оны Дээд Боловсролын Хуулийг оролцуулан) болон боловсролын салбарыг бүхэлд хамарсан хэд хэдэн тогтоол, шийдвэрүүдийг баталсан. БСШУЯ-ны гол зорилго нь эрсдэлийг хувийн секторт шилжүүлэх, их, дээд сургууль, коллежүүдийн санхүүгийн алдагдалыг багасгах, дээд боловсрол эзэмших боломжийг⁶ дээшлүүлэх зэрэг асуудлуудад чиглэгдэж байсан юм. Дээд Боловсролын Хуулиар их, дээд боловсролын сургалт явуулах, цол зэрэг олгох (Бакалавр, Магистр ба Доктор) чадвартай байгууллагууд зохих хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах эрхтэй болсон. Уг хуулиар бүх их, дээд сургуулиуд кредит цагийн системийг нэвтрүүлэх шаардлагатай болсон бөгөөд сургалтын хөтөлбөрийн дагуу эзэмших ёстой кредитын доод хязгаарыг тогтоосон. Мөн 1998 онд Дээд Боловсролын Магадлан Итгэмлэх Зөвлөлийг байгуулах үндэсийг тавьсан.

22. СТС-ын үйл ажиллагааг зохицуулах, зээл, тусламж үзүүлэх үйл ажиллагааг хуульчилсан Засгийн газрын 194-р тогтоол (Мэргэжлийн сургуульд суралцагчдад зээл, буцалтгүй тусламж олгох тухай) батлагдсан. Үүний дагуу 4 төрлийн ангиллалд багтсан суралцагчид төрөс сургалтын төлбөрийн зээл авах эрхтэй. Үүнд:

- Амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн 1 хүүхэд;
- өрхийн тэргүүн нь хөдөөлмөрийн чадвараа алдсан өрхийн 1 хүүхэд;
- Эцэг эх нь хоёулаа тэтгэвэрт гарсан бага орлоготой өрхийн 2-оос илүүгүй хүүхэд;
- Хагас өнчин хүүхэд.

23. Уг сан өнчин ба тахир дутуу суралцагчдад тусламж олгодог.

1996 он

24. 1990-ээд оны эдийн засгийн хямралын үеэр Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) олон олон нийтийн дэмжлэгийг алдаж, 1996 оны бүх ард түмний сонгуулиар Ардчилсан Холбоо Эвсэл (АХЭ) ялалт байгуулсан. Засгийн газрын энэ өөрчлөлтийн үр дүнд Шинжлэх Ухаан, Боловсролын Яамыг Соёлын Яамтай нэгтгэж одоогийн Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны бүтцийг бий болгосон.

⁶ Алтанцэцэг, Содномцэрэн (2002) Монгол дахь Төрийн өмчийн Их Дээд Сургуулиудын Санхүү: Бэрхшээл ба Боломжууд, МУИС, Нээлтэй Нийгэм Хүрээлэн, х.8.

25. 1994 оны Мастер Төлөвлөгөөний үр дүнг үндэслэн цаашид баримтлах суурь бодлого болон хийгдэх бүтцийн өөрчлөлтүүдийг тодорхойлсон. АХБ-ны санхүүжилт, удирдлагатайгаар хэрэгжих Боловсролын Салбарын Хөгжлийн Хөтөлбөрийг АХБ-ны захирлуудын зөвлөл 1996 онд баталсан. Уг хөтөлбөрт хувьчлал, хувийн их, дээд сургуулиудыг дэмжих зорилтуудыг тусгагдсан. Дараагийн 5 жилд уг хөтөлбөр хэрэгжиж 2001 онд дууссан байна.

1997 он

26. Засгийн газрын 179-тогтоолд (Их, дээд сургууль, коллежид дипломын болон бакалаврын боловсрол эзэмшихээр сурч буй оюутнуудад сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох тухай) зээл, буцалтгүй тусламж авах эрхтэй оюутнуудын шалгуур үзүүлэлтүүдийг өргөтгөж сурлагын өндөр амжилт гаргасан оюутнууд төрөс санхүүгийн дэмжлэг авах эрхтэй болж байна. 1997 оноос хойш их, дээд сургуулиудын үнэлгээний системийг бий болгосон бөгөөд 1998 оноос хойш магадлан итгэмжлэх систем үйлчилж эхэлсэн. Магадлан итгэмжлэл нь их, дээд сургуулиудын сайн дурын үндсэн дээр явагддаг. Магадлан итгэмжлэлийн шалгуур, үзүүлэлтэд тэнцсэн сургуулиуд л төрөс санхүүгийн дэмжлэг авах эрхтэй болох бөгөөд өрөр хэлбэл, магадлан итгэмжлэгдсэн сургуульд элсэн суралцаж буй оюутнууд л зээл, буцалтгүй тусламжид хамрагдах эрхтэй.

1998 он

27. Улс орныг 21-р зууны хөгжилд бэлтгэх зорилгоор АХЭ-ийн Засгийн газар “21-р Зууны Хөгжлийн Хөтөлбөр”-ийг (ЗХХ 21) боловсруулсан. Энэхүү хөтөлбөрт боловсролын салбарын талаар дэвшүүлэн тавьсан бүлэг зорилтуудын ихэнх нь боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн байлаа. Боловсролын хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. 1995 оны Дээд Боловсролын Хуулиар Дээд Боловсролын Магадлан Итгэмжлэх Зөвлөлийг Засгийн газрын агентлаг болгон байгуулсан боловч удалгүй Засгийн газрын бус бие даасан байгууллага болсон. Уг зөвлөлийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа явуулах зорилго нь:

- Их, дээд сургуулиуд, мэргэжлийн болон техникийн сургалтын төвүүдэд чанарын стандарт тогтоох;
- Дээд боловсролын чанар үр ашгийг дээшлүүлэх зоригоор магадлан итгэмжлэх, үнэлгээг тогтоох;
- Их, дээд сургуулиуд, мэргэжлийн болон техникийн сургалтын төвүүд, тэдний сургалтын үйл ажиллагаанд зориулж чанарын менежмент, техникийн тусламж болон зөвлөгө өгөх үйлчилгээ явуулах зэрэг болно.

28. Одоогийн байдлаар төрийн өмчийн бүх сургуулиуд, хувийн 58 сургууль магадлан итгэмжлэлд хамрагдаад байна.

1999 он

29. “21-р Зууны Хөгжлийн Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хэсгийг Дунд Хугацааны Эдийн Засаг, Нийгмийн Хөгжлийн Стратеги (1999-2002), хүний хөгжил болон нийгмийн хамгаалалын стратегийн хүрээнд хэрэгжүүлж цаашид чанартай боловсон хүчин, эрүүл мэндийн үр ашигтай үйлчилгээний тусламжтайгаар Монгол улсын эдийн засгийн өсөлтийг хангах явдал байлаа. Иргэдийн хэрэгцээг хангахуйц боловсролын шинэ тогтолцоог бий болгох шаардлагатай буйг тодорхойлж, түүнийг Засгийн газрын эн тэргүүний чиглэлийн нэг болгон тавьсан. Боловсролын салбарт явагдаж буй шинэчлэлийг түргэтгэх, сургалтын хөтөлбөрийн агуулга, хангамжийг сайжруулахыг чухалчилжээ.

30. АХЭ-ийн Засгийн газар МАХН-ын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байсан нь бүтцийн өөрчлөлт хийх зорилтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байсан. “21-р Зууны Хөгжлийн Хөтөлбөр” ба Дунд Хугацааны Хөгжлийн Стратегийн хэрэгжилт улс төрийн өөрчлөлтийн уршигаар зогссон. 2000 онд, МАХН 72 суудалтайгаар дахин Засгийн эрхэнд гарсан. Ихэнх шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлсэн боловч МАХН 2000-2004 онуудад хэрэгжүүлэх өрийн мөрийн хөтөлбөртө гол анхаарлаа хандуулсан бөгөөд эдгээр нь нийгмийн хамгаалал (ажил эрхлэлт, ядуурал болон анхан шатны боловсрол) баталгаажуулах ба нийгмийн дэг журмыг сахиулах зэрэг рүү чиглэгдсэн байлаа.

Нэг. НИЙГМИЙН БОДЛОГО:

Нийгмийн салбарын гол зорилтууд бол хүний хөгжлийн орчинг бүрдүүлэх, иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах, нийгмийн үйлчилгээг эрх тэгш хүртэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах явдал юм.

1. Хүмүүсийг боловсрол эзэмших ижил боломжоор хангагдах орчныг бий болгох; анхан шатны боловсрол ба бүх төрлийн мэргэжлийн сургалтын тогтолцоог хувь хүний сонирхол, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх; орчин үеийн боловсрол олгох чадвартай тогтолцоог төлөвшүүлэх болно.

- Боловсролын салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
(...)
- Боловсролын салбар дахь хувийн хөрөнгө оруулалтыг дэмжин урамшуулах;
(...)
- Өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургууль, коллежүүдийн салбарыг Монгол улсад үйл ажиллагаагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг тогтвортой ажиллах боломжоор хангах; эдгээр сургуулиудад суралцагчдын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх;
- Дотоодын их, дээд сургууль, коллежүүдэд суралцагч авъяаслаг, чадварлаг оюутнуудыг шагнал урамшуулах асуудлыг дахин шийдвэрлэх;
- Ядуу, малчин өрх, 3 буюу түүнээс дээш хүүхэд нь дотоодын их, дээд сургууль, коллежид зэрэг суралцаж байгаа өрхийн нэг суралцагчид сургалтын тусламж олгох;
- Дотоодын их, дээд сургууль, коллежид суралцагчид олон улсын төвшинтэй дүйцэхүйц сургалтын хэрэгсэл, агуулгаар хангагдаж чадаж байгаа эсэхэд анхаарал тавих, хичээлийн бус цагаар ажил хийж амьдралаа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцаж буй оюутнуудын тоог нэмэгдүүлэх, сүүлийн үеийн мэдээлэл, шинэ технологид хүрэх хаалга болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад хэлүүдийг сурах шаардлагыг тогтоох;
(...)

- *2000-2004 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөс*

2000 он

31. БСШУЯ, Азийн Хөгжлийн Банк ба гадаадын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр Боловсролын Салбарын 2000-2005 онуудын Стратегийг боловсруулсан. Үүнд боловсролын 6 дэд салбарыг (сургуулийн өмнөх буюу цэцэрлэг, Анхан ба дунд шатны сургууль, Техникийн ба мэргэжлийн сургалт, Дээд боловсрол, Шинжлэх ухаан технологи, Албан бус ба зайны сургалт) хамарсан бие даасан 23 стратегиуд багтасан. Дээд боловсролын талаар 3 стратеги дэвшүүлэгдсэн:

- Дээд боловсролын менежмент, санхүүг сайжруулах;
- Чанар үр ашгийг дээшлүүлэх зорилгоор дээд боловсролын шинэчлэлийг түргэтгэх;
- Илүү үр дүнтэй бодлого хүрээг бий болгох.

32. Хэдийгээр эдгээр стратегиуд нь сургалтын зээлтэй шууд холбоогүй ч, стратегийн тайланд одоогийн сургалтын зээл олгох тогтолцооны талаар хэд хэдэн дуталдалыг дурьдаж, дараах саналуудыг илэрхийлжээ.

- СТС-ийн тогтолцоо, бүтцийг сайжруулах;
- Зарим эрх мэдлийг сургуулийн төвшинд шилжүүлсэнээр зээлийн эргэн төлөлтийн баталгааг нэмэгдүүлэх;
- Засгийн газрын зарим хэрэгцээтэй мэргэжлийг дэмжих (багш, компьютерийн сургалт, хууль гэх мэт)
- Зээл тусламжийн тогтолцоог санхүүжүүлэхийн тулд гадны тусламж авах, ялангуяа эдийн засгийн ажиллагаа хязгаарлагдмал⁷ байгаа шилжилтийн үед;

⁷ Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам (1999) *Боловсролын Салбарын Стратеги 2000-2005*, Монгол Улсын Засгийн Газар, Улаанбаатар, х. 35.

33. СТС-гийн зээл олгох тогтолцоог сайжруулах, санхүүжилтэнд хамрагдах нэмэлт шалгууруудын талаар хэд хэдэн Засгийн газрын тогтоол батлагдсан. Засгийн газрын 96-р тогтоолоор хөнгөлөлттэй зээл, тусламж ба шагналын хэлбэрээр суралцахад доорх нөхцлүүдийг харгалзан үзнэ гэж заасан байдаг.

- Сургалтын төлбөрийн зээлд хамрагдах шалгуур үзүүлэлт:
 - ҮСГ-аас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч, тахир дутуу гишүүнтэй өрх болон эцэг эх нь хоёулаа тэтгэвэрт гарсан өрхийн суралцагч;
 - Хагас өнчин бөгөөд ҮСГ-аас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч;
 - 3,5-аас дээш голч дүнтэй бакалавр оюутан;
 - Засгийн газрын гэрээгээр гадаадад сурч байгаа оюутан;
- Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжинд хамрагдах шалгуур үзүүлэлт:
 - Бүтэн өнчин;
 - Асран хамгаалагчгүй;
 - Нэн ядуу өрхийн тахир дутуу оюутан.
- Сургалтын төлбөрийн шагналд хамрагдах шалгуур үзүүлэлт:
 - Олон улсын уралдаан тэмцээн, Олимпиадаас шагнал авсан оюутан;
 - Улсын хэмжээний олимпиадад эхний 3 байр эзэлсэн арван жилийн сургуулийн төгсөх ангийн сурагч;
 - Суралцах хугацаандаа кредит цагийн шаардлагыг бүрэн хангасан, 4 улирал дараалан 3,8-аас дээш голч дүнтэй суралцагч;

34. 2000 оны Засгийн газрын 158-р тогтоолоор магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцагч дор дурьдсан өрхийн 1 оюутныг төрөс санхүүжүүлнэ гэж орсон.

- Малчин өрх (700-аас доош бог малтай);
- Нэн ядуу өрх (ҮСГ-аас тогтоосон бүсийн амьжиргааны баталгаажих доод түвшингийн 60-аас бага хувийн орлоготой);
- 3 ба түүнээс дээш хүүхэд нь их дээд сургуулийн өдрийн ангид зэрэг суралцаж байгаа өрх;

35. Эцэст нь 2000 оны Засгийн газрын 201-р тогтоолоор бүх төрлийн их, дээд сургуульд бакалаврын болон дипломын боловсрол эзэмшихээр суралцаж байгаа төрийн албан хаагчийн 1 хүүхдийн сургалтын төлбөрийг төрөс даана гэж орсон.

2001 он

36. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам ба Санхүү, Эдийн Засгийн Яамны Сайд нарын хамтарсан тушаалаар (2001 оны 310/290-р тушаал) сургалтын зээлд хамрагдагсдын хүрээг өргөжүүлж, яамд, аймаг дүүргийн улсын байгууллагуудад 2 буюу түүнээс олон жил ажилласан хүмүүсийг сургалтын зээл авах эрхтэй болгосон.

2002 он

37. Дээд Боловсролын хуулинд орсон 2002 оны нэмэлт өөрчлөлтийн дагуу их, дээд боловсролын байгууллагуудыг их сургууль, дээд сургууль ба коллеж гэж ангилсан. Коллежууд 3 жилийн дипломын боловсрол эсвэл 4 жилийн бакалаврын зэрэг, дээд сургуулиуд Магистрын зэрэг олгох (жил хагас эсвэл 2 жил), их сургуулиуд эдгээрээс гадна докторын зэрэг (3-5 жил) олгох эрхтэй. Одоогийн байдлаар 7 их сургууль байгаа бөгөөд тэдгээр нь бүгд төрийн өмчийн сургуулиуд юм. 2002 оны 207-р тогтоолоор эдгээр өөрчлөлтэд зохицуулан өмнөх бүх тогтоолуудыг шинэчлэсэн.

38. 2002 оны 207-р тогтоолоор ядуу малчин өрхийн амьжиргааны үзүүлэлтийн 500 бог мал (2000 оны 158-р тогтоол) гэдгийг 700 бог мал болгож нэмэгдүүлсэн. 2003 оны Ядуурлыг Бууруулах Стратегид заагдсан ядуурлын үзүүлэлт болох 100 бог малтай харьцуулахад энэ тоо нилээд өндөр байгаа юм. Зарим хүмүүс 700 бог малтай өрх чинээлэг өрхийн тоонд орно гэж үзэж байна.

39. Мөн сургалтын төлбөрийн зээлээ төлж эхлэх ёстой байсан ч хамаагүй дипломын хуулбарыг төгсөгчдөд төгссөний нь даруй олгоно гэсэн заалт орсон.

2004 он

40. 2004 оны 22-р тогтоолоор Монгол улсын Засгийн газар 2003-2004 оны хичээлийн жилээс өмнө төгсөгч бүх оюутны сургалтын зээлийг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн.


4.2. Ерөнхий мэдээлэл

4.2.1. Хүн амын өсөлт

41. Монгол улсын хүн ам 2003 оны байдлаар 2.7 сая, өсөлтийн хурд 1.42% гэж тооцоологдсон. Ойролцоогоор 30,7% нь 0-14 насныхан эзэлж байгаа бөгөөд дундаж нас 23,5 жил⁸ байна. 2000 онд хүн амын 57% нь хотод амьдарч байсан. Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлтийн хурдац тогтвортой байгаа боловч 14 хүртэлх насныхны хүн амын бүлэгт эзлэх хувийн жин буурсан. 2009 онд 3,03-3,3 сая болж өснө гэсэн тооцоо байгаа бөгөөд 5-14 насныхны нийт хүн амд эзлэх хувь 19-22%-иар буурч, дундаж нас нэмэгдэнэ. Гэхдээ энэ нь залуу хүмүүсийн тоо буурна гэсэн үг биш юм. Энэ насныхан үргэлжлэн өсөх боловч өсөлт нь арай удааширна⁹.

42. Засгийн газраас элсэлтийн тоонд тавьдаг хязгаарлалт багассанаас хойш их, дээд сургуульд элсэгчдийн тоо эрс нэмэгдсэн. 1993 оноос хойш их, дээд сургуульд элсэгчдийн тоо тогтвортой өсч байна. Энэ өсөлт нь 1990 оны эхэнд их, дээд сургуульд элсэгчдийн тоо буурч 1990 онд 33,000 байсан бол 1992 он гэхэд 27,000 болж буурсан. Түүнээс хойш өссөж эхэлсэн. Энэхүү эхний үеийн бууралт нь зах зээлийн чөлөт эдийн засаг, ардчилсан засаглалд шилжсэн шилжилтийн үеийн үр дагавар байсан юм. Энэ нь зах зээлийн шинэ эдийн засагт ямар ажил, мэргэжил хэрэгтэй болох талаар тодорхойгүй байдалтай байсныг харуулж байна. Төрийн өмчийн үйлдвэрийн газрууд хувьчлагдаж, зарим нь хаагдаж, боловсон хүчний төвлөрсөн төлөвлөгөө хийх чадвар буурсан нь Монголчуудын хувд шинэ зүйл байсан. Гэсэн хэдий боловч элсэгчдийн тоо удалгүй хэвийн хэмжээндээ орж, 1992-2001 онд өсч, нийт элсэлтийн хувь холбогдох насныхны өсөлттэй харьцуулахад 10,9-35,2%-иар өссөн.

Зураг 2: Их, дээд сургуульд элсэгчдийн тоо, Монгол, 1990-2004



Эх сурвалж: Алтанцэцэг, Содномцэрэн (2002). Монгол дахь Төрийн өмчийн Их Дээд Сургуулиудын Санхүү: Бэрхшээл ба Боломжууд, МУИС, Нээлтэй Нийгэм Хүрээлэн, www.policy.hu

43. Их, дээд сургуулиудын даац, оюутнуудын санхүүгийн чадвартай холбоотойгоор их, дээд сургуульд суралцагчдын тоо одоогоор хязгаарлагдмал байгаа. Хэрэв СТС-гаас үзүүлдэг санхүүгийн дэмжлэг нэмэгдэх, эсвэл их, дээд сургуулиудийн чадавхи, материаллаг бааз өргөжих тохиолдолд суралцагчдын тоо цаашид хэр хэмжээгээр өсөхийг тооцоолоход бэрх. Боловсролын Салбарын Стратеги 2000-2005 (хуудас 41)-ийн төлөвлөсөн тооноос аль хэдийн давчихаад байгаа ажээ¹⁰.

⁸ Тагнуулын Төв Газар (2003) 'Монгол Улс' Дэлхийн ном, www.cia.gov/cia/publications/factbook.

⁹ Ньюперт, Рикардо (1992) Монголын Хүн Амын өсөлтийн чиг Хандлага, 1989-2019, НҮБ-ын Ази-Номхон Далайн Хүн Амын Сэтгүүл, 7 дэвтэр, №4, х. 61-80.

¹⁰ БСШУЯ (1999) Боловсролын Салбарын Стратеги 2000-2005, Монгол улсын Засгийн газар, Улаанбаатар, х 41.

4.2.2. Ядуурал ба орлогын түвшин

44. 1998 онд хийсэн амьжиргааны түвшний судалгаагаар нийт хүн амын 35,6 хувь нь (хотын 39,4%, хөдөөгийн 32,6%) үндэсний ядуурлын түвшингээс доогуур байна. Ядуурлын түвшингийн мөнгөн хэмжээ бүсээс хамаарч нэг хүнд 19,500-25,300 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

45. Монголд явуулсан судалгаануудаас үзэхэд ядуурал дараахь 5 бүлэг хүмүүсийн дунд илүү их байна. Үүнд:

- Ганц бие, өрх толгойлсон, олон хүүхэдтэй өрх;
- 100-гаас цөн тооны малтай (өрхийн гишүүдийн тоо, бүтцээс хамаарна);
- Ажилгүй;
- Анхан шатны боловсролгүй;
- Эмзэг бүлэг (хөгшин, тахир дутуу буюу хөдөөлмөрийн чадвараа алдсан хүн, тэнэмэл ба өнчин хүүхдүүд¹¹).

4.2.3. Ажилгүйдэл

46. 2003 оны 4-р улирлын байдлаар 33,000 ажилгүйчүүд байна гэсэн статистик мэдээ байна. Энэ тоо нь 2001 оны 4-р улиралд 40,000 байсантай харьцуулахад буурсан үзүүлэлт юм¹². Хүснэгт 1-т үзүүлсэнчилэн ажилгүйдлийн хувь хэмжээ нь боловсролын төвшингөс хамарч янз бүр байгаа бөгөөд ялангуяа, их, дээд сургуульд төгсөгчдийн дунд хамгийн бага байна.

Хүснэгт 1. Боловсролын төвшингээр ажилгүйдлийн хувь хэмжээ

Боловсролын түвшин	Ажилгүйдлийн хувь хэмжээ	
	Улаанбаатар хот (%)	Улсын хэмжээнд (%)
Суурь боловсролгүй	34.9	10.1
Суурь боловсролтой	29.1	8.8
4-8-р анги	31.5	20.8
9-10-р анги	23.7	24.8
Техник, мэргэжлийн боловсрол	19.2	21.5
Дипломын боловсрол	13.3	13.4
Их, дээд сургуулийн боловсрол	8.0	7.8

Эх сурвалж: Ескола ба Батхүү (2003). Хөдөөлмөрийн зах зээл ба Хөдөөлмөр эрхлэлтийн үйлчилгээний судалгаа, х 55.

4.2.4. Сургуулийн Тогтолцоо

47. Дээд боловсролыг дэмжих сургалтын тогтолцоо гурван хэсгээс бүрддэг. Цэцэрлэгийн буюу сургуулийн өмнөх нас, анхан шатны 5 жилийн боловсролын сургууль дүүргэх хүүхдүүдийн сургалт 7 наснаас эхэлдэг. Энэ систем 2002 оны Анхан ба Дунд Шатны Боловсролын Хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгагдсан бөгөөд сургууль элсэх нас 8-аас 7 болон буурч, заавал эзэмших боловсролын хугацаа 10-аас 11 жил болж уртасна. Энэ 2005 оноос хэрэгжиж эхэлнэ. Дараа нь 8-р анги дүүргэх 4 жилийн бүрэн бус дунд боловсрол орно. Бүрэн дунд боловсролын нэмэлт 2 жилийг суралцсаны дараа их дээд сургуульд элсэх боломжтой болно. Дунд боловсролын

¹¹ Монгол Улсын Засгийн Газар (2003), Эдийн Засгийн өсөлтийг Дэмжих, Ядуурлыг Бууруулах Стратеги, Монголын Зөвлөлүүдийн бүлгийн (Монголд Хандивлагч Орнуудын Зөвлөлдөх уулзалт) уулзалт, 11сарын 19-21, х. 24.


¹² Үндэсний Статистикийн газар (2004) Статистикийн сар бүрийн эмхтгэл, Монгол улсын Засгийн газар, Улаанбаатар хот, 3-р сар, х 55.

агуулгыг төрийн өмчийн сургуулиудад үнэ төлбөргүй эзэмшүүлнэ. үндсэн хичээлийн хөтөлбөрөс гадна нэмэлт сургалтанд өрсдийн хүсэлтийн дагуу төлбөр төлж суралцаж болно.

48. Ерөнхийдө бүх хүүхдүүд бага сургуульд элсэн ордог боловч 89% нь л 8-р анги төгсч, 50% нь бүрэн дунд боловсролтой болдог (10-р анги төгсдөг). Уламжлалт мал аж ахуйд эрэгтэй хүүхдүүдийн оролцоо их байдаг учир улсын сургуулийн 64%, хувийн их дээд сургуулийн 76%-д нь эмэгтэй хүүхдүүд сурдаг.

49. Монголын боловсролын тогтолцоог График 3-т харуулав.

Зураг 3: Монголын Боловсролын Тогтолцоо



50. Боловсролын тогтолцоо нь 2 өр төсвөс санхүүждэг: Улсын төвлөрсөн төсөв ба орон нутгийн төсөв. Улсын төвлөрсөн төсөв нь их, дээд боловсролын байгууллагууд, зарим техник мэргэжлийн сургуулиуд, СТС ба төвлөрсөн арга хэмжээнүүдийг санхүүжүүлнэ. Төвлөрсөн арга хэмжээ гэдэгт:

- Дунд сургуулийн ном, сурах бичгийн хэвлэл;
- Хөдөө орон нутгийн оюутнуудын замын зардал;
- Стипенд (амьжиргааны тэтгэлэг);
- Гадаадад сурч буй оюутнуудын тэтгэлэг;
- Байгалийн ба хүмүүнлэгийн шинжлэх ухааны олон улсын уралдаан тэмцээн;
- Эцсийн шалгалтын зардал багтана.

5. Хөтөлбөрийн зорилтууд ба шийдлийн үзүүлэлтүүд

5.1. Сургалтын төрийн сангийн зорилтууд

51. Монголын сургалтын төрийн сангийн тусламжийн хөтөлбөрийн үндсэн зорилго бол оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй оюутнуудад суралцах боломжийг төлбөрийн чадваргүйгээс нь болж хаахгүй байх явдал юм. Зөвлөхүүдийн ажил, үүргийн хуваарьт дурьдсанчилан энэхүү зорилт нь бусад олон орны сургалтын сангийн үндсэн зорилготой нийцэж байна. Өөрөр хэлбэл:

- Дээд боловсролыг өргөжүүлэх;
- Зардал хуваалцах, нөхөн олох;
- Улсын болон сургуульд суралцаж байгаа оюутнуудын санхүүгийн дарамтын багасгах;
- Дээд боловсрол эзэмших боломжийг эрх тэгш хангах;
- Хүний нөцийг нэмэгдүүлэх¹³ зэрэг багтана.

52. Хэсэг 2-т хэлэлцсэн асуудлуудаас оюутны санхүүгийн тусламжийн хөтөлбөр нь дараах 3 ерөнхий бүлгийн оюутнуудад ашиг тустай:

- Санхүүгийн хэрэгцээ шаардлагатай байгаа оюутнууд – бага орлоготой өрхийн буюу боломж хомс оюутнууд (өнчиу, тахир дутуу оюутнууд);
- Амжилттай суралцаж буй авъяаслаг оюутнууд;
- Төрийн албан хаагчийн хүүхдүүд/оюутнууд.

53. Монголын сургалтын төрийн сангийн оюутны санхүүгийн тусламжааны хөтөлбөрийн ерөнхий зорилго нь сайн тодорхойлогдсон боловч эдгээр 3 бүлгийн оюутнуудад үзүүлж буй зээл, буцалтгүй тусламжийн дэд хөтөлбөрүүдийн зорилго нь тодорхой бус бөгөөд баримтжаагүй байна. Ийнхүү зорилго тодорхой бус байсан хэдий ч СТС нь 1993 оноос эхлэн эдгээр бүлэгт багтах оюутнуудыг хамарч дэмжлэг үзүүлж ирсэн байна.

5.2. Шийдлийн үзүүлэлтүүд

54. Ерөнхийд нь аваад үзэхэд СТС-ийн зээл, буцалтгүй тусламжийн 4 үндсэн хэлбэр байна. Үүнд: сургалтын зээл, сургалтын буцалтгүй тусламж, сургалтын тэтгэлэг болон төрөс санхүүждэг хэлбэрүүд багтана. Эдгээрийг хэсэг 4-т дурьдсанаар Засгийн газрын хэд хэдэн тогтоолуудаар хэрэгжүүлж эхэлсэн. Тусламжийн эдгээр хэлбэрүүд нь өр хоорондоо дараах хүчин зүйлсээр ялгагдаж байна. Үүнд:

- Тусламж ядуучууд руу чиглэсэн эсэх;
- Тусламж нь зөвхөн сургалтын төлбөрийг хариуцах уу эсвэл сургалтын төлбөр болон амьдралын өртгийг бас санхүүжүүлэх үү;
- Тусламж нь эргэн төлөгдөх эсэх;
- Тусламжийг үргэлжлүүлэн авахын тулд тухайн оюутан тодорхой үүргийг биелүүлэх ёстой эсэх

¹³ Зидерман, Адриан (2001) *Тайландын Оюутны Зээл, Тогтвортой дэмжиж чадаж байна уу?, Бодлогын судалгаа ба Оюутны Зээлийн Хөтөлбөр*, Азийн цуврал, 1-р дэвтэр, № 1, ЮНЕСКО, Банкок.

Сургалтын төлбөрийн зээл	<ul style="list-style-type: none">• Ядуу/санхүүгийн бололцоо муутай өрхийн суралцагч• Засгийн газрын гэрээгээр суралцагч• Сурлага сайтай оюутан
Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж	<ul style="list-style-type: none">• Нэн ядуу/ санхүүгийн бололцоо муутай өрхийн суралцагч
Сургалтын төлбөрийн шагнал	<ul style="list-style-type: none">• Сурлагын өндөр амжилт гаргасан суралцагч• Нэн ядуу/эмзэг бүлэгийн өрх
State tuition financing	<ul style="list-style-type: none">• ТАХ-ын хүүхэд

55. Сургалтын дэмжлэгийн хэлбэрээс үл хамааран санхүүжилт тухайн оюутны сурдаг их, дээд сургуулийн дансанд шууд төлөгддөг. Эргэн төлөгдөх зээл олгогдож байгаа үед тодорхой хугацаанд төрөс заасан газар (улсын байгууллага)-т ажиллавал зээлээс чөлөлөгдөнө гэх мэт хэдэн тохиолдлоос бусад тохиолдолд уг зээлийг эргэн төлөх шаардалагатай. Зээлийн төлж эхлэх хугацааг тодорхой заагаагүйгээс энэ нь зөвхөн оюутнаас хамаарна. Гэхдээ сургууль төгссөнөс хойш 10 жилийн дотор зээлийн төлж барагдуулах шаардлагатай. Төгссөнөс хойш 7 жилийн дотор хүү тооцдоггүй учир төгссөний дараа зээлийг хугацаанд нь эргэн төлөх хөшүүрэг байхгүй байна.

56. 2002 оны 10-р сар хүртэл оюутнуудын сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн төлөхдө сурлагын тодорхой амжилт гаргахыг шаарддаг байсан. СТС нь хичээлийн улирал бүр их, дээд сургуулиудын сургалтын албадаас ирүүлсэн сурлагын тодорхойлолтыг үндэслэн зээлийг үргэлжлүүлэн олгох эсэхийг шийдвэрлэдэг байсан. Энэ шаардлага СТС-гийн үйл ажиллагаанд хээл хахууль, хуурамч бичиг баримт бүрдүүлэх зэрэг сөрөг үр дагаварыг бий болгож байна гэсэн шалтгааны улмаас хүчингүй болсон. Мөн, ТАХ-аас хүүхдүүд/суралцагчид нь тусламжийг үргэлжлүүлэн авч чадахгүй байна гэсэн гомдол ихээр ирсэн. Одоо, зээл тусламжийг үргэлжлүүлэн олгох гэрээний сунгалтыг их, дээд сургуулиудиа ирүүлсэн тухайн сурагч үргэлжлэн суралцах байгаа гэсэн тодорхойлолтын үндсэн дээр хийдэг болсон.

57. Хүснэгт 2-т Монголын СТС-гийн хүрээнд олгогдож байгаа зээл тусламжийн ерөнхий байдлыг нэгтгэн дүгнэв.

Хүснэгт 3: Сургалтын төрийн сангаас үзүүлдэг зээл, тусламжийн хэлбэрийн хураангуй

Зээл, тусламжийн хэлбэр	Үзүүлдэг тусламж	Шалгуур үзүүлэлт	Ямар зардлыг санхүүжүүлдэг	Эргэн төлөлт	Хүү
Сургалтын төлбөрийн зээл (ЗГ-ын тогтоол 96/2000)	Эргэн төлөгдөх нөхцөлтэй сургалтын төлбөрийн зээл	<ul style="list-style-type: none"> Амьжиргааны доод төвшингөс доогуур орлоготой өрхийн оюутан (ЗГ-ын тогтоол 96/2000) Тахир дутуу гишүүнтэй өрхийн оюутан (ЗГ-ын тогтоол 96/2000) Амьжиргааны доод төвшингөс доогуур орлоготой өрхийн хагас өнчин оюутан (ЗГ-ын тогтоол 96/2000) Эцэг эх хоёулаа тэтгэвэрт өрхийн оюутан (ЗГ-ын тогтоол 96/2000) 3.5 ба түүнээс дээш голч дүнтэй бакалавр, магистр, докторантурт оюутан (ЗГ-ын тогтоол 96/2000) ЗГ-ийн хэлэлцээр, гэрээний дагуу гадаадад суралцагч оюутан (ЗГ-ын тогтоол 96/2000) 	<ul style="list-style-type: none"> Сургалтын төлбөр ЗГ-ын гэрээний дагуу Польш, ОХУ-д суралцагч оюутнуудад амьжиргааны зардал ЗГ-ын гэрээний дагуу гадаадад суралцагч оюутнуудад замын зардлын зээл 	<ul style="list-style-type: none"> Төгссөнөс хойш 10-н жилийн дотор эргэж төлнө Эргэн төлөгдөх тодорхой дүн, эхлэх хугацаа байхгүй. Хагас өнчин оюутанд хичээлийн 1 жилд 150,000 төгрөг эргэн төлөгдөхгүйгээр заасан. Зээлийг нь дараах нөхцөлд тэглэж болно: <ul style="list-style-type: none"> а) Төгссөнөс хойш төрийн албанд 5-дээш жил ажилласан б) Нас барах буюу ажиллах чадвараа 70 хувиас дээш алдах в) Гадаадад сурч байгаа оюутан сурлагын амжилт (75-иас дээг амжилт гаргасан) 	Эхний 6 жил хүү тооцохгүй бөгөөд 7 дахь жилээс арилжааны банкны хүүгээс 0.5 хувиар дээгүүр тооцно.
Өндөр хөгжилтэй оронд магистр, докторантурт суралцагчдад сургалтын төлбөрийн зээл (СЭЗЯ, БСШУЯ-ны хамтарсан тушаал 310/ 290-2001)	Эргэн төлөгдөх нөхцөлтэй сургалтын төлбөрийн зээл	<ul style="list-style-type: none"> Төрийн албанд 2-дээш жил ажилласан ба БСШУЯ-наас зарласан шалгалтанд тэнцсэн. 	<ul style="list-style-type: none"> Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал Замын зардал орохгүй 	<ul style="list-style-type: none"> 5 жил захилгаат газраа ажиллах буюу эргэн төлөх нөхцөлттэй Оюутан эх орондоо эргэж ирээгүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөлөгч нь зээлийг эргэн төлөх ёстой 	Хэрэв захилгаат байгууллагадаа 5-аас доошгүй жил ажиллаагүй тохиолдолд зээлийг авсан өдрөс эхлэн жилийн дундаж инфляцийн төвшингөс 1 хувийн илүү хүүтэйгээр суралцагч буюу итгэмжлэгч нь буцаан төлнө
Гадаадад бакалавр, магистрт сурч буй оюутны сүүлийн 2 жилийн сургалтын төлбөрийн зээл (СЭЗЯ, БСШУЯ-ны хамтарсан тушаал 310/ 290-2001)	Эргэн төлөгдөх нөхцөлтэй сургалтын төлбөрийн зээл	<ul style="list-style-type: none"> Суралцаж буй мэргэжлээрээ сурлагын өндөр амжилт гаргасан ба эх орондоо эргэн ирж ажиллахад бэлэн, дотоодын их, дээд сургуулиас гадаадын их, дээд сургуульд уригдан суралцаж байгаа. 	<ul style="list-style-type: none"> Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал Замын зардал орохгүй 	<ul style="list-style-type: none"> 5 жил захилгаат газраа ажиллах буюу эргэн төлөх нөхцөлттэй Оюутан эх орондоо эргэж ирээгүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөлөгч нь зээлийг эргэн төлөх ёстой 	Хэрэв захилгаат байгууллагадаа 5-аас доошгүй жил ажиллаагүй тохиолдолд зээлийг авсан өдрөс эхлэн жилийн дундаж инфляцийн төвшингөс 1 хувийн илүү хүүтэйгээр суралцагч буюу итгэмжлэгч нь буцаан төлнө

Зээл, тусламжийн хэлбэр	Үзүүлдэг тусламж	Шалгуур үзүүлэлт	Ямар зардлыг санхүүжүүлдэг	Эргэн төлөлт	Хүү
Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж (ЗГ-ын тогтоол 96/2000)	Буцаан үл төлөгдөх нөхцөлтэй буцаалтгүй тусламж	<ul style="list-style-type: none"> Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй өрхийн оюутан Нэн ядуу өрхийн тахир дутуу оюутан 	Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал (сард тогтмол 10,000 төгрөг)	Хэрэв дипломын болон бакалаврын сургалтанд сурч байгаа нөхцөлд буцаан төлөхгүй	Хамааралгүй
Сургалтын төлбөрийн шагнал (ЗГ-ын тогтоол 96/2000)	Буцаан үл төлөгдөх нөхцөлтэй сургалтын төлбөрийн шагнал	<ul style="list-style-type: none"> Олон улсын хэмжээнд зохиогдсон олимпиад, олон улсын дээд зэрэглэлийн уралдаан тэмцээнд шагналт байр эзэлсэн суралцагч (суралцах хугацаанд) ЕБС-ийг төгсөх жилдээ тус улсын хэмжээнд зохигддог олимпиадад эхний 3 байр эзэлсэн суралцагч Их, дээд сургууль, коллежид дараалсан 4 улиралд голч дүнгээрээ 3.8 буюу түүнээс дээш амжилт үзүүлсэн суралцагч (суралцах хугацаанд) Суралцах хугацаандаа зохих кредит цагийг бүрэн биелүүлсэн суралцагч (сэдэвээ хамгаалах хүртэл) 	<ul style="list-style-type: none"> Сургалтын төлбөр Хэрэв улсын хэмжээний арга хэмжээ бол эхний 2 жилийн төлбөр Хэрэв олон улсын хэмжээний арга хэмжээ бол бүхий л суралцах хугацааны төлбөр 	Хамааралгүй	Хамааралгүй
Төрөс санхүүжих (ЗГ-ын тогтоол 158/2000)	Буцаан үл төлөгдөх нөхцөлтэй буцалтгүй тусламж	<ul style="list-style-type: none"> ҮСГ-аас тогтоосон бүсийн амьжиргааны төвшингийн 40 хувиас доогуур орлоготой бөгөөд тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй нэн ядуу (ЗГ-ын тогтоол: 60 хувиар доогуур) Нийт малыг нь богд шилжүүлснээр 200 хүртэл толгой мал бүхий зөвхөн малчин (ЗГ-ын тогтоол 207/2002: 700 хүртэл толгой мал) 3 ба түүнээс дээш хүүхэд нь их сургууль, коллежид зэрэг суралцаж буй өрх 	<ul style="list-style-type: none"> Сургалтын төлбөр 	Хамааралгүй	Хамааралгүй
Төрөс санхүүжих ЗГ-ын тогтоол 201/2000)	Буцаан үл төлөгдөх нөхцөлтэй буцалтгүй тусламж	Төрийн албан хаагчийн нэг хүүхэд	<ul style="list-style-type: none"> Сургалтын төлбөр 	Хамааралгүй	Хамааралгүй

5.3. Сургалтын зээл, буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн зохион байгуулалт

58. Сургалтын төрийн сан нь Засгийн газрын 107-р тогтоолоор сургалтын төлбөрийн зээл, тусламжийг зохицуулах зорилгоор 1992 онд байгуулагдсан. Сургалтын төрийн сангийн зорилго нь мэргэжлийн боловсролын сургалтад зарцуулж буй хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, суралцагчдад төрөс санхүүгийн баталгаат дэмжлэг үзүүлэх, сургалтын чанарыг урамшуулах, хувийн сургуулийг дэмжихэд оршино.

59. Сургалтын төрийн сан нь төрөс жил бүр сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжид зориулж буй төсвийг захиран зарцуулж, сургуулиудад хуваарилахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн, сургалтын төрийн санд хөрөнгө төвлөрүүлэх, зээл, буцалтгүй тусламжийн гэрээг баталгаажуулах, тэдгээрийг шилжүүлэх, буцаан төлүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэв шаардлагатай бол зээлийг төлүүлэхээр шүүхэд хандана.

60. Сургалтын төрийн сан нь анх Засгийн газрын 1992 оны тогтоолоор төрийн өмчийн мэргэжлийн сургуульд суралцаж буй оюутнуудын зээл, зээлийн тэтгэлийг баталгаажуулах зорилгоор зээлийн санг дотроо байгуулсан. Зээлийн хөрөнгийг оюутны тоо, зээл, зээлийн тэтгэлэгийн хэмжээг харгалзан тогтоодог.

61. Сургалтын зээл, буцалтгүй тусламжийг зохицуулахад БСШУЯам болон их, дээд сургууль, коллежууд бас чухал үүрэг гүйцэтгэдэг. БСШУЯам тухайн жил сургалтын төрийн сангийн сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцах оюутны хяналтын тоог тогтоодог. Их, дээд сургууль, коллежиуд нь оюутнуудын өргөдөл хүлээн авах, хянах, урьдчилан баталгаажуулах ба сургалтын төрийн санд хянуулах үүрэгтэй байдаг.

62. Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн үйл ажиллагааг дараах байдлаар хураангуйлан авч үзэж болно.

5.3.1. Оюутны тоог урьдчилан төсөлөх

63. Их, дээд боловсролын байгууллагууд нь сургуульд шинээр элсэх оюутнуудын тоог өрсдө тогтоох эрхтэй боловч төрөс санхүүжилт авах оюутны тоог БСШУ-ын яамнаас эил болгон тогтоодог байна. Энэхүү үйл ажиллагаа нь 3 хэсгээс бүрддэг:

- БСШУЯ болон СЭЗЯ хамтран жил бүрийн 5-р сарын эцэст тухайн жилд сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжаар суралцах оюутны тоог зах зээлийн эрэлт хэрэгцээ болон шаардлагатай мэргэжлийг харгалзан тогтоодог;
- Их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтад дээд оноо авсан оюутнуудад БСШУЯ-наас томилолт өгдөг бөгөөд эдгээр оюутнууд нь санхүүгийн байдлаасаа хамааран сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдах боломжтой болно. Ихэнхдээ эдгээр оюутнууд нь элсэлтийн шалгалтын дүнгээсээ хамааран нийт элсэгчдийн 10 орчим хувийг эзэлдэг. БСШУЯ-ны томилолт авсанаар тухайн оюутан сургалтын төрийн сангийн зээл, тусламжид хамрагдах эрхтэй болдог бөгөөд хэрэв ийм томилолт аваагүй тохиолдолд зээл, тусламжид хамрагдах өргөдөл гаргах эрхгүй байдаг байна;
- Энэхүү томилолтыг үндэслэн тухайн жилд гаргасан өргөдөлүүдийг хянаж үзээд сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж, шагнал гэсэн ангилалаар суралцах мэргэжлийн дагуу оюутны тоо болон санхүүжилтийг хэмжээг гаргадаг. Хяналтын тоог тухайн сургалтын байгууллагын хүчин чадлаас хамааран тогтоодог байна.

5.3.2. Сургалтын төрийн сангийн санхүүжилтэд хамрагдах хүсэлт гаргах

64. Тухайн хичээлийн жилийн эхэнд элсэлтийн шалгалтын дүнгээс хамааран томилолт авсан оюутнууд элссэн сургуульдаа сургалтын төрийн сангийн зээл, тусламжид хамрагдах өргөдөл гаргана. Оюутан буюу итгэмжлэгдсэн төлөлөгч нь хамрагдах ангилалаас хамааран өргөдөл болон дор дурьдсан бусад шаардлагатай материалуудыг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Их, дээд сургууль, коллежид элссэнийг нотлох элсэлтийн төв комиссоос олгосон томилолт, магистрантжр, докторантурт суралцуулах тухай суруулийн шийдвэр, Засгийн газар хоорондын хэлэлцээрээр гадаадын их сургуульд суралцуулах тухай Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;
- Сургалтын төлбөрийн зээл, тусламж хүссэн болон түүнийг буцааж төлөх тухай нотолсон суралцагч эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөлөгчийн гараар бичэн өргөдөл;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Эцэг, эх, асран хамгаалагч нь нас барсан тухай гэрчилгээний хуулбар;
- Зээлийн төлбөрийн хөрөнгийн баталгааны нотариатын гэрчилгээ;
- ҮСГ-аас тогтоосон амьжиргааны төвшингөс доогуур орлоготой нэн ядуу өрх болох тухай тодорхойлолт;
- Суралцагчийн өрхийн гишүүдийн хөдөөлмөрийн чадвараа бүрэн алдсан, тахир дутуу болохыг тогтоосон холбогдох байгууллагын шийдвэр;
- Суралцагчийн тахир дутуу болохыг тогтоосон холбогдох байгууллагын шийдвэр
- Итгэмжлэгдсэн төлөлөгчийн тухай нотариатын гэрчилгээний хуулбар.

5.3.3. Шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг тодорхойлох

65. Их, дээд сургууль, коллеж нь сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдах өргөдлийг хүлээн авч тухайн жилд санхүүжүүлэх хөрөнгийг хуваарилна. 5 гишүүн бүхий комисс зээл, буцалтгүй тусламжид хамрагдах оюутнуудыг ангилалаар нь хуваарилж шийдвэрлэнэ. Энэхүү комисс нь тухайн сургуулийн сургалтын алба, оюутны байгууллага, эцэг эхийн төлөлөл болон нягтлан бодогчоос бүрдэх бөгөөд лютнуудын өргөдөл, бүрдүүлж ирсэн материал зэргийг хянаж хэнийг хамруулах эсэхийг шийднэ. БСШУЯ-наас баталсан хяналтын тоо болон төсвийн хэмжээнд хөрөнгийг хуваарилна.

5.3.4. Өргөдлийг баталгаажуулах

66. Төсөв хөрөнгө хуваарилагдаж, оюутны гэрээ хийгдсэний дараа тухайн их, дээд сургуулийн сургалтын алба оюутан, сургууль ба төрийн сангийн гурвалжилсан гэрээг шинэчлэх, зогсоох зэрэг ажлыг гүйцэтгэнэ. Тухайн оюутны асуудал шийдэгдэхийн өмнө сургууль нь оюутны өргөдөл болон дагалдах тодорхойлолт баримт бичгүүдийг үнэн зөв эсэхийг шалгаж баталгаажуулах үүргийг хүлээнэ. Бүрдүүлсэн материал, тодорхойлолт үнэн зөв, бүрэн гүйцээт байгаа тохиолдолд гурвалжилсан гэрээг байгуулдаг. Сургалтын төлбөрийн зээл олгож байгаа тохиолдолд зээлийн картыг нээж тэмдэглэлүүдийг хийнэ. Энэхүү картыг үндэслэн олгогдсон зээл, түүний төлөлтийг зохион байгуулна..

67. Сургуулиуд холбогдох баримт бичиг, сургалтын алба, оюутны гарын үсэг зурсан гэрээг Сургалтын төрийн санд 10-р сарын 1-ний дотор хүргэнэ. Сургалтын төрийн сан нь тэдгээрийг хянан шалгаж, нотариатаар баталгаажуулан санхүүжилтийг 12-р сарын 1-ний дотор сургуулиудад бүрэн шилжүүлж дуусна.

5.3.5. Сургуулиудад санхүүжилтыг шилжүүлэх

68. Их, дээд сургуулиуд улирал бүр СТС-тай тооцоо хийдэг. Оюутны нэр, зээл тусламжийн төрөл, хугацаа, зээл тусламжийн хэмжээг харуулсан Excel-ийн дэлгэрэнгүй хүснэгтийг файлаар буюу хэвлэмэл байдлаар оюутны өргөдөл болон бусад бичиг баримтын хамт СТС-нд хүргүүлдэг. СТС оюутан бүрийн хавтастай танилцаж, дээрх хүснэгттэй тулгаж шалгаад, санхүүжилтийг их, дээд сургуулиудад шилжүүлэх эсэхийг шийддэг. СЭЗЯ шилжүүлгийг зөвшөрсний дараа СТС-гаас санхүүжилтийг сургууль бүрт шилжүүлдэг.

5.3.6. Гэрээг зохицуулах

69. Оюутны хичээлийн жил, зээлийн төрөл, хэмжээ, амьжиргааны зардал, замын зардал, зээл олгогдсон хугацааг бүртгэдэг, зөвшөрсөн 2 гарын үсэг бүхий зээлийн карт бий болсон. Уг зээлийн картанд мөн зээлийн эргэн төлөх хугацаа, зээлийн төрөл, хүүг тооцох ерөнхий зарчим ба зээлийн хүүгийн түвшинг харуулсан зээлийг эргэн төлөх нөхцлийг тусгадаг. 2002 онд оюутны тоо ба зээлийн хэмжээг нэгтгэн дүгнэх шинэ программыг практикт нэвтрүүлсэн. Гэхдээ, техникийн бэрхшээлээс болоод энэ программ цаашид хэрэглэгдээгүй.

70. Зээлийн мэргэжилтэн бүр өрсдийн хариуцсан их, дээд сургуулиуд, зээлийн төрлийг агуулсан хүснэгттэй байдаг. Их, дээд сургуулиудаас ирүүлдэг мэдээллийг (оюутны нэр, сургалтын хөтөлбөр, хугацаа, зээл тусламжийн хэмжээг харуулсан файлаар буюу хэвлэмэл байдлаар ирүүлсэн Excel-ийн дэлгэрэнгүй хүснэгт) зээлийн мэргэжилтнүүд гараар дахин оруулдаг.

71. Зээлийн мэргэжилтэн бүр хүснэгттэй танилцаж, зээл тусламжийн талаар СЭЗЯ болон БСШУЯ-д улирал тутам тайлагнах үүрэгтэй. Сургууль тус бүрийн шилжүүлгийн нийт хэмжээг тооцохын тулд зээл, тусламж авч байгаа нийт оюутны материалыг сургууль бүрээр Excel-ийн хүснэгтэд оруулдаг. Энэ нь гар ажиллагаа их шаарддаг тул заримдаа уг шилжүүлгийг хийхэд бүтэн сар ч болох явдал байдаг.

72. Хэрвээ зээлээр суралцаж байгаа оюутан сургуулиа орхисон буюу хасагдсан тохиолдолд их, дээд сургуулиуд ажлын 5 өдрийн дотор СТС-нд албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй. Мөн түүнчлэн, хэрвээ гэрээлэгч талуудын нэг нь гэрээг зогсоох юмуу түдгэлзүүлбэл, эсвэл оюутан сургуулиа төгсвөл сургалтын алба оюутантай сургалтын тооцоо хийж, зээлийн картыг оюутны дипломын хавсралтын хамт СТС-нд ажлын 10 хоногийн дотор ирүүлнэ. Зээлийн хэлбэрээр санхүүжигдсэн бол оюутан зээлээ төлж дуустал дипломоо гардаж авах эрхгүй. Гэсэн хэдий боловч, оюутан ажилд орохдоо дипломын хуулбарыг ашиглах боломжтой тул зээлийн үр ашиг, баталгаа хязгаарлагдмал. Оюутан сургууль төгссөний гэрчилгээ болох дипломгүйгээс болж ажилд ороход хүндрэлтэй учирдаг учраас дипломын хуулбарыг олгодог болсон нь Засгийн газрын 207-р тогтоолоор буй болгосон шинэ өөрчлөлт юм.

73. Оюутан хичээлийн жил бүрийн эхэнд гэрээг сунгах өргөдөл өгнө. Их, дээд сургуулиудаас ирүүлсэн оюутан уг сургуульд суралцаж буйг гэрчлэх тодорхойлолтыг үндэслэн СТС зээл тусламжийг олгохыг зөвшөрөх буюу гэрээг сунгана. 2002 оноос өмнө сургалтын албанаас ирүүлсэн оюутны сурлагын тодорхойлолтыг үндэслэн гэрээг сунгадаг байсан.

5.3.7. Зээлийн эргэн төлөлт

74. Оюутан сургалтын төлбөрийн зээлийг хүүгийн хамт заасан хугацааны дотор төлж барагдуулах үүрэгтэй. Хэрвээ оюутан төлбөрө төлж чадахгүй тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу итгэмжлэгдсэн төлөлөгч уг зээлийн төлбөрийн асуудлыг хариуцна.

75. Оюутан сургалтын зээлийн асуудлаа СТС-тай биечлэн уулзаж шийдвэрлэнэ. СТС нь оюутны төлбөрийн нөхцөлийг зөвшөрч, төлбөрийг шилжүүлэх дансны дугаарыг оюутанд өгнө. Зээл бүрэн төлөгдсөн тохиолдолд СТС нь оюутны дипломыг олгож, зээлийн хавтасыг хаана.

76. Оюутан авсан зээлээ хүүгийн хамт эргэн төлөгүй тохиолдолд СТС-гаас оюутанд зохих арга хэмжээг авна.

5.4. СТС-гийн бүтэц зохион байгуулалт

77. СТС нь Гүйцэтгэх захиралыг оруулаад нийт 7 ажилтантай бөгөөд Гүйцэтгэх захирал нь СЭЗЯ ба БСШУЯ-ны төлөлөл бүхий Удирдах зөвлөлд шууд тайлагнана (Хавсралт 5-аас СТС-ийн зохион байгуулалтын бүтцийг үзнэ үү). Удирдах зөвлөлийн даргаар нь БСШУЯ-ны сайд байдаг байна.

78. СТС-гийн удирдах зөвлөлийн гол үүрэг бол сургалтын зээл, тусламжийн гэрээ, түүний санхүүжилттэй холбогдон гарсан маргаан, санал зөрөлдөнийг шийдвэрлэх явдал юм. Зохион байгуулалтын бүдүүвчид үзүүлснээр мэргэжилтэн бүр тогтоолуудад үндэслэн нэг буюу түүнээс дээш оюутны асуудлыг хариуцна. Мэргэжилтэн бүрийн гүйцэтгэх үндсэн үүрэг бараг ижил байдаг. Үүнд:

- Статистик мэдээ, судалгаагаар хангах;
- Оюутны өргөдөл, санал гомдол, шаардлагыг шийдвэрлэх;
- Аймаг дүүргийн төсвийн байгууллагуудад ажилладаг төрийн албан хаагчдын (Засгийн газрын 201-р тогтоол) хүүхдүүдийн/оюутнуудын материал, данс тооцоог шалгах;
- Их, дээд сургууль, коллежуудын санхүүгийн материалтай танилцаж, шалгах;
- Их, дээд сургууль, коллежуудын санхүүжилтыг хийх.

79. Эдгээр үүргүүдээс гадна СТС нь дараах үүрэгтэй. Үүнд:

- Улирал, жил тутам санхүүгийн тайлан гаргах;
- Зээлийн эргэн төлөлтийг зохицуулах;
- Мэдээлэл сурталчилгаа хийх.

6. Сургалтын төрийн сангийн загварын сул талууд

80. 1990-ээд оноос хойш оюутны санхүүгийн тусламжийн хөтөлбөр Монголын дээд боловсролын салбарын өсөлт хөгжилд нийтэд нь ба тусламжийг хүртэж байгаа бүлэгт чухал үүрэг гүйцэтгэсэн нь эргэлзээгүй юм. Зөвхөн 2004 он гэхэд 40,000 гаруй оюутан сурагчид Сургалтын төрийн сангийн хүрээнд зээл тусламжид хамрагджээ. Эдгээр амжилтаас гадна СТС нь бодлогын шийдэл болон үйл ажиллагааны нилээд олон сул талуудтай тулагрч байна.

6.1. Бодлогын шийдлийн сул талууд

81. Монголдын дээд боловсролд хамрагсадын тоо олширч, үүнд оюутны тусламжийн хөтөлбөрийн үүрэг чухал байсан гэдэг нь эргэлзээгүй боловч Монголын дээд боловсролын салбар, оюутны тусламжийн хөтөлбөр дараахь сорилтуудтай тулгараад байна. Үүнд:


- Сонгон авах шалгуур үзүүлэлтүүдийг өргөжүүлж, улам боловсронгуй болгох
- Шалтгаан нь тодорхой бус янз бүрийн эрх үүрэг хүлээх нөхцөлтэйгэр хэт олон төрлийн тусламжийн хэлбэрийг тусгасан төсөл
- Төслийн зээлийн хүүгийн тогтолцоо нь сул
- Төслийн зээлийн дахин төлөлтийн механизм сул
- Төслийн чиглүүлэх механизм сул
- Зээлийн хэмжээ нь гачигдалтай оюутнуудын хувьд сургалтын төлбөрө бүрэн төлөх боломжгүй.

82. Дээрхи хүчин зүйлүүдээс шалтгаалан оюутны сургалтын тусламжийн хөтөлбөр нь бүрэн утгаараа хэрэгжихэд хүндрэл учирдаг байна. Эдгээр хүндрэлүүдийг дор авч үзнэ.

6.1.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд өргөжилт

83. СТС-тай холбоотой санаа зовоож буй зүйл бол шалгуур үзүүлэлтүүд өргөжиж буй явдал юм. Засгийн Газрын 96-р тогтоолын дагуу сургалтын төрийн сан нь эмзэг бүлгийн оюутнуудад сурч боловсроход нь туслалцаа, дэмжлэг үзүүлэх зорилготой байсан билээ. Энэхүү шийдвэрийн дагуу бага орлоготой оюутнуудад хөнгөлөлттэй зээл, өнчин, тахир дутуу оюутнуудад сургалтын тэтгэмж олгодог. Зураг 4-т сургалтын төрийн сан нь үйл ажиллагааныхаа эхний хоёр жилд зөвхөн бага орлоготой өрхийн оюутнуудад сургалтын зээлийн тусламж үзүүлсэн байна (1993-1995). Энэхүү хугацаанд уг сангаас жил бүр нийт 8,000 орчим оюутанд тусламж үзүүлээд байгаа билээ.

Зураг 4. СТС-ийн шалгуур үзүүлэлтийн өргөжилт



84. Анх хэрэгжиж эхэлсэн цагаас хойш оюутны тусламжийн хөтөлбөрийн зорилго нь улам өргөн цар хүрээтэй болсон. 1996-1999 онуудад уг хөтөлбөр нь эмзэг бүлэгт анхаарлаа илүү хандуулж байсан. Гэвч Засгийн Газрын 290, 310-р тогтоолууд гарснаар СТС-гаас үзүүлж буй тусламжийн хэлбэр, цар хүрээ улам өргөжиж өнчин, тахир дутуу болон Монголд сурч байгаа гадаад оюутан, гадаадад сурч байгаа Монгол оюутан сурагчдад тэтгэлэг олгодог болсон. Үүнээс үзэхэд бага орлоготой гэсэн тодотголтой туслалцаанаас илүүтэй “тэтгэлэг”-ийн хэлбэрийн дэмжлэгийг 1990 оны дунд үеэс түлхүү үзүүлэх болсон. Гэсэн хэдий ч Хүснэгт 4-өс үзэхэд оюутны тусламжийн хөтөлбөр нь гол анхаарлаа бага орлоготой өрхийн хүүхдэд хандуулах гол зарчмаасаа хазайгаагүй байна.

85. 2000 онд батлагдсан Засгийн Газрын 201-р тогтоолын дагуу төрийн албан хаагчийн хүүхдэд сургалтын тэтгэлэг олгодог болжээ. Өмнө нь төрийн албан хаагчдыг үр дүнтэй дэмжих зорилго бүхий тусгай хөтөлбөрийн хүрээнд тэдгээрийн оюутан хүүхдүүдэд сургалтын зардлын тэтгэлэгийг олгодог байсан. Гэвч мөнгөн хөрөнгийг тухайн сургуулиудад зохистой хуваарилан олгоход хүндрэл гарч байсан. Төрийн албан хаагчийн хүүхдэд тэтгэлэг олгох тусгай хөтөлбөрийн дагуу 2001 оны 1-6 сард төлөвлөгдөд байсан 1.7 тэрбум төгрөгийг сургалтын төрийн санд 2000 онд шилжүүлсэн. Төрийн албан хаагчийн хүүхдийн тоо өсөхийн хирээр тэдгээрийн сургалтын тэтгэлэгийг бүрдүүлэх зорилгоор сургалтын төрийн сангийн бусад ангилалд төсөвлөгдсөн мөнгөн хөрөнгөс зарцуулж байсан.

86. Ийнхүү шалгуур үзүүлэлтүүд өргөжсөн нь СТС-д үлэмж үр дагавар үзүүлсэн. Хүснэгт 4-ээс үзэхэд энэ чиглэлийн тусламжийн хувь нэмэгдэж, төрийн албан хаагчийн 16,000 хүүхэд энэ тусламжид хамрагдсан нь нийт оюутны 40% эзэлж байна. Жилээс жилд энэ хэлбэрийн тэтгэлэг авдаг оюутны тоо өсч байгаа юм.

87. 2000 онд Засгийн газрын 158-р тогтоол гарснаар энэ хөтөлбөрийн өргөжилтийн 2-р үе шат хэрэгжиж эхэлсэн. Сургалтын төрийн сангийн тусламжид хамрагддаг оюутны тоонд үлэмж нөлө үзүүлсэн. Засгийн газрын 158-р тогтоолын дагуу малчин, бага орлоготой, 3-аас дээш хүүхэдтэй айлын хүүхдэд санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх болсон. Энэ өөрчлөлт нь 2001 оноос эхлэн хэрэгжсэн. Хүснэгт 4-т 2001 онд 2,000 гаруй оюутан хамрагдаж байсан бол 2004 онд гэхэд 14,000 болж өссөн нь энэ ангиллын дагуу зээл, тусламж авсан оюутны тоо илт өссөнийг харуулж байна. Энэхүү ангилалд хамрагдаж буй оюутнууд нийт сургалтын төрийн сангийн оюутнуудын 35 хувийг эзэлж байна.


88. Уг хөтөлбөрийн зорилтууд өргөжсөний эцсийн үр дүн нь хоёр талтай. Нэгт, сургалтын төрийн санд хамрагдсан оюутны тоо маш түргэн нэмэгдсэн. 1994-2004 онуудын хооронд сургалтын төрийн сангаас үзүүлдэг тусламж хамрагдсан оюутны тоо 8,000-гаас 40,000 гаруй болж өссөн байна. Үүнтэй холбогдон нийт зардал 290 саяас 11,788 сая төгрөг болтол өсчээ. Хоёрт, энэхүү өргөжилт нь СТС-гаас үзүүлдэг тусламжийг ядуу оюутнуудад харьцангуй бага хүртээж, орлого сайтай өрхийн оюутнуудад илүү түлхүү үзүүлдэг болсон.

89. Түүнчлэн, энэхүү хөтөлбөрийн зорилтуудын өргөжилт нь хөрөнгийг бага өртөгтэй эргэн төлөгдөх зээлийн хэлбэрээс харьцангуй өртөг ихтэй буцалтгүй тусламжийн хэлбэр рүү илүүтэй шилжүүлсэн. Зураг 5-аас үзэхэд эргэн төлөгдөх нөхцөлтэй сургалтын зээлийн нийт СТС-ийн төсөвт эзлэх хувь хэмжээ 1994 онд 100% байсан бол 2004 онд 20% болж буурсан байна. 2000 оны сүүлээр төрийн албан хаагчийн хүүхдийн сургалтын санхүүжилт СТС-д шилжиж ирсэн үед ч гэсэн эргэн төлөгдөх зээлийн хэмжээ нийт СТС-гийн төсвийн 40%-ийг эзэлж байжээ.

90. СТС-гийн төсөв хязгаарлагдмал байгаа үед ядуу биш оюутнууд руу тусламжаа хандуулах нь зарим ядуу оюутнуудын уг тусламжид хамрагдах боломжийг хааж байна гэсэн үг юм. Судалгаанаас үзэхэд СТС-ийн тусламжид хамрагдах хүсэлтэй нийт оюутнуудын зөвхөн 60 хувь нь хамрагдаж байна. Үүнээс гадна хамгийн хурдацтай өссөж буй төрийн албан хаагчдын хүүхдүүд нь “ядуу боловч сурах чадвартай” гэсэн шалгуур үзүүлэлтийг тэр болгон хангаж чадахгүй байх.

91. Дараагийн нэг асуудал бол СТС-ийн тусламжид үргэлжлүүлэн хамрагдах нэг шалгуур үзүүлэлт болох сурлагын онцсайн дүнг хангах шаардлагыг хүчингүй болгосон явдал юм. 2002 оны 10-р сар хүртэл СТС нь зээл, буцалтгүй тусламжийн гэрээг оюутны улирлын голч дүнг үндэслэн сунгадаг. Гэвч оюутнууд сургалтын тэтгэмжээ хадгалахын тулд багш нараа өрсдийн дүнгээ засуулах гэж хахуульдах эсвэл айлган сүрдүүлэх гэх мэт сөрөг үр дагавар гарч ирсэн учраас 2002 оны 10-р сард энэ шалгуурыг мөрдөхийг зогсоосон.

Зураг 5. Эргэн төлөгдөх нөхцөлтэй сургалтын зээлийн нийт СТС-ийн төсөвт эзлэх хувь хэмжээ 1994-2000



Тэмдэглэл: 1999-2000 онд төрийн албан хаагчдийн хүүхдэд сургалтын төрийн сангийн тусламжийг илүүтэй чиглүүлсэн тул энэ үед оюутны зээлийн хэмжээ эрс буурсан

Эх сурвалж: Төрийн боловсрол, сургалтын сан

92. Оюутны тэтгэмжийг олгохдоо тэдний сурах идэвхи зүтгэл, сурлагын чадварыг дүгнэх нь чухал. Гэвч үүнтэй холбогдон гарах хээл хахууль, хүчирхийлэл нь тус хөтөлбөрийн үндсэн үүргийг биелүүлэхэд саад учруулж байна. Энэ асуудал нь зөвхөн тэтгэмжийн хөтөлбөрийн хүрээнд яригдах асуудал биш бөгөөд зөвхөн сургуулиудын хүрээнд тусгайлан авч шийдэх асуудал юм. Мөн түүнчлэн оюутны сурлагын дүн нь сургалтын тэтгэмж авахад шаардагдахаасаа илүү тухайн оюутан төгссөний дараа ажилд орох, тэр тусмаа ирээдүйд олох орлогын хэмжээг тодорхойлоход чухал үүрэгтэй байдаг.

6.1.2. Хөтөлбөрийн ярвигтай байдал

93. Засгийн газраас гаргасан олон тооны тогтоолын дагуу СТС-ийн хөтөлбөрт шинэ зүйл ангилалууд нэмэгдсэн нь хөтөлбөрийг ойлгоход бэрх илүү, төрөл бүрийн эрх үүрэг бүхий тусламж болон нэрлэвэрүүдтэй болгоо байна. Хөтөлбөрийн хүрээнд нийт 4 төрлийн тусламжийг үзүүлж байна. Үүнд: зээл, буцалтгүй тусламж, тэтгэлэг болон төрийн санхүү багтана. Сүүлийн 3 нь хэдийгээр өр өрөр нэрлэгдэж байгаа боловч бүгд буцалтгүй тусламжийн хэлбэрүүд юм.

94. Сургалтын тусламжийг зарим тохиолдолд тодорхой хугацаатайгаар, харин зарим үед тухайн сургалтын бүх хугацааны туршид үзүүлдэг. Зарим төрлийн оюутнууд төрлийн (гадаадад сурч байгаа оюутан) хөтөлбөрийн янз бүрийн хэсэгт хамрагдаж болно. Бага орлоготой оюутан эсвэл гадаадад сурч байгаа оюутанд зориулсан сургалтын төлбөрийн зээл үү гэдгээс хамааран зээлийн хүүг өр өр жишгийн дагуу тооцож гаргадаг. (жишээ нь: нэгэнд нь тухайн үеийн арилжааны банкны зээлийн хүүг жишиг болгож байхад нөгөд нь инфляцийн түвшинг жишиг болгодог).

95. Хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдэд өгсөн янз бүрийн нэрлэвэрүүд нь ихэнхдээ ойлгомж муутай буюу буруу ойлголт төрүүлэхээр байдаг. Жишээ нь хэдийгээр зарим нэр төрлийн сургалтын зээлийн нэр нь зөвхөн сургалтын зардлыг төлнө гэсэн утга агуулах боловч түүнд амьжиргааны зардал, замын зардлыг зэрэг багтаасан байдаг.

96. Эдгээр нь оюутнууд болон олон нийтийн хөтөлбөрийн талаарх ойлголтыг хязгаарлаж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэцүү бөгөөд өртөг ихтэй болгож байна. Мөн эдгээр олон тусламжийн төрлүүд нь оюутнуудад шаардлагатай байгаа тусламжийн төрлө сонгоход нь хүндрэл учруулдаг.(эргэн төлөгдөхгүй буцалтгүй тусламжийг зээлээс илүүтэй үздэг).

Хүснэгт 4: Оюутны зээл авсан оюутны тоо, ангиллаар, 2004

Ангилал	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
<i>96-р тогтоол</i>											
А. Зээл											
• Бага орлого	8,035	8,115	8,189	6,872	6,128	7,870	9,237	9,596	7,337	7,972	7,500
• Дотоодын магистр/доктор	-	-	-	-	-	-	-	125	243	267	252
• Гадаадад сурч байгаа оюутан	-	-	-	-	-	180	204	239	104	170	114
В. Өнчин/тахир дутуу хүүхдүүд	-	-	-	326	520	833	962	1,099	1,297	1,391	1,438
С. Сургалтын тэтгэлэг	-	-	-	-	61	132	178	182	255	153	149
<i>96-р Тогтоол : бүгд</i>	<i>8,035</i>	<i>8,115</i>	<i>8,189</i>	<i>7,198</i>	<i>6,709</i>	<i>9,015</i>	<i>10,581</i>	<i>11,241</i>	<i>9,236</i>	<i>9,953</i>	<i>9,453</i>
<i>Нийт оюутны хувь (%)</i>	<i>100.0</i>	<i>100.0</i>	<i>100.0</i>	<i>98.9</i>	<i>98.4</i>	<i>98.9</i>	<i>46.6</i>	<i>43.7</i>	<i>38.0</i>	<i>27.7</i>	<i>23.5</i>
<i>201-р тогтоол</i>											
Д. Төрийн албан хаагч	-	-	-	-	-	-	12,082	12,262	14,928	15,915	16,335
<i>Нийт оюутны хувь (%)</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>53.2</i>	<i>47.7</i>	<i>38.0</i>	<i>44.3</i>	<i>40.6</i>
<i>158-р тогтоол</i>											
Е. Төрөс санхүүжүүлэх											
• Малчин	-	-	-	-	-	-	-	260	1,396	2,080	5,727
• Бага орлого	-	-	-	-	-	-	-	1,639	3,863	6,640	7,567
• 3 болон түүнээс дээш хүүхэд	-	-	-	-	-	-	-	234	435	1,082	1,016
<i>158-р тогтоол: бүгд</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>2,133</i>	<i>5,694</i>	<i>9,802</i>	<i>14,310</i>
<i>Нийт оюутны хувь (%)</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>8.3</i>	<i>23.5</i>	<i>27.3</i>	<i>35.6</i>
<i>310/290-р тогтоол</i>											
F. Магистр, доктор											
• Монголд буй гадаад оюутан	-	-	-	-	-	-	-	-	-	104	114
• Хөгжилтэй оронд сурч байгаа оюутан	-	-	-	79	107	98	61	87	109	131	0
<i>310/290-р тогтоол: бүгд</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>79</i>	<i>107</i>	<i>98</i>	<i>61</i>	<i>87</i>	<i>109</i>	<i>235</i>	<i>114</i>
<i>Нийт оюутны хувь (%)</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>1.1</i>	<i>1.6</i>	<i>1.1</i>	<i>0.3</i>	<i>0.3</i>	<i>0.4</i>	<i>0.7</i>	<i>0.3</i>
Нийт	8,035	8,115	8,189	7,277	6,816	9,113	22,724	25,723	29,967	35,905	40,212
Нийт оюутны хувь (%)	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх сурвалж: Төрийн боловсрол, сургалтын сан

6.1.3. Зээлийн хүүг тогтоох

97. Оюутны тусламжийн хөтөлбөрийн сул талуудын нэг нь зээлийн хүүг тогтоох механизм байгаа юм. Энд 2 хүндрэлтэй асуудал байна. Нэгдүгээрт, хэдийгээр онолын хувьд зээлийн хүү нь арилжааны банкны хүүгээс 0.5 хувиас дээш байна гэх боловч, гэвч амьдрал дээр оюутны зээлийн хүүг тогтоодог тодорхой нэг механизм, систем байдаггүй. Ийм тохиолдолд сургалтын зээл нь үнэн хэрэгтээ буцалтгүй тусламж болох бөгөөд оюутны зээлийн хөтөлбөрт тодорхой төрийн татаас байна гэсэн үг юм.

98. Хоёрдугаарт, хэрэв сургалтын зээлийн хүүг тооцдог хэдий ч хэтэрхий урт хугацаагаар хүүгээс чөлөлдөг. Одоогийн мөрдөж байгаа журмын дагуу уг оюутан төгссөнөс хойш 7 дахь жилээс нь эхлүүлэн зээлийн хүүг төлүүлдэг. Оюутны зээлийг ийм урт хугацаагаар хүүгээс чөлөлөх тодорхой үндэслэл байхгүй байна. Энэ нь сургалтын төлбөрийг төлөх санхүүжилтээр урьдчилан хангаснаар хөрөнгийн зах зээлийн дутагдлыг арилгах зорилго бүхий дэлхий нийтээр хэрэгжүүлж байгаа оюутны тусламжийн хөтөлбөрийн үзэл санаатай нийцэхгүй байгаа юм. Санхүүжилт нь Засгийн газарт ногдож буй хөрөнгийн бодит өртөгийг агуулж байх ёстой болохоос биш татаасын хэлбэрийн хөнгөлөлттэй нөхцөлөр олгогдох ёсгүй. Иймээс одоо олгогдож байгаа хэт урт хугацаагаар хүүгээс чөлөлсөн зээл нь ил, тодорхой бус Засгийн газрын татаасын хэлбэрийг агуулж байна.


99. Ийнхүү урт хугацаагаар хүүгээс чөлөлдөг явдал нь оюутны тусламжийн хөтөлбөрт дараах байдлаар сөргөр нөлөлж байна.

- Засгийн газраас уг хөтөлбөрт зориулж оруулсан хөрөнгийн эх үүсвэрийн зардлыг төлөлнө.
- Оюутнууд тухайн зээлийн хүүг төлөх ёстой хугацаа болтол авсан зээлээ төлөх санаачлага гаргах хөшүүрэг болж чадахгүй.

100. Зээлийн хүүг тогтоох нэг чухал механизм бол зээлийн хүүг зах зээлийн хүүгийн ханштай жиших явдал юм. Жишээ нь бага орлоготой оюутанд олгосон сургалтын зээлийг тухайн үеийн арилжааны банкны зээлийн зах зээлийн ханштай дүйцүүлэх хэрэгтэй байхад бусад оюутнуудад(гадаадад сурч байгаа оюутан) олгосон зээлийн хүүг инфляцийн ханштай жишиж үзэх шаардлагатай юм. Ийнхүү зах зээлийн жишиг үнэтэй харьцуулан зээлийн хүү тогтоох механизм нь зээлийн хүүг тухайн үеийн Засгийн газрын зээллэгийн зардал болон бусад ханшны өөрчлөлт хэлбэлзэлтэй цаг тухайд нь нарийн уялдуулах оновчтой сонголт болж чадна. Гэвч дээр дурдсанаас харахад оюутны зээлээс ямар ч хүү төлүүлээгүй байна.

101. Зураг 6-д Монгол банкны хүүгийн түвшин, дотоодын арилжааны банкны богино хугацааны зээлийн хүүгийн түвшин гэсэн 2 жишгийг үндэслэн бага орлоготой өрхөд олгогдож буй сургалтын зээлийн хүүгийн түвшинг 2 өр хувилбараар гаргаж болохыг харж болно. 1998-2004 онуудад Монгол банкны ханшийг жишиг болгон үзэхэд зээлийн хүү 4.4%-38% байсан бол 2004 оны эхний улиралд 10-аас доогуур хувьтай болж байна. Харин дотоодын арилжааны богино хугацааны зээлийн хүү (30-40%)-г жишиг болговол оюутны зээлийн хүү илүү өндөр байх байсан. Иймээс зээлийн хүүг тооцдоггүйгээс болж нь оюутны зээлийн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт татаасын хэлбэр агуулагдсан болохыг харуулж байна.

Зураг 6: 2 төрлийн ялгаатай жишиг ханшинд тулгуурлан тогтоосон бага орлоготой оюутнуудад зориулсан сургалтын зээлийн хүүгийн түвшин, улирлаар, 1998-2002



Тэмдэглэл: Ханш нь Монгол банкны ханшаас 5 %-иар их тооцогдсон бөгөөд төгрөгийн богино хугацааны зээлийн хүүгийн жишгийг ашигласан

Эх сурвалж: Олон Улсын Валютын Сангийн тоо баримт

6.1.4. Эргэн төлөх механизм

102. Оюутны зээлийн бас нэг сул тал нь хангалтгүй боловсруулагдсан зээлийн эргэн төлөлтийн механизм юм. 5.2-р бүлэгт зааснаар эргэн төлөх механизм нь дараах гол бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Зээл сургууль төгссөнөс хойш 10 жилийн дотор эргэн төлөгдөх ёстой.
- Эргэн төлөгдөх мөнгөний хэмжээ болон эргэн төлж эхлэх хугацааг тодорхой заагаагүй байна.
- Дипломын баталгаажсан хуулбарыг өгдөг болсноор оюутнуудын зээлээ эргэн төлөх санаачлага бага болсон.

103. Зээлийн тодорхой хэсгийг хүчингүй болгох цөнгүй нөхцөлүүд байна. Жишээ нь:

- Сургалтын жил бүр хагас өнчин оюутны нийт зээлийн 150,000 төгрөгийг хүчингүй болгох.
- Төгссөнөсө хойш 5 жил төрийн албанд ажилласан хүмүүсийн зээлийг бүрэн чөлөлөх.
- Хэрэв оюутан амь нас барсан эсвэл хөдөөлмөрийн чадвараа 70% болон түүнээс дээш хувиар алдсан бол чөлөлөх.
- Гадаадад сурч байгаа оюутнууд 75%-аас дээш сурлагын амжилт үзүүлбэл зээлийг чөлөлөх.

104. Оюутны зээлийн эргэн төлөлтийн үр ашигтай тогтолцоо байхгүй байгаа нь уримтлагдсан өрийн хэмжээг нэмэгдүүлж, тэдгээрийг хүчингүй болгох лоббиг бий болгож байна. Засгийн газраас 2004 оны 1-р сард их, дээд сургууль төгссөн 21,000 оюутны 8:2 тэрбум төгрөгийн зээлийг хүчингүй болгосон.

105. 6.2.7 хэсэгт дурьдсан бодлогын шийдэл болон үйл ажиллагааны сул талуудын үр дүнд зээлийн эргэн төлөлт маш бага байна. Хүснэгт 5-аас үзэхэд зээлээ бүрэн төлсөн төгсөгчид 5.3%, төлж байгаа нь 14.7% байна. 1994-2002 хооронд нийт 20,000 төгсөгч оюутны зээл авснаас зөвхөн 2000 буюу 9.7% нь зээлээ төлж байгаа буюу төлж барагдуулсан байна. Хүснэгт 5-аас 1994-2002 хооронд нийт 12.2 сая төгрөгийн оюутны зээл олгосныг мөн харж болно. Зээлийн төлөлт нь 1994 онд 9 сая төгрөг, 2002 онд 45 сая төгрөг зэрэг жил бүр харилцан адилгүй байжээ. 1994-2002 хугацаанд 245 сая төгрөг буюу нийт зээлийн зөвхөн 2% л төлөгдсөн байна.

Хүснэгт 5: Сургалтын төрийн сангийн зээлээр суралцагчид, төгсөгчдийн тоо, зээлээ төлөгчдийн тоо ба төлсөн дүн (1993–2002)

Он	Зээлээр төгсөгчдийн тоо (#)	Зээлээ эргэн төлөгчдийн тоо (#)	Зээлээ эргэн төлөгчдийн хувь (%)	Зээлийн үлдэгдлийн Дүн (мянган төгрөгөр)	Зээлийн эргэн төлөлт жил бүрээр (мянган төгрөгөр)	Эргэн төлөгдсөн зээлийн хувь (%)
1993	N/A	N/A	N/A		16,882.4	
1994	3,157	448	14.2	290,100	8,955.6	3.1
1995	2,907	244	8.4	395,900	11,738.2	3.0
1996	2,221	170	7.7	408,800	33,248.4	8.1
1997	4,731	250	5.3	500,800	32,901.4	6.6
1998	1,674	120	7.2	807,000	24,411.4	3.0
1999	1,332	186	14.0	1,723,200	35,462.2	2.1
2000	1,339	197	14.7	2,531,400	36,849.2	1.5
2001	1,307	178	13.6	2,813,500	44,796.9	1.6
2002	1,969	208	10.6	2,720,900	698.9	0.0
Total	20,637	2001	9.7	12,191,600	245,945	2.0

Тэмдэглэл: 2003-2004 онд зээлийг СЭЗЯ-нд төлдөг болсон.

Эх сурвалж: Сургалтын төрийн сан

106. Хүснэгт 6-д үзүүлсэний дагуу хөгжиж буй болон хөгжилтэй орнуудад оюутнуудын зээлийн эргэн төлөлтийн хувь хэмжээ (инфляци тооцсон) нь 8 хувиас 67 хувь хүртэл байдаг байна. Нэлээд олон тооны хөгжиж буй орнууд зээлийн эргэн төлөлтийн төвшингөрө Монгол улсаас илүү дээгүүр амжилттай байна.

107. Бусад орны туршлагаас үзэхэд оюутны зээлийн хөтөлбөрийн хэлбэр нь зээлийн эргэн төлөлтийн төвшинд амин чухал нөлөтэй. Жишээлбэл, Филиппины Одоо сур, дараа нь төл оюутны зээлийн хөтөлбөрийн эргэн төлөлтийн хувь хэмжээ нь энэхүү хөтөлбөрийг хэрхэн ажиллуулж байгаагаас хамааран янз бүр байдаг бөгөөд ямар байгууллага үйл ажиллагааг нь удирдаж явуулж байгаагаас шалтгаалан 2.4 хувиас 53 хувь хүртэл ялгаатай гарч байсан.¹⁴ Гэвч энэ асуудал зөвхөн хөгжиж буй оронд гардаг гэж бодож болохгүй бөгөөд өндөр хөшжилтэй оронд ч гэсэн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон бэрхшээлтэй тулгардаг гэдгийг мэдэхэд илүүдэхгүй.

¹⁴ Лароке, Норман (2000), Филиппины хувийн боловсрол: Зах зээл болон зохицуулалтын судалгаа, Азийн хөгжлийн банк, Мимео, 11-р сар, Манила, 42-р хуудас.

Хүснэгт 6: Зээлийн бодит эргэн төлөлтийн хувь хэмжээ, Орон ороноор

Орон	Алдагдал ба Захиргааны Зардалгүй (хувь)	Алдагдал ба Захиргааны Зардалгай (хувь)
<i>Урт хугацааны барьцаат зээл</i>		
Венесуэл	77	8
Кени	30	8
Чили	52	18
Гондурас	49	27
Индонези	43	29
Бразил	38	29
Ямайка	44	30
Дани	48	38
Япон	50	40
АНУ	71	47
Финланд	65	48
Норвеги	67	52
Колумби	71	53
Хонг Конг	57	53
Канада	69	63
Барбадос	87	67
<i>Орлогод зохицсон зээл</i>		
Австрали	52	43
Швед	72	67

Эх сурвалж: Албрехт Д ба Зидермань А, 79 хуудас

6.1.5. Чиглэх Механизм

108. Сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжийн зарим хөтөлбөрүүд нь тодорхой ангилалд хамаарагдах оюутнуудад чиглэгдсэн байдаг. Гэвч өнөөгийн чиглэлд зарим асуудлууд байна. Жишээлэхэд, бодлогын хүрээнд сургалтын төрийн хөтөлбөрүүд нь эхний үед орлого багатай ядуу буюу эмзэг бүлэгт хамаарах өрхүүд рүү чиглэгдэж байсан хэдий ч тодорхой хугацааны дараа 6.1.1-д дурьдсанчилан өрхийн орлогын төвшингөс үл хамааран төрийн албан хаагчийн хүүхдийн сургалтын төлбөр эсвэл сурлагын амжилтыг дэмжсэн сургалтын төлбөрийн шагнал зэргийг санхүүжүүлэх рүү илүү чиглэгдэх болсон. Тиймээс төрөс санхүүждэг төрийн албан хаагчийн хүүхдийн тоо нэмэгдэж байгаа нь гол санаа зовоож асуудал болж айна.

109. Дээр дурьдсан хөтөлбөрүүдийн чиглэл нь үр өгөжтэй байгаа эсэх нь чухал асуудал болж байна. Сургалтын төрийн сангийн санхүүжилт дахь тодорхой зорилгоор төрөс санхүүждэг хэсэг үлэмж нэмэгдэж байгаа (2000-гаас 2004-ны хооронд ойролцоогоор 600 хувь) нь сурах чадвартай боловч санхүүгийн хэрэгцээтэй хүүхдийг дэмжих зорилгод хэр нийцэх вэ гэсэн асуудлыг хөндөж байна

110. Дараагийн нэг асуудал бол сургалтын сангийн хөтөлбөрүүдийн санхүүжилтийн хэлбэр, шалгуур үзүүлэлт болон ямар төвшингийн боловсролыг дэмжих вэ гэдгийн цаана тодорхой бодлогын үндэслэл байхгүй байдал юм. Ихэнх тохиолдолд Засгийн газрын төрөл бүрийн тогтоолоор сургалтын сангийн санхүүжилт нь ямарваа нэгэн нийгмийн эмзэг бүлэг рүү чиглэгдэж байгаа хэдий ч дотроо янз бүрийн эрх үүрэгтэй байна. Тэдгээрийн цаана байгаа үндэслэл тэр болгон тодорхой бус байна. Жишээлбэл:

- Зарим бага орлоготой өрхийн оюутнууд сургалтын төлбөрийн зээл авч байхад зарим нь эргэж төлөгдөхгүй нөхцөлөр төрийн санхүүжилт авдаг;

- Зарим бага орлоготой өрхийн оюутнууд эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, зээлийн тэтгэлэгийг авч байхад зарим нь эргэн төөөгдөх нөхцөлгүй сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж авч байна.

111. Дараагийн бас нэг санаа зовоож буй зүйл бол шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг тодорхойлох хэмжүүр нь зөв эсэх явдал юм. Өөрөр хэлбэл, эмзэг бүлгийнх гэдгийг тодорхойлох зөв шалгуур үзүүлэлтийг хэрэглэж байгаа эсэхийг тодруулах явдал юм. Үүнд 3 хэсэг байдаг: шалгуур үзүүлэлтүүдийн бүтэц, тэдгээрийн босго болон амьдрал дээр ашиглах буй байдлууд байна.

112. Нэгт, төрийн санхүүжилтэд хамрагдахад нөлөлөх олон шалгуур үзүүлэлтүүд байна. Жишээлэхэд, бага орлоготой өрх, малчин, 3 ба түүнээс хүүхэд зэрэг суралцаж буй өрх, бүтэн ба хагас өнчин, эцэг эх нь хоёулаа тэтгэвэрт гэх мэт. Түүнчлэн, эдгээрийн ялгааны үндэслэлүүд нь бас тодорхой бус байна.

113. Хоёрдахь чухал асуудал бол шалгуур үзүүлэлтүүдийн төвшин бодит хэмжээнд (ядуурлын төвшинг зав тодорхойлж чадаж байгаа эсэх) байгаа эсэх явдал юм. Жишээлэхэд, нэлээд олон хүмүүс 700 орчим малтай өрх бол Монголын нөхцөлд ядууд биш харин баянд тооцогдоно гэж хэлж байсан.


114. Эцэст нь хэлэхэд сургалтын сангийн хөтөлбөрүүд нь ядуурлыг төвшинг хэмжиж ядуу өрх рүү чиглэгдэж чадаж байгаа эсэх юм. Өнөгийн байдлаар, өргөдөл гаргаж буй оюутны өрхийн орлогын төвшинг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг бөгөөд орон нутгийн засаг захиргаанаас гаргаж өгсөн тодорхойлолтыг л үндэслэдэг. Сургалтын сангийн санхүүжилтэд хамрагдахын тулд оюутнууд тухайн орон нутгийн засаг захиргаанаас нэн ядуу буюу ҮСГ-аас тогтоосон амьжиргааны төвшингэс доогуур орлоготой гэсэн тодорхойлолт авчрах шаардлагатай болдог.

115. Энэхүү тодорхойлолт нь зарим тохиолдолд маш субъектив тодорхойлолт байдаг. Их, дээд сургуулиуд болон сургалтын төрийн сан нь зөвхөн энэ тодорхойлолтыг үндэслэдэг бөгөөд өр төрлийн тодруулга хийгддэггүй байна. Зарим тохиолдолд орлогын төвшингийн тодорхойлолт нь зөвхөн өрийн мэдлэгийн хүрээнд (тухайн өрхийн талаарх ерөнхий мэдлэг, гадаад байдал гэх мэт) хийгддэг. Гар цайлгах буюу танил талаа ашиглах гэх зэрэг нь нөлөлдөг. Үүнд нөлөлдөг бас нэг асуудал бол орон нутгийн засаг захиргаа ихэвчлэн албан ёсны бүртгэлтэй орлогыг үндэслэдэг. Гэвч нөгө талаас Монголд албан бус хэвшлийн орлого нь өрхийн орлогын тодорхой хувийг эзэлдэг. Хөрөнгийн үнэлгээ хийдэггүй нь эдгээр бүх асуудлыг улам бэрхшээлтэй болгодог байна. Харамсалтай нь орлогын төвшинг хэр үнэн зөв тодорхойлдог талаар үүнээс илүү мэдээлэл байхгүй байна.

6.1.6. Санхүүжилтийн хүрэлцээ

116. Сүүлийн жилүүдэд сургалтын төрийн санхүүжилтэд хамрагдсан оюутны тоо үлэмж өссөн. Зураг 7-д үзүүлсэнчилэн ямарваа нэгэн туслалцаа авдаг их, дээд сургуулийн оюутнуудын хувь хэмжээ нь 1990 оны дундуур буурч байсан боловч түүнээс хойш эрчимтэй өссөн байна. 2002 оноос хойш өссөр 2004 онд гэхэд 37 хувь болсон байна.

Зураг 7: Сургалтын төрийн сангаас туслалцаа авдаг их, дээд боловсролын оюутнуудын хувь хэмжээ, 1994-2002



Эх сурвалж: Сургалтын төрийн сангаас авсан тоо статистик

117. Эхний нэг асуудал бол СТС-гийн тусламжид хамрагдсан оюутнуудын хувь хэмжээ нь хэрэгцээтэй бүх оюутнуудыг хамрах зорилгын хүрээнд нийт их, дээд сургууль, коллежид элсэгчдийн хангадттай хувийг эзэлж байгаа эсэх юм. Сүүлийн үед бол СТС-гийн тусламжид хамрагдсан оюутнуудын хувь хэмжээ нэмэгдэж байгаа ч гэсэн сургалтын сангийн хөтөлбөр нь их, дээд боловсролын төвшинд суралцаж буй бүх оюутнуудыг хамрах боломжгүй юм. Тийм учраас шалгуур үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай юм.

118. Одоогийн байдлаар БСШУ Яам их, дээд сургуульд шинээр элсэгчдийн 60 хувийг зээл, буцалтгүй тусламжид хамруулахаар тооцож төсөвө гаргаж байна. Энэхүү тоо нь сургалтын сангийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтэй оюутнуудын судалгааг үндэслэн гаргасан юм. Гэхдээ энэ нь шаардлагатай хүрээг хамраж байгаа эсэх, цаана нь санхүүгийн бэрхшээлтэй хэчнээн оюутнууд тусламж авч чадахгүй байгааг харуулж чадахгүй байна.

Хүснэгт 7: Сургалтын төрийн сангийн санхүүжилтэд хамрагдах боломжтой оюутнуудаас хамрагдсан байдал, 1999-2003

	Сургалтын төрийн сангийн санхүүжилтэд хамрагдах боломжтой оюутны тоо (#)	Үүнээс сургалтын төрийн сангийн санхүүжилтэд хамрагдсан оюутны тоо (#)	Батлагдсан хувь хэмжээ (%)
1999	1,768	1,086	61.4
2000	1,170	585	50.0
2001	7,150	4,157	58.1
2002	9,200	6,490	70.5
2003	7,200	6,140	85.3

Эх сурвалж: БСШУ Яам

119. Дараагийн нэг асуудал бол хамрагдаж буй оюутнуудад үзүүлж буй санхүүжилтийн хэмжээ хангалттай эсэх явдал юм. Хүснэгт 7-д үзүүлсэнчилэн 2003-2004 хичээлийн жилд их, дээд сургуульд сурах зардал 681,000-гаас 2.1 сая төгрөг (сургалтын материал болон амьжиргааны зардал орно) болж байсан.

Хүснэгт 8: Их, дээд боловсрол эзэмшихтэй холбоотой нэг жилийн өрхийн зардал, 2002-2003

	Төрийн өмчийн		Төрийн бус		
	Хамгийн өндөр (MNT)	Хамгийн бага (MNT)	Хамгийн өндөр (MNT)	Хамгийн бага (MNT)	
Сургалтын материал зардал	Нэг удаагийн төлбөр	3,000	1,500	4,000	1,200
	Сургалтын төлбөр	450,000	300,000	650,000	250,000
	Бусад	0	0	0	0
	Сургалтын материал, номын зардал	80,000	60,000	80,000	60,000
	Сургалтын материалын, зардлын дүн	533,000	361,500	734,000	311,200
Оюутны амьжиргааны зардал	Байр	360,000	0	600,000	0
	Хоол хүнс	500,000	200,000	500,000	200,000
	Тээвэр	Автобус: 50,000 Гэртээ очиж ирэх (жилд нэг удаа): 60,000	Автобус: 50,000	Автобус: 50,000 Гэртээ очиж ирэх (жилд нэг удаа): 60,000	Автобус: 50,000
	Бусад хувийн зардал	120,000	120,000	120,000	120,000
	Оюутны амьжиргааны зардлын дүн	1,090,000	370,000	1,330,000	370,000
	Нийт дүн	1,623,000	731,500	2,064,000	681,200

Эх сурвалж: Отгонжаргал, Охидой (2003) Mongolia

www.gse.buffalo.edu/org/inthigheredfinance/region_asia_Mongolia.htm p 9.

120. Хүснэгт 9-д үзүүлсэнчилэн 2004 онд үзүүлсэн зээл, тусламжийн дундаж хэмжээ болон их, дээд боловсролын өртөгийн зөрүү маш их байна. Энэхүү зөрүү нь ялангуяа өндөр төлбөртэй төрийн өмчийн болон төрийн өмчийн бус сургуулиудад их мэдрэгдэх бөгөөд оюутнуудын боловсрол эзэмших бололцоонд нөлөлдөг. Мөн түүнчлэн энэ нь сургалтын сангийн санхүүжилтийг зарим оюутнуудад илүү ихээр олгох, үлдсэнд нь бага хэмжээгээр буюу огт олгохгүй байх байдлаар нөлөлдөг.

Хүснэгт 9: 2004 онд үзүүлсэн зээл, тусламжийн дундаж хэмжээ болон их, дээд боловсролын өртөгийн зөрүү

	Хамгийн өндөр төлбөртэй төрийн өмчийн (MNT)	Хамгийн бага төлбөртэй төрийн өмчийн (MNT)	Хамгийн өндөр төлбөртэй төрийн өмчийн бус (MNT)	Хамгийн бага төлбөртэй төрийн өмчийн бус (MNT)
Их, дээд боловсролын нийт өртөг	1,623,000	731,500	2,064,000	681,200
2004 онд үзүүлсэн зээл, тусламжийн дундаж хэмжээ	392,607	392,607	392,607	392,607
2004 онд үзүүлсэн зээл, тусламжийн дундаж хэмжээ болон их, дээд боловсролын өртөгийн зөрүү	1,230,393	338,893	1,671,393	288,593

Эх сурвалж: www.gse.buffalo.edu/org/inthigheredfinance/region_asia_Mongolia.htm, p 9.

6.2. Үйл ажиллагааны загварын сул талууд

121. СТС нь санхүүгийн тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцдаа үр ашиг муутай систем ба процессийн улмаас нилээд бэрхшээлүүдтэй тулгарч байна. Эдгээрийн зарим нь үндсэн бүтэц муугаас болж, нөгө хэсэг практикт тэр болгон хэрэглэгддэггүй журмууд нь дэлгэрэнгүй нарийвчлал муугаас үүсч байна. Эдгээр дутагдалтай талуудыг дор дэлгэрэнгүй тайлбарлалаа.

6.2.1. Үйл ажиллагааны журам

122. Үйл ажиллагааны журам нь үйл ажиллагааны явцын өнөөгийн байдлыг тусган харуулдаг. Олон талаараа төвөг чирэгдэл учруулсан, бүрэн гүйцэд бус байна. Жишээ нь зээлийн буцаан төлөлт, хүүг тооцох ба хүчингүй болгох талаар дэлгэрэнгүй тусгаагүй байна. Эдгээр тусгагдаагүй зүйлсийн талаар доор дэлгэрэнгүй тайлбарлана.

123. Үйл ажиллагааны журмын нэг хүндрэлтэй тал нь уг журам анхнаасаа гурван өр хэрэглэгчдэд (СТС, их, дээд сургууль ба суралцагч) зориулагдсантай холбоотой. Эдгээр хэрэглэгчдийн бүлгүүдийн хэрэгцээт мэдээлэл нь ялгаатай бөгөөд энэ нь уг журмын хэрэглээг бууруулахад нөлө үзүүлсэн бололтой. Нөгө талаас зээл, буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн зорилтууд нь тодорхой үндэслэлгүйгээр өргөжиж буй явдал уг журмыг нарийн төвөгтэй болгож байна.

124. Дараагийн нэг сул тал нь уг журам нь олон тооны ялгаатай тогтоолуудад үндэслэгдсэн байна. (жишээ нь 96-р тогтоол - Сургалтын зээл, буцалтгүй тусламж, 158-р тогтоол - Төвөс санхүүжүүлэх тухай, 201-р тогтоол-Төрийн албан хаагч, 310/290-р тогтоол-Өндөр хөгжилтэй орны их сургуульд Магистрантур, докторантурт суралцах тухай). Гэтэл уг хөтөлбөрийн тогтоол тус бүрийг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанууд нь ерөнхийдө ижил төстэй. Чанарын хувьд үйл ажиллагааны журамд тусгагдсан заалтуудын нэгдмэл байдал, бүрэн бүтэн байдалд нилээд зөрүү, ялгаатай байна.

6.2.2. Хөтөлбөрийг сурталчлан таниулах нь

125. СТС-ын үйл ажиллагааг сурталчлах зорилгууд:

- СТС-гийн үйл ажиллагааг нийтэд таниулах;
- Оюутнуудыг зээл тусламж хэрхэн яаж авах, өргөдөл яаж гаргах, ямар бэлтгэл хийх талаар илүү сайн ойлголттой болгох;
- СТС ба түүний хэрэглэгчдийг хамтран ажиллах боломжоор хангах.

126. СТС-ын гүйцэтгэх захирал өрө сурталчилгааны олон ажлуудыг хийдэг. Сүүлийн 2 жилд явуулсан сурталчилгааны тодорхой арга хэмжээнд:

- 2002 болон 2003 онд гаргасан мэдээллийн товхимол;
- 2003 оны 11-р сар, 2004 оны 2-р сарын хоёр удаагийн асуулт хариултын телевизийн нэвтрүүлэг;
- Сонинуудад өгсөн ярилцлагууд;
- Хавар (2-6-р саруудад), СТС-гийн ажилтнууд их, дээд сургуулиудад очиж үйл ажиллагаагаа тайлбарлан таниулж, зээл, буцалтгүй тусламж авах шалгуур үзүүлэлтүүд,, эргэн төлөх журам зэргийг танилцуулсан;
- Дунд сургуулийн төгсөгчдийн дунд семинар, ярилцлага.

127. Бага орлоготой олон өрхүүд бүхий хөдөө орон нутагт мэдээлэл, сурталчилгаа хангалтгүй байна:

- Ихэнх ажлууд Улаабаатар хотод явагддаг. СТС-гийн ажилчид хөдөөгийн дунд сургууль,, их сургуулиудад очиж ажилладаггүй. Хөдөөгийн оюутнууд зээлийн хөтөлбөр байдаг гэдгийг мэддэг боловч зээл авах шалгуур үзүүлэлтүүдийн тухай мэдээлэл дутмаг.
- 2003 онд үйл ажиллагааны журам цөн тоогоор хэвлэгдсэн. (жил бүр зээл тусламж авах эрхтэй 40,000 оюутан байдаг ба тэдэнд зориулж 360,000 төгрөг зарцуулаад дөнгөж 300 ширхэг хэвлэсэн)
- СТС нь вэб хуудасгүй учраас СТС-гийн тухай мэдээлэл интернэтэд байхгүй,.
- 2002 болон 2003 онуудад хэвлэгдсэн мэдээллийн товхимлыг дөнгөж 10-15 оюутан захиалсан. Энэ нь ийм товхимол хэвлэгддэг гэсэн мэдээлэл байхгүйгээс болдог байж болж юм.

128. Эдгээр дутагдлуудын гол шалтгаан нь төсөв, санхүүгийн хязгаарлагдмал байдалтай холбоотой гэж үзэж байна.

6.2.3. Зээл тусламж хүртэгчийн сэтгэл ханамжийн түвшинг хэмжих

129. Энэ албан тушаалд 2 жил болсон одоогийн СТС-гийн гүйцэтгэх захирал, зээл, буцалтгүй тусламж авагчдын сэтгэл ханамжийн талаар судалгаа одоогоор аваагүй байна. Гэхдээ өмнөх удирлагатай харьцуулахад дор дурьдсан шалтгаануудын улмаас гомдол саналын тоо цэрсэн. Үүнд:

- Түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж байгаа;
- үр дүнтэй, бодлоготой үйлчилгээ үзүүлж байгаа;
- Хэрэглэгчдийг хүндэтгэн найрсаг харьцаж, үйлчилж байгаа зэрэг болно.

130. СТС-гийн ажилтан бүр оюутнуудын гомдлыг холбогдох дүрэм журмын дагуу барагдуулахын тулд ямар учраас хамрагдах боломжгүй гэдгийн тайлбарласан албан захидал үйлдэх үүрэгтэй. Гэхдээ гомдол санал барагдуулах талаар одоогийн үйл ажиллагааны журамд тодорхой зүйл заагдаагүй байна.

6.2.4. Нэн тэргүүнд зээл тусламж хүртэх оюутнуудын тодорхойлох нь


131. СТС нь тухайн жилд олгогдох нийт зээл, тусламжийн хэмжээг тогтоодог. Гэхдээ их, дээд сургуулиуд, коллежууд нь зээл, буцалтгүй тусламж олгохдоо ямар оюутныг эн тэргүүнд хамрах талаар тодорхой журам байдаггүй байна. Энэ талын заалт СТС-гийн үйл ажиллагааны журамд заагдаагүй бөгөөд үүний улмаас зээл, буцалтгүй тусламж нь шаардлагатай оюутнуудад хүрч байгаа эсэх нь тодорхойгүй байна.

132. Үйл ажиллагааны журмыг судлах, холбогдох хүмүүстэй уулзах явцад их, дээд сургуулиудын Шалгаруулах Комисс яг ямар үүрэгтэй гэдэг нь тодорхойгүй байна. Сургалтын алба нь бичиг баримтын үнэ зөв эсэхийг шалгадаг ба харин орон нутгийн засаг дарга нар амьжиргааны түвшний тодорхойлолтыг гаргаж өгдөг. Тийм учраас оюутнуудын хэн нь зээл, буцалтгүй тусламж авах давуу эрхтэйг тогтоох нь уг комиссын үүрэг болж байна. Гэхдээ, өнгөрсөн хугацаанд зээл, буцалтгүй тусламж авагчдын тоо хяналтын тоотой бараг ойролцоо байсан учир шалгаруулах комиссын үүрэг роль тодорхой гарч ирээгүй. Харин цаашдаа зээл, буцалтгүй тусламж авахаар өргөдөл гаргагчдын тоо нь хяналтын тооноос хэтэрвэл шалгаруулах комиссын үүрэг роль тодорхой болох юм.

6.2.5. Өргөдлийн шийдвэрлэх хугацаа

133. Сургалтын зээл, буцалтгүй тусламж нь хичээлийн жил эхэлснээс хойш 2.5 сарын дотор батлагдаж олгогддог. Жил бүрийн 10-р сарын 31-ны дотор их, дээд сургуулиуд нь хэн санхүүгийн тусламж авахыг шийдэж, 12-р сарын 15-нд СТС нь зээл авах өргөдлийг хянаж, зөвшөрсөн байх ёстой. Зөвлөхүүдийн ажил, үүргийн хуваарьт ихэнх орнууд гурван долоо хоногоос бага хугацаанд энэхүү асуудлыг шийдвэрлэдэг гэж заажээ. Зураг 8-д зээл, буцалтгүй тусламж олгох явц удаашралтай байгааг харуулжээ.

Зураг 8: Зээл тусламж олгох өргөдлийг шийдвэрлэх цаг хугацааны дүрслэл.



134. Цаг хугацааг удаашруулж буй хэд хэдэн хүчин зүйлс байна. Үүнд:

- Оюутнууд өргөдлөс гадна холбогдох бичиг баримтаар хангах үүрэгтэй учир их, дээд сургууль, коллежууд санхүүгийн жил эхэлтэл өргөдөл хүлээж авдаггүй, ихэвчлэн биечлэн өргөдөл авчирч өгдөг;
- Өргөдлийн нэгдсэн стандарт байхгүй. Өргөдлийг оюутнууд гараар бичиж өгдөг. Маш олон өргөдөл (нийт өргөдлийн 50-60%) шаардлагад нийцэхгүй, бүрэн бус гэсэн шалтгаанаар буцаагддаг;
- Бичиг баримтыг эхлээд их, дээд сургуулиудын сургалтын алба үнэн зөв, бүрэн эсэхийг шалгасны дараа СТС дахин хянаж шалгадаг нь ажлын давхардлыг үүсгэдэг;
- Гурван тал гэрээнд гарын үсэг зурах шаардлагатай;
- Санхүүжилтын сургуулиудад шилжүүлэх нь механик ажиллагаа ихтэй, хугацаа шаарддаг.

135. Хичээлийн жил эхлээд нилээд удасны дараа зээл, буцалтгүй тусламж шийдэгддэг учир бага орлоготой өрхийн оюутнуудыг их, дээд сургуульд орж, зээл, буцалтгүй тусламжийн өргөдөл гаргах байдлыг бууруулж байх талтай юм.

6.2.6. Суралцагчдын Сурлагын амжилтыг хянах, их, дээд сургуулиудыг сонгох Удирдлагын Мэдээллийн систем (УМС)

136. Excel-ийн хуудас ба зээлийн картын систем бүхий УМС нь үр ашиг муутай бөгөөд СТС-гийн идэвхитэй үйл ажиллагааг хязгаарлаж байна. Тухайлбал, зээлийн нарийвчилсан тайланг (зээлийн хэмжээ, хүү, эргэн төлөлт) гаргах боломжгүй.

137. Excel-ийн хуудас бүхий системийн хязгарлагдмал байдлаас шалтгаалан зээлийн хүү, түүний эргэн төлөлтийн талаар улирал бүр тайлан тооцоо гаргах боломжгүй. Ихэнх тохиолдолд оюутан зээлээ төлөхөр биеэр ирсэн тохиолдолд зээлийг нь тооцож өгдөг. Үүний улмаас дараах санхүүгийн үзүүлэлтүүдийг гаргах боломжгүй байна. Үүнд:

- Зээл батлагдсан хувь;
- Хугацаа хэтэрсэн ба төлөгдөгүй зээлийн хувь;
- Хүүгийн татаасын хэмжээ;
- Зээлийн эргэн төлөлтийн хувь.

6.2.7. Зээлийг эргэн төлүүлэх механизм

138. Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн эргэн төлөлт, суралцагчдаас гэрээгээр хүлээсэн үүргийнхээ биелэлтийг хангах явдлыг хязгаарладаг процессийн асуудлууд байна. Үүнд:

- Үйл ажиллагааны журамд зээлийн эргэн төлөлтийг хангах зарим нөхцөл тусгагдсан хэдий ч зээлийн эргэн төлөлтийг хангах тодорхой нарийвчилсан журам байхгүй байна.
- Ямар оюутан зээлээ эргэн төлж байна, ямар нь заасан газар ажил байна гэдгийг хянах тогтолцоо байхгүй байна. Олгогдсон зээлийг эргэж олж авах, оюутнуудыг зээлээ төлөхийг шаардах систем бүрэн төлөвшөгүйгээс болж зээлийн эргэн төлөлтийн хувь бага байна гэж бид үзэж байна.

139. Одоогийн байдлаар 1990-ээд оны эхэнд олгогдсон зээлийн дөнгөж 2.8% нь эргэж төлөгдсөн бөгөөд 2000 оны эхээр зээлийн эргэн төлөгдөх хугацаа дуусч байгаа юм (бүх зээлийн хувьд төгссөнөс хойшхи 7 дахь жилээс эхэлж хүү тооцогдох бөгөөд төгссөнөс хойш 10 жилийн дотор зээл бүрэн төлөгдсөн байх ёстой). 2004 онд Засгийн газар (2004 оны 2-р сар, Засгийн газрын 22-р тогтоол) 2003-2004 оны хичээлийн жилээс өмнө төгссөн бүх оюутнуудыг сургалтын төлбөрийн зээлээс хүүгийн хамт бүрэн чөлөлсөн. Өнөгийн ийм бодлого өрчлөгдөхгүй бол зээлийн эргэн төлөлт сайжрахгүй.

140. Гадаадад сурч буй оюутнууд (засгийн газрын гэрээгээр гадаадын их дээд суругуулиудад магистур, докторантад суралцаж буй) төгссөний дараа эх орондоо эргэн ирдэггүй, тэднийг хайж олоход хүндрэлтэй учраас, эдгээр оюутнуудын зээлийн эргэн төлөлтийн асуудал маш их анхаарал татаж байна. Гадаадад сурч буй оюутнуудын зээлийн хэмжээ дотоодын оюутнуудыхтай харьцуулахад өндөр, дунджаар 15,000 ам.доллар, зарим зээл 40,000 ам.долларт хүрэх явдал ч байдаг. Хэдийгээр зээлийн барьцаа гэж авдаг боловч зээлийг төлөх хугацаа нь болоход барьцааг олж авах буюу мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд төвөгтэй (жишээ нь машин, компьютер, мал ба компаний хөрөнгө гэх мэт) байдаг.

141. Зээлийг эргэн төлүүлэх зарчим арай чангарсан. Үүнд:

- 2003 оноос үл Хөдлөх Хөрөнгийн Газраас баталгаажигдсан байр, байшин гэх мэт үл хөдлөх хөрөнгийг барьцаа болгохыг зөвшөрдөг болсон;
- Зээлийн гэрээнд оюутнуудын үүргийг тодорхой зааж өгсөн;
- Засгийн газраас энэ асуудалд илүү чанга болсон тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн;
- Зээлээ төлөгүй оюутнуудын нэрсийг сонинд гаргадаг болсон.

142. СТС зээлээ төлөхгүй байгаа оюутнуудыг эрж олдог, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлдэг тусгай ажилтан байхгүй. Оюутнуудыг эрж олох явдал бэрхшээлтэй байдаг учир тэд зээлээ эргэн төлөх сонирхолгүй байдаг байна.

143. Зээлийг эргэн төлүүлэх механизм үр ашиггүй байгаагийн шалтгаан нь СТС нь хэрэгцээт мэдээллээр хангах оновчтой УМС-гүй байгаад оршино.

6.2.8. Хяналт ба Тайлан

144. Зээлийн хэрэгжилтийн хяналт ба тайлагнал хангалтгүй байна. Одоогийн байдлаар СТС стратегийн төлөвлөгөөгүй буюу менежментийн тайланг тогтмол гаргадаггүй байна. СТС-гийн үр дүнгийн гэрээнд заасан зээлийн төрөл ба төлөх хугацааг хүлээлгэж өгөх нь гүйцэтгэлийн гол шалгуур болж байна. 2004 оны 3-р сард анх удаа үр дүнгийн гэрээг тайлагнасан. Зээл тусламжийн хамрах хүрээ, үр ашиг, тогтвортой байдал ба хүрэлцээтэй холбоотой СТС-гийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар үүнээс өр тайлан байдаггүй байна.

6.2.9. Захиргааны үр ашиг

145. СТС-гийн ажилтнууд дээр дурьдсан тогтолцооны болон үйл ажиллагааны олон сул талуудыг төсөв санхүүгийн хязгаарлагдмал байдалтай холбон тайлбарладаг. Хүснэгт 10-д сүүлийн 5 жилийн СТС-гийн захиргааны төсөв ба сургалтын сангийн төсвийг харууллаа.

Хүснэгт 10: СТС-гийн захиргааны төсөв ба СТС-гийн зээл тусламжийн төсөв, 2000-2005

Он	СТС-гийн зээл, буцалтгүй тусламжийн төсөв (тэрбум төгрөг)	СТС-гийн захиргааны төсөв (тэрбум төгрөг)	СТС-гийн захиргааны төсвийн СТС-гийн зээл, буцалтгүй тусламжийн төсөвт эзлэх жин (хувь)
2000	6,200	11.7	0.19
2001	11,800	13.0	0.11
2002	13,300	16.7	0.13
2003	13,100	17.1	0.13
2004	13,900	18.2	0.13
2005	N/A	18.2	N/A

Эх сурвалж: СТС ба БСШУЯ

146. Хэдийгээр СТС-гийн захиргааны төсөв тасралтгүй өссөн ч гэсэн СТС-гийн зээл тусламжийн үндсэн төсөвтэй харьцуулахад маш бага байна (0.01%-иас бага). СТС-гийн захиргааны зардалд зээлтэй холбоотой их дээд сургуулиудын зардал ороогүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Сургууль бүр комисстой бөгөөд томоохон сургуулиуд сургалтын албандаа нилээд хэмжээний хөрөнгө зарцуулдаг. Их, дээд сургуулиудаас сургалтын зээл тусламжийн хөтөлбөртэй холбоотой гарч буй зардал 100 сая төгрөг гэж бид тооцоолж байна¹⁵. Их, дээд сургуулиудын энэ зардлыг СТС-гийн захиргааны зардалтай нийлүүлбэл тус сангийн төсвийн 1%-тай тэнцэж байна. Энэ нь ажил, үүргийн хуваарьт заасанаас бага байгаа бөгөөд 5-аас доош хувь зөвшөрөгдөх ба ихэнх хамгийн үр ашигтай хэрэгжиж буй хөтөлбөрүүд нь 3% байсан байна.

147. Бусад улс орны ижил сургалтын сангийн захиргааны үр ашигтай харьцуулахад Монгол улсын СТС 7 ажилтантайгаар 40,000 гаруй зээл, буцалтгүй тусламжийг зохицуулж байгаа нь харьцангуй үр ашиг багатай юм.

Хүснэгт 11: Бусад орны сургалтын сангийн захиргааны үр ашиг

Орон	Ажигласадын тоо	Зээлийн тоо
Венесуэл	120	5,000
Мексик	30	12,000
АНУ-ын Колорадо	125	90,000

¹⁵ 1,800 оюутан бүрт их, дээд сургуулийн сургалтын албанд нэг ажилтан, 58 их, дээд сургууль, коллежи бүрт шалгаруулах комисст нэг ажилтан ногдоно гэж үзвэл нэг хүнд 1.5 сая төгрөг зарцуулагдана. 2004 онд нийт 41,000 оюутан СТС-гийн хөтөлбөрт хамрагдсан.

6.2.10. Аудитын үйл ажиллагаа

148. Сүүлийн үеийн аудитаар зээлийн ситемийн ба хяналтын талаар томоохон доголдол дутагдал илрээгүй. Зээлийн эргэн төлөлттэй холбоотой бидний өмнө дурдсан асуудлуудыг баталсан. Хоёр тусдаа аудитын үр дүнг доор товч дурдлаа.

- Монгол Улсын Аудитын газар тус сангийн 2003 оны орлого зарлагын тооцоо, сангийн хуваарилалтын талаар аудит хийсэн. Үүний гол дүгнэлтүүд нь:
 - 2002-2003 оны хичээлийн жилийн СТС-гийн санхүүжилт цагтаа хийгдсэн.
 - СТС үүргээ цаг тухайд нь биелүүлсэн;
 - СТС нь санхүүжилтийг хүлээн авч, их, дээд сургуулиудад төлөвлөгөөний даруу хийсэн;
 - Оюутнуудын зээлийн эргэн төлөлтийн талаар цаашид судалгаа, шинжилгээ хийх шаардлагатай бөгөөд уг асуудлыг шийдвэрлэх арга замыг хайх нь чухал.
- Нягтлан бодох, татварын аудитын итгэмжлэгдсэн байгууллага (Тэд Аудит ХХК) нь 2003 оны 12 сарын 31-ний байдлаар СТС-гийн санхүүгийн тайланд мөн аудит хийсэн. Тэдний аудитын дүгнэлт “Бид тус сангийн 2003 оны 12 сарын 1-ний байдлаар санхүүгийн байдал, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээнд аудит хийгээд материаллаг бүх талаараа хангалттай гэж дүгнэж байна” гэсэн байлаа.

149. Аудитаар илрээгүй ч гэсэн, СТС-гийн үйл ажиллагааны журамтай танилцсаны үр дүнд бидний тооцоогоор зээлийн картын тогтолцооны материаллаг аюулгүй байдал нь СТС-г тодорхой эрсдэлд хүргэж байна.

- Ямар нэгэн нөц систем байхгүй учраас галын аюул эсвэл байгалийн гамшиг учирлаа гэхэд зээлийн бүртгэл эргэж сэргээгдэхгүйгээр бүр мөсөн устгах боломжтой.
- Эдгээр нь бичиг баримт хуурамчаар үйлдэх боломжийг олгож байна. СТС-гийн ажилтнуудын зүгээс санаатайгаар зээлийн картыг ямар ч гэрчлэх баримтгүйгээр авч устгах боломжтой

150. Эдгээр эрсдэлүүдийг анхааралдаа авч нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай.

6.2.11. Бүтэц, зохион байгуулалт

151. 5-р бүлэгт дурьдсанчилан сургалтын төрийн сангийн ажилтнууд холбогдох Засгийн газрын тогтоолын дагуу ажлын хуваарилалт хийж хариуцдаг бөгөөд зохицуулалтын ажил (өргөдөл, материалыг хянах, сургуулиудад санхүүжилтийг шилжүүлэх гэх мэт) эрхэлдэг учраас ийм ажил үүргийн хуваарилалт тохиромжтой байж магадгүй. Ийм тохиолдолд сургалтын төрийн сан нь мэдээлэл олон нийтэд түгээх, зээлийн эргэн төлөлтийг хангах гол ажлаа гүйцэтгэх үүрэгтэй. Дээр дурьдсанчилан эдгээр ажлууд нь өдөр тутам хийэд шаардлагатай төсөв санхүүгийн хомсдлоос болж орхигдсон гэж хэлж болохоор байна

152. Одоогийн бүтэц, зохион байгуулалтын нэг сул тал бол БСШУЯ болон сургалтын төрийн сан 2-ын хоорондын гүйцэтгэх үүргийн зааг тодорхой бус байна. Бүтэц, зохион байгуулалт, ажилтнуудын үр дүнгийн гэрээ болон үйл ажиллагааны журмаас харахад бодлого, үнэлгээний үүрэг роль болон үйл ажиллагааны үүргийн холбоог тогтооход бэрхшээлтэй байна. Тиймээс БСШУЯамнаас өрийн бодлогын гол үүрэгээс гаднах сургалтын төрийн сангийн үйл ажиллагаа болох төлөвлөлт, төсөв зохиох болон бодлого хэрэгжүүлэхэд илүү их оролцоож байна гэсэн эмзэглэл байна. Энэ нь сургалтын төрийн сангийн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 60 орчим хувь нь СЭЗЯ болон БСШУЯ-ны төлөлөгч нар байна. Тиймээс сургалтын сангийн хөтөлбөртэй холбоотой стратегийн чиглэл болон гол шийдвэрүүдэд нөлөлж байна. Нэг талаас бодлогын нөгө талаас үйл ажиллагааны үүрэг хүлээх нь Монгол улс 2000 оны эхээр батлагдсан төрийн эзэмшил болон худалдан авах зарчимтай зөрчилдөж байна.

7. Сургалтын төрийн сангийн тогтвортой ирээдүйг бүрдүүлэх: Санал болгож буй бодлогын шинэчлэлтүүд

153. Өмнөх бүлэгт оюутны сургалтын санхүүжилтийн хөтөлбөрийн бодлогын болон үйл ажиллагааны зарчимтай холбоотой сул талуудыг авч үзсэн. Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулахын тулд олон тооны чухал бодлогын болон үйл ажиллагааны асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай.

154. Монгол улсын СТС нь зөвхөн дээрх дурьдсан бэрхшээлүүдтэй тулгарч байгаа бус бөгөөд нилээд олон хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын хувьд үр ашигтай болон санхүүгийн тогтвортой оюутны зээлийн тогтолцоог нэвтрүүлэх нь тийм ч амар биш байна. Салмигийн үзэж байгаагаар тодорхой хэдэн үндсэн нөхцөлүүдийг хангаснаар санхүүгийн хувьд тогтвортой бөгөөд үр өгөжтэй хөтөлбөрийг буй болгож хэрэгжүүлэх боломжтой юм гэдгийг Дэлхийн Банкны туршлага харуулж байна. Ийнхүү амжилттай байхын тулд дараах хэдэн зүйлс нь маш чухал байна. Үүнд:

- Оюутны зээлийн хөтөлбөрийг сурталчилаж, хамрагдаж болох сургууль, оюутнуудын дунд өргөнөр таниулахын тулд маш сайн боловсруулсан мэдээллийн болон маркетингийн стратеги,
- Ямарваа нэгэн татаасын хэлбэрийн тусламжийг хамгийн хэрэгцээтэй (чадварлаг ба ахуйн хувьд хэрэгцээтэй) байгаа оюутнуудад чиглүүлэх тийм ил тод шалгуур үзүүлэлт,
- Зээл, буцалтгүй тусламжид хамрагдаж буй оюутнуудын сурлагын амжилтийг нарийн шалгах, хянах механизм,
- СТС-гийн урт хугацааны санхүүгийн тогтвортой ажиллагааг хангах зорилго бүхий нарийвчилан боловсруулсан зээлийн хүү болон татаасын бодлого,
- Зээлийг эргэн төлүүлэх үр ашигтай тогтолцоо, ялангуяа төлөгдөхгүй байгаа зээлийг багасгах зорилго бүхий хууль, эрх зүйн орчин,
- Бүрэн компьютержсэн удирдлагын мэдээллийн систем дээр суурилсан бүхий л чухал үйл ажиллагаа (оюутныг үнэлэх, шалгаруулах, сурлагыг хянах, зээл эргэн төлүүлэх ба санхүүгийн удирдлага)-ны үр ашигтай байгууллагын удирдлага,
- Тогтвортой удирдлагын баг.¹⁶

155. Энэхүү бүлэгт 6-р бүлэгт дурьдсан бодлогын асуудлуудыг шийдвэрлэх зорилго бүхий бодлогын өөрчлөлт шинэчлэлтийн хувилбаруудыг санал болгоно. СТС-гийн боломжит загварыг Зураг 10-т үзүүлсэн. Бүлэг 8-д СТС-гийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд авч үзэж болох шинэчлэлтийн хувилбаруудыг тодорхойлсон.

156. Эдгээр бодлогын болон үйл ажиллагааны шинэчлэлтийн хувилбарууд нь сургалтын төрийн сангийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, эрх тэгш байдлыг хангах, үр өгөж болон санхүүгийн ажиллагааг сайжруулахад чиглэгдэж байна. Ийм замаар шинэчлэгдсэн сангийн хөтөлбөрүүд нь Монгол улсын Засгийн газарт тавьж буй нийгмийн болон эдийн засгийн бодлогын зорилтуудаа хэрэгжүүлэхэд илүү их сайжирсан механизмыг бүрдүүлж өгнө.

157. Энэхүү санал болгож буй өөрчлөлтийн хамгийн чухал зарчим бол Монголын сургалтын төрийн сангийн хөтөлбөрүүд нь сурах чадвартай боловч ядуу оюутнуудад чиглэгдэж санхүүгийн дэмжлэг үзүүлж байх ёстой. Эдгээр хөтөлбөрүүд нь ийм оюутнуудад Монгол улс буюу дэлхийн аль ч улсад дээд боловсрол эзэмшихэд тулгарч буй санхүүгийн болон бусад бэрхшээлийг даван туулахад зориулагдсан байх ёстой.

¹⁶ Салми, Жамил (2003) *Оюутны зээлийн олон улсын Хандлага: Дэлхийн Банкны Туршлага*, Дэлхийн Банк, Вашингтон хот, х 14.

158. Тиймээс бүлэг 6-д дурьдсан сул талуудыг авч үзэхэд ямарваа нэгэн өөрчлөлт шинэчлэлт нь цогц шинжтэй байх ёстойг харуулж байна. Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулахын тулд хөтөлбөрүүдийг гол хэв маяг болон үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг (Жишээлбэл, зээлийн эргэн төлөлт болон хүүг тооцох механизм) өрчлөх нь илүү их үр дүнтэй. Түүнээс гадна үйл ажиллагааны зарим үе шатыг сайжруулах, хөтөлбөрийн чиглэлийг сайжруулах, одоогийн хүчин төгөлдөр буй бодлогын зарим асуудлуудыг хэрэгжүүлэх гэх мэт хязгаарлагдмал бодлогын шинж чанартай өөрчлөлтүүдийг хийснээр илүү их үр өгөжтэй байж болох юм. Жишээлэхэд, одоогийн байдлаар сургалтын сангийн хөтөлбөрт зээлийн хүүг тооцно гэсэн заалт орсон боловч түүнийг хэрхэн хэрэгжүүлэх, яаж төлүүлэх механизм нь байхгүй байна.

159. Сургалтын сангийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг сайжруулах бодлогын өөрчлөлтүүдийн талаарх зөвлөмжүүдийг дор дурьдав. Эдгээр нь нилээд дээд төвшингийн зөвлөмжүүд боловч өөрчлөлтийн чиг хандлага болон өөрчлөлт шинэчлэлтийн аливаа нэгэн хэрэгтэй шинж чанарыг тусгахаар нарийвчлан гаргасан. Дараагийн шатанд санал болгож буй хөтөлбөрүүдийн нарийвчилсан шинж чанар, хэв маягийг тодорхойлно.

7.1. Сургалтын төрийн сангийн зорилго бол ядуу боловч сурах чадвартай оюутнуудыг дэмжихэд чиглэгдэх ёстой

160. Бидний үзэж байгаагаар сургалтын төрийн сангийн зориги нь ядуу боловч сурах чадвартай оюутнуудад дэмжлэг үзүүлэхэд орших ёстой. 6-р бүлэгт дурьдсанчилан явцын дунд гаргасан Засгийн газрын тогтоолын дагуу төрийн албан хаагчийн хүүхдийн сургалтын төлбөр зэрэг нэмэгдсэнээр сургалтын төрийн сангийн санхүүгийн дэмжлэгийн чиглэл нь гол зорилгоосоо хазайсан байна. Сургалтын төрийн санд төрийн албан хаагчийн хүүхдийн төлбөрийн сангийн хөрөнгө шилжилж ирсэн ч гэсэн энэхүү хөрөнгө нь салангид биш учраас тодорхой хугацааны дараа сургалтын төрийн сангийн нэлээд их хувийг эзлэх эрсдэлтэй байна. Ялангуяа, төрийн албан хаагчийн хүүхдүүд бусад бүлгийн хүүхдүүдээс илүү мэдээлэл сайтай байдаг. Сүүлийн жилүүдэд төрийн албан хаагчийн хүүхдийн хэсэг нэлээд өссөх хандлагатай байгаа.

161. Дээрх өөрчлөлтийг хийснээр сурах чадвартай боловч ядуу өрхийг хүүхдүүдэд илүү их дэмжлэг үзүүлэх боломжтой болох бөгөөд нэг хүүхдэд ногдох тусламжийн хэмжээг ч нэмж болох юм. Энэ талаар мэдээлэл хязгаарлагдмал байгаа нь дэмжлэг авах эрэлт хэрэгцээ нэлээд их байгааг харуулж байгаа бөгөөд нэг оюутанд үзүүлж буй дэмжлэгийн хэмжээ тухайн оюутанд дээд боловсрол эхэмшихэд нь хангалтгүй байгааг харуулж байж ч болох юм (Бүлэг 6.1.6.-г үзнэ үү). Ийм маягаар чиглэлийг өрчилснөр Засгийн газрын зарцуулалтын эрх тэгш байдлыг дээшлүүлж тусламжийг бага орлоготой хэсэг рүү чиглүүлнэ.

7.2. Сургалтын сангаас төрийн албан хаагчийн хүүхдэд олгодог санхүүжилтийг зогсоох буюу багасгах

162. 7.1 -р бүлэгт заасан зөвлөмжийн дагуу сургалтын төрийн сангаас төрийн албан хаагчийн сургалтын төлбөрийг санхүүжүүлдэг байдлыг зогсоох, багасгах буюу өрчлөх шаардлагатай. Тодорхой нийгмийн чиглэлгүйгээр амьжиргааны төвшинг үл харгалзан ийм бүлгийг дэмжих нь хэрэгцээтэй хэсгийн боломжийг багасгаж байгаа бөгөөд төрийн бодлогын хувьд үндэслэл муутай юм. Төрийн албан хаагчийн хүүхэд нь ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд сургалтын төрийн сангийн хөтөлбөрт хамрагдаж байх ёстой.

163. Хэрэв Засгийн газраас төрийн албан хаагчийн хүүхдийг үргэлжлүүлэн дэмжих зорилготой байгаа бол одоогийнхоос илүү сайн хувилбаруудыг авч үзэж болох юм. Эдгээр хувилбаруудыг дангаар нь буюу эсвэл хамтад нь авч хэрэгжүүлж болох юм. Үүнд дараах хувилбарууд багтана:

- Сургалтын төрийн санд төрийн албан хаагчийн хүүхдэд зориулсан хөрөнгийн хэмжээг хамрагдах хүүхдийн тоог хязгаарлах, нэг оюутанд ногдох дэмжлэгийн хэмжээг багасгах, эсвэл төрийн албан хаагчид зориулсан нийт төсвийг багасгах;

- Төрийн албан хаагчийн хүүхдэд зориулсан хөрөнгийг тусгаарлан тусдаа сан болгох. Ингэснээр цаашид тохирсон төвшингэс нэмэгдэх боломжийг хязгаарлаж болох юм. (жишээлэхэд сургалтын санд шилжилж ирэх үеийн хэмжээнд);
- Төрийн албан хаагчийн хүүхдэд буцаан төлөгдөх нөхцөлгүйгээр буцалтгүй тусламж олгохын оронд буцаан төлөгдөх нөхцөл бүхий сургалтын зээл олгох.

164. Төрийн сангаас гадуур үлдсэн төрийн албан хаагчийн хүүхдийн дэмжлэгийг сургалтын сангаас өр байгууллага зохицуулах, эсвэл гэрээгээр сургалтын сангаар гүйцэтгүүлэх хэрэв шаардлагатай бол.

165. Сургалтын сангийн төрийн албан хаагчийн хүүхдэд зориулсан хэсэг нь төрийн албан хаагчид үзүүлж буй нэмэгдлийн гол хэсэг юм. Тиймээс энэ хэсгийг зогсоох буюу багасгах гэдэг нь тэдэнд цалингийнх нь хэмжээ буурч байгаа мэт сэтгэгдэл төрүүлж магадгүй. Үүнийг зогсоосноор чөлөлөгдөж буй хөрөнгийн зарим хэсгийг тэдгээрийн цалинг нэмэхэд зориулж болно. Энэхүү арга хэмжээ нь зөвхөн оюутан хүүхэдтэй төрийн албан хаагчдыг дэмжих биш харин бүх төрийн албан хаагчийг ижил хамрана.

7.3. Сургалтын төрийн сангийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг хэв загварыг хялбаршуулах

166. Бүлэг 6.1.2.-д дурьдсанчилан өнөөгийн сургалтын сангийн хөтөлбөрүүд нь шаардлагагүй олон янзын хэлбэр, үүрэг хариуцлага, ойлгомж муутай нэрлэвэрүүдтэй байна. Тиймээс эдгээрийг олон аргаар хялбаршуулж болно. Үүнд:

- Дээр дурьдсанчилан сургалтын төрийн сан нь ядуу боловч сурах чадвартай оюутнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Одоогийн байгаа 4-н ангилалын оронд 2 үндсэн ангилалтай байх бөгөөд эргэн төлөгдөх зээл ба эргэн төлөгдөхгүй буцалтгүй тусламж. Одоогийн байгаа ангилалын тооны үндэслэл тодорхой бус байна. Учир нь эргэн төлөгдөх нөхцөлгүй олон хэлбэрийн буцалтгүй тусламжийн хоорондын ялгаа бага байна.
- Сургалтын төрийн сангийн санхүүгийн хөтөлбөрүүдийг Засгийн газрын нэгдсэн ганц тогтоолоор зохицуулах. Ингэснээр бодлого болон зохицуулалт хоёр илүү уялдаатай болж хэлбэрийн хувьд тодорхой болно.
- Эргэн төлөгдөх зээл ба эргэн төлөгдөхгүй буцалтгүй тусламж хоёулаа сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг санхүүжүүлэх бөгөөд хамрагдах шалгуур нь сурлагын болон амьжиргааны төвшин дээр тулгуурладаг болно. Нарийвчилсан загварыг боловсруулахын тулд нэмэлт ажил шаардана.
- Шалгуур үзүүлэлт, олгогдох дэмжлэгийн хэлбэр цэрч цэгцтэй болно.
- Үзүүлж буй тусламж нь эмзэг бүлгийнх нь шинж чанар луу илүүтэй чиглэх, жишээлэхэд нэн ядуу өрхөд бүрэн хэмжээний туслалцаа үзүүлэх. Ингэснээрээ тухайн оюутны сул тал багасна. Ядуу бус өрхийн оюутанд туслалцаа үзүүлэхгүй байх.
- Үзүүлдэг дэмжлэгийн хэлбэрүүдийг шинэчлэн нэрлэснээр тухайн тусламжийн мөн чанарыг илүүтэй тусгана.
- Олон төрлийн тусламжийн нэрсийг өрчлөснөр тухайн тусламжийн мөн чанарын илүүтэй агуулж байх.


7.4. Сургалтын зээлийн хүүг тооцох арга хэлбэр үлэмж сайжруулах

167. Сургалтын зээлийн хүүг тооцох арга механизмыг хэлбэрийн болон хэрэгжүүлэлтийн хувьд үлэмж сайжруулах шаардлагатай. Ингэснээр төрийн зардлыг багасгаж оюутнуудыг зээлээ эргүүлэн төлөх хөшүүрэг болно.

168. Онолын хувьд сургалтын төрийн сангаас олгож буй сургалтын төлбөрийн зээл нь хүүтэй байх ёстой. (-р бүлгийг үзнэ үү). Гэвч бодит амьдрал дээр хүүг тооцож ногдуулдаггүй. Тиймээс ч зээлийн хүүг үлэмж хөнгөлддөг ба сургалтын сангийн далд татаас болж байна. Татаас гэдгээр бид зээлийн хүүг төсвийн хөрөнгийн зардлаас доогуур тогтоосон байгааг илэрхийлж байгаа юм. Үүнийг өнөөгийн инфляцийн төвшин, Монголбанкны хүү буюу арилжааны зээлийн хүү гэх мэт аль ч үзүүлэлтийг ашигласан ч үнэн болно.

169. Хөнгөлсөн зээлийн хүү нь түгээмэл биш байдаг. Ихэнх улс орнууд зах зээлийн хүүгийн хэмжээнээс доогуур тогтоох замаар хүүгийн хөнгөлөлт хийдэг (Зураг 9).

Зураг 9: Оюутны зээлийн хөтөлбөрийн бодит хүү, Орон ороноор



Source: Albrecht, D and A Ziderman (1992) *Deferred Cost-recovery for Higher Education: Student Loan Programs in Developing countries*, World Bank Paper No 137, Washington DC, p 15.

170. Тухайн оюутанд санхүүгийн дарамт үзүүлэхгүйн тулд зээлийн хүүг ихэвчлэн хөнгөлдөг. Энэ нь зээл авагчид хөнгөлөлт болдог боловч төрд зардал болдон байна. Оюутны зээлийн хүүг хөнгөвчилөх нь олон сөрөг үр дагавартай. Энэ нь ил тод бус, тодорхой чиглэлгүй оюутанд татаас олгох явдал юм. Түүнээс гадна зээлийн хөтөлбөрийн өртөгийг нэмэгдүүлдэг. Үлэмж хэмжээний татаас нь төрөс зээлийн хөтөлбөрийг нэмэлт шалгуур тогтоож оюутнуудын хамрагдах бололцоог хязгаарладаг.

171. Сургалтын төрийн сангийн хүрээнд олгогдож буй зээлийн хүүг тооцох аргыг дараах байдлаар сайжруулна:

- Эргэн төлөгдөх сургалтын зээлд оюутан хүү төлөх ёстой;
- Сургалтын зээл болгон нэг ижил хүү тооцно. Одоогийн байдлаар 2 өр хүү бодож байгаа;
- Аль болохоор хүү нь зээлийн өртөгийг тусгаж байх ёстой бөгөөд оюутанд татаас олгох механизм болох ёсгүй. Ямарваа нэгэн татаасыг ил тод олгох ёстой;
- Одоогийн байдлаар оюутнууд 6 жилийн дараа зээлээ төлж эхлэх боломжтой байгаа бөгөөд үнэндээ төгссөн хугацаанаасаа эхлэн зээлээ төлж эхлэх шаардлагатай. Ингэснээр оюутан боломжтой болсон даруйдаа зээлээ эргэн төлөх хөшүүрэг болно;

- Зээлийн хүү нь ил тод томъёоны дагуу бодогдох ёстой бөгөөд олон нийтэд нээлттэй зарлагддаг зах зээлийн хүү буюу инфляцийн төвшинтэй уялдаж байс ёстой. Боломжит хэмжүүрт Монголбанкны хүү буюу Улаанбаатар хотын хэмжээнд тооцогддог инфляцийн төвшин;
- Зээлийн хүүг тогтоохдоо тухайн үеийн зах зээлийн хүү болон ирээдүйд оюутан хэчнээн хэмжээний хүү төлж болох вэ гэдгийг харгалзана. Хүүг тодорхой интервал бүхий тогтсон хугацаанд тогтооно (жишээлбэл, улирал, 6 сар, жил тутам). Тухайн хичээлийн жил эхлэхээс өмнө хүүг тогтоох нь зүйтэй.

7.5. Сургалтын зээлийн эргэн төлөлтийн механизмыг үлэмж сайжруулах

172. 6.1.4-р бүлэгт дурьдсанчилан зээлийн эргэн төлөлтийн механизм нь үйл ажиллагааны болон хэв маягийн хувьд нэлээд их сул талуудтай байна. Тиймээс олгосон зээлийн маш бага хувь нь эргэн төлөгддөг. Өнөгийн байгаа тогтолцоог өрчлөх шаардлагатай. Ер нь үндсэн 2 төрлийн оюутны зээлийн хэлбэр байгаа ба янз бүрийн эргэн төлөлтийн нөхцөлтэй:

- Урт-хугацааны барьцаат зээл. Энэ нь бусад барьцаат зээлийн нэгэн адил тодорхой хугацаатай байх бөгөөд тогтсон эргэн төлөлтийн графиктай байдаг. Бусад жирийн зээлийн адил эргэн төлөлт нь тухайн хүний орлогоос хамаардаггүй. Энэ хэлбэрийн оюутны зээлийн хөтөлбөр нь Канад, Швед болон АНУ зэрэг 40 оронд байдаг бөгөөд 1950 ба 1960 оноос эхтэй байна.
- Орлоготой уялдсан зээлийн хөтөлбөрүүд. Эдгээр хөтөлбөрүүд нь тухайн зээл авагчийн орлоготой холбоотой зээлийн эргэн төлөлттэй байдаг байна. Жишээлбэл, оюутан нь сургуулиа төгссөний дараа орлогынхоо тогтсон хувийг зээлийн төлбөрт төлдөг. Хэрэв ижил хэмжээний зээлтэй 2 хүн байхад орлогынхоо төвшингөс хамааран харилцан адилгүй хэмжээний зээлийн төлбөр төлдөг. Тиймээс барьцаат зээлээс ялгаатай зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь янз бүр байна.

173. АНУ, Дани, Канад, Норвеги болон Япон улсууд барьцаат зээл маягийн хэлбэр ашигладаг байхад Шинэ Зеланд, Австрали болон Унгар орнууд орлоготой уялдсан зээлийн хэлбэрийг ашиглаж байна. Хүгнэгт 13-т оюутны зээлийн 3 хөтөлбөрийн шинж тэмдэгүүдийг үзүүлсэн байна. Эдгээрээс 2 (Гана болон Шинэ Зеланд) нь барьцаат зээлийн хөтөлбөрийг ашигладаг ба Онтарио нь орлогын төвшинтэй уялдсан зээлийн хөтөлбөрийг ашигладаг.

174. Оюутны зээлийн хөтөлбөрийг нэвтрүүлэх үндэслэл бол хөрөнгийн зах зээлийн дутуу хөгжсөн, хувийн зээлдүүлэгч дээд боловсрол эзэмших гэж буй оюутнуудад зээл олгох дургүйтэй холбоотой байдаг. Хүний нөцөд оруулсан хөрөнгө оруулалтыг биет хөрөнгийн нэгэн адил баталгаажуулах боломжгүй, зарим оюутнуудын ирээдүйд гаргах амжилт, орлогыг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг учраас хөрөнгийн зах зээл дутуу хөгждөг байна.

175. Тиймээс төрөс санхүүжигддэг буюу баталгаажуулдаг оюутны зээлийн хөтөлбөр нь оюутнуудад өрийнхө хүний нөцийн хөрөнгө оруулалтыг барьцаалан зээл авах боломж олгох замаар энэхүү зах зээлийн гажуудлыг давах гол хэрэгсэл болдог байна.

176. Дээр дурьдсан хоёр төрлийн эргэн төлөлтийн тогтолцоо нь зээлийн хөтөлбөрийг буйболгох үндэслэл болж байна. Орлогын төвшинтэй уялдсан хөтөлбөр нь бага орлоготой холбоотой нэг ёсны даатгал бөгөөд учир нь орлогын төвшингөс нь хамааран хүүг хүчингүй болгож болох юм. Хүснэгт 13-т оюутны зээлийн 3 хөтөлбөрийн гол шинж тэмдэгүүдийг үзүүлэв. Гана, Шинэ Зеланд болон Канадын Онтарио мужид хэрэгждэг эдгээр загварууд нь одоогийн байдлаар үйл ажиллагаагаа явуулж олон хөтөлбөрүүдийг харуулж байна.

177. Монголын зээлийн хөтөлбөр бол барьцаат зээлийн хэлбэртэй. Төрөс орлогын төвшинтэй уялдсан зээлийн хөтөлбөрийг нэвтрүүлж болох хэдий ч барьцаат зээлийнхээ энэ хэлбэрийг хадгалан үлдэж болох юм. Орлоготой уялдсан зээлийн хөтөлбөрийг дэмжигчид нь энэхүү тогтолцоог эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэх үр дагаварыг мэдэрч шингээх чадвартай байдаг хэмээн магтдаг. Хүснэгт 12-т үзүүлсэнчилэн Монгол улсад дундаж цалин эдийн засгийн салбараасаа хамаарч янз бүр байдаг бөгөөд 2000 оны байдлаар ХАА, ан агнуур, ойн салбарт 50,000 төгрөг, барилгын салбарт 100,000 байна.

Хүснэгт 12. Дундаж цалин хөлс, эдийн засгийн салбараар, 2000-2004

Эдийн засгийн салбар	2000 (мян. Төг)	2001 (мян. Төг)	2002 (мян. Төг)
ХАА, ан агнуур, ой	48.4	-	50.3
Уул уурхай	59.3	58.5	81.4
Үйлдвэрлэл	66.0	73.6	73.3
Цахилгаан, газ, ус	72.8	76.5	80.6
Барилга	70.2	76.7	103.0
Бөний болон жижиглэнгийн худалдаа	51.1	50.8	59.2
Зочид буудал, ресторан	62.9	86.6	89.0
Тээвэр, хадгалалт, холбоо	78.4	96.7	95.1
Санхүүгийн зуучлал	47.3	70.6	98.6
Үл хөдлөх хөрөнгө	50.5	67.0	55.2
Төрийн хамгаалал	56.7	59.7	71.5
Боловсрол	59.2	58.5	69.3
Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	43.7	47.9	53.9
Нийгмийн, олон нийтийн үйлэиогээ	38.7	46.6	55.6
Бүгд	62.3	67.4	75.5

Эх сурвалж: Статистикийн жилийн эмхэтгэл 2002, х 79.

178. Орлоготой уялдсан зээлийн хөтөлбөр нь зээл төлөгдөхгүй байгаа байдлыг багасгаж зээл авагчийн орлогын төвшинд зохицож аяндаа өрчлөгдөнө. Мөн түүнчлэн, энэ нь урт хугацаанд зээлийн эргэн төлөлтийг төлөвлөхөд туслах юм. Зарим талаар барьцаат зээлийн хөтөлбөрийн төлөгдөгүй зээлийн хувь хэмжээг тухайн хөтөлбөрийг үр ашигтай удирдсанаар багасгаж болно.

179. Орлоготой уялдсан зээлийн хөтөлбөрт сул талууд байдаг. Жишээлбэл, зээлийн эргэн төлөлтийг хураахад найдвартай татварын буюу тэтгэвэрийн тогтолцоо байх шаардлагатай байдаг. Түүнчлэн, энэхүү хөтөлбөр хувьд эхний жилүүдэд төлөгдөхгүй зээлийн хэмжээ үлэмж нэмэгдсэнээр улс төрийн асуудал үүсгэдэг бөгөөд улс төрийн шахалтан доор эдгээр зээлийг хүчингүй болгох буюу хөнгөлдөг байна.

180. Тиймээс Засгийн газар эдгээр 2 оюутны зээлийн хэлбэрийн давуу талуудыг үнэлэх хэрэгтэй. Ингэхдээ татварын болон тэтгэвэрийн тогтолцоо нь зээлийг эргэн төлүүлэх найдвартай хэрэгсэл болж чадах эсхийг тодруулах хэрэгтэй. Хэрэв чадаж байгаа бол орлоготой уялдсан зээлийн тогтолцоог нэвтрүүлэх. Энэ нь Унгарт саяхан нэвтэрсэн (Хайрцаг) ба Филиппин болон Ганад өмнө нь байсан.

Хайрцаг 1: Унгарын оюутны зээлийн хөтөлбөр

<p>Дэлхийн Банк нь 1998 оноос эхлэн Унгар улсын Засгийн газартай хамтран Дээд боловсролын реформ төслийг хэрэгжүүлж эхэлсэн билээ.</p> <p>Энэхүү реформын хүрээнд төрөөс баталгаажуулсан оюутны зээлийг 2001 оны 8-р сард нэвтрүүлсэн. Өрхийн буюу эх эцэгийн орлогын төвшингөөс үл хамааран бүх оюутнууд жил бүр зээл авах боломжтой бөгөөд уг зээлийн хүү нь инфляцийн төвшинтэй уялдсан байдаг. Зээлийн гэрээ хийгдсэн нэг оюутанд сард 42, 63, 88, 104 ам. доллар тус тус авах эрхтэй бөгөөд нэг семестрт дээд тал нь 520 ам. доллар авах боломжтой буюу жилийн нийт төлбөрийг бүтнээр авах ч бас боломжтой.</p> <p>Зээлийн хугацаа нь 5-аас 30 жил байх бөгөөд тухайн төгсөгчийн цалингийн хэмжээнээс хамаарна. Боловсролын яам нь санхүүгийн чөлөөт зах зээлээс хөрөнгийг зээл авч энэ хөтөлбөрийг санхүүжүүлдэг бөгөөд Оюутны зээлийн компаниар дамжуулан зээлийг олгодог байна.</p> <p>Эхний жилээ тус компани 70,000 оюутанд 56.8 сая ам. долларын зээл олгосон. 2002 он гэхэд 110,000 оюутанд нийт 93.75 сая ам. долларын зээлийг олгожээ.</p>
--

Эх сурвалж: http://www.gse.buffalo.edu/org/inthigheredfinance/region_europe_Hungary.html

181. Зээлийн эргэн төлөлт муу байгаагийн нэг томоохон хэсэг нь бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа явдал юм. Зээлийн эргэн төлөлтийг сайжруулахад чиглэгдсэн хөтөлбөрийн үйл ажиллагааны болон процесийн ямарваа нэгэн шинэчлэлт өөрчлөлтийг хөтөлбөрийн хэлбэрээс үл хамааран хэрэгжүүлэх шаадлагатай. Энэ талаар Бүлэг 8-т дэлгэрэнгүй авч үзсэн.

182. Засгийн газар зээлийн өрийг хүчингүй болгох явдлаас аль болох зайлсхийх ёстой. Энэ нь төсөв, санхүүгийн нилээд ачаалал буй болгодог гадна зээлдэгчдийг зээлээ эргэн төлөх явдлыг бууруулж ирээдүйд хүчингүй болгоно гэсэн хүлээлтийг бий болгодог. Мөн түүнчлэн, хүмүүсийн сэтгэхүйд оюутны зээлийн хөтөлбөр нь нийгсийн халамжийн нэг хэлбэр бөгөөд зээлийг эргэн төлөх шаардлагагүй юм байна гэсэн ойлголтыг төрүүлдэг.

Хүснэгт 13. Гаана, Шинэ Зеланд ба Канадын Сургалтын Зээлийн Хөтөлбөрийн Харьцуулалт

	Гааны Сургалтын Зээлийн Хөтөлбөр	Шинэ Зеландын Сургалтын Зээлийн Хөтөлбөр	Канадын Сургалтын Зээлийн Хөтөлбөр
Хөтөлбөрийн төрөл	Засгийн газраас шууд санхүүжүүлдэг	Засгийн газраас шууд санхүүжүүлдэг, Орлогоос хамаарсан зээлийн хөтөлбөр	(2000 оноос хойш) Засгийн газраас шууд санхүүжүүлдэг, Барьцаат зээлийн хөтөлбөр
Байгуулагдсан он	1970-аад онд анхны хэлбэрээр байгуулагдаж, 1980-аад оны сүүлээр одоогийн хөтөлбөр бий болсон.	1992	1964
Гүйцэтгэгч байгууллага	Нийгмийн Хамгаалал ба Үндэсний Даатгалын Итгэлийн Сан (НХҮДИС)	Зээл олгох асуудлыг Ажил ба Орлого Шинэ Зеланд, Зээлийг эргэн төлүүлэх асуудлыг Инландын Орлогын Хэлтэс хариуцна.	үндэсний Оюутны Зээлийн үйлчилгээний Төв (Канадын Хүний Нөцийн Хөгжил)
Шалгуур үзүүлэлт	Төрийн өмчийн сургууль өдрийн ангид суралцагчид	Өдрийн ба оройн ангид суралцаж байгаа оюутнууд, Зөвшөрөгдсөн төрийн ба хувийн их дээд сургуулиуд санхүүжилт авах эрхтэй.	Өдрийн ба оройн ангид суралцаж байгаа оюутнууд, Зөвшөрөгдсөн төрийн ба хувийн их дээд сургуулиуд санхүүжилт авах эрхтэй.

Тусламжийн хэлбэр	Байр, ном, сургалтын хэрэгслээ авахын тулд зээл авдаг. Зээлийн хэмжээг Засгийн газраас жил бүр тогтооно.	Сургалтын төлбөр, бар, амьжиргааны зардал ба ном авахын тулд зээл авдаг. Зээлийн хэмжээ ЗГ-аас тогтоосон сургалтын төлбөрийн дээд хэмжээтэй холбоотой тогтоогдоно. Зээл нь санхүүгийн хэрэгцээтэй холбоогүй. Оюутны зээл авах хугацаанд хязгаарлалт байхгүй.	Сургалтын зардал, байр, амьжиргааны зардал, ном ба хичээлийн хэрэгсэл авахын тулд зээл авдаг. Оюутнууд мужуудын оюутны зээл авах давхар эрхтэй. Санхүүгийн хэрэгцээ шаардлагатай холбоотой. Тусламж нь Канадын Сургалтын зээл тусламжтай холбоотой. Нийт 340 долоо хоног зээл авах эрхтэй.
Хүүгийн түвшин	Улирал тутам тогтоогддог. Одоогоор Засгийн газрын зээллэгийн хүүгийн түвшин, арилжааны банкны зээлийн хүүгийн түвшнээр тогтоогдсон.	Жил бүр тогтоогддог. Одоогоор 7%- Засгийн газрын зээллэгийн хүүгийн түвшингээс өндөр, гэхдээ арилжааны банкны зээлийн хүүгийн түвшингээс доогуур тогтоогдсон. Суралцах үедээ зээлийн хүү төлдөггүй. Орлого маш бага үед зээлийн хүүг тооцохгүй байж болдог.	Оюутан төгсөд зээлийн эргэн төлөх хугацааг тохирохын хамт хүүг тогтооно. Суралцах үедээ зээлийн хүү төлдөггүй. Төгсөгчийн орлого бага бол хүүг тооцохгүй байж болдог.
Эргэн төлөлт	Төгсөд ажилд гармагц төлж эхэлнэ. Сургалтын зээлийн итгэмжлэгч нь бэлэн мөнгөний хэлбэрээр буюу НХҮДИС-ийн төлбөрийн хэлбэрээр хийгдэж болно. НХҮДИС-д төлөх төлбөр Эргэн төлөх хугацаа янз бүр байж болно, гэхдээ 10 жилээс хэтрэхгүй.	Орлогоос хамаарсан зээлийн хөтөлбөр-зээлийн эргэн төлөлт тухайн жилийн орлогын хэмжээнээс хамаарна. Төлбөр татварын хэлбэрээр цалингаас суутгагдана. Санаачилгаараа төлж болно. Эргэн төлөх хугацаа заагаагүй – зээлийн төлөх хугацаа зээлийн хэмжээ ба төгсөгчийн жилийн орлогоос хамаарна.	Барьцаат зээлийн хөтөлбөр – Төгссөнөс 6 сарын дараанаас эхлээд зээлийг төлж эхэлнэ.
Бусад	Маш том, өсч буй хөтөлбөр-1999/00 оны хичээлийн жилд 50000 зээлдэгчтэй байсан. Зээлийн хэмжээ анх төлөвлөж байснаас их хэмжээтэй болсон.	Дээд боловсролын салбарыг бүхэлд нь хамарна. Томоохон хөтөлбөр – 2003 онд 150,000 зээлдэгчтэй, 5 тэрбум Шинэ Зеланд долларын авлагатай.	Дээд боловсролын салбарыг бүхэлд нь хамарна. Томоохон хөтөлбөр – 2000/01 онд 343,000 өдрийн ангийн зээлдэгчдэд 1.6 тэрбум доллар зээлдүүлсэн.

7.6. СТС-гийн тусламжийн хөтөлбөрт үргэлжлүүлэн хамрагдахын тулд сурлагын амжилтийг эргэн шалгуур болгон мөрдөх

183. Саяхан хүртэл төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдаж байсан оюутнууд гэрээгээ сунгуулахын тулд сургалтын өндөр амжилт үзүүлэх шаардлагатай байсан. Бүлэгт 6.1.-т дурьдсанчилан багш, оюутны харьцаанд муугаар нөлөлөхөс сэргийлж энэхүү заалтыг хүчингүй болгосон байна. Тиймээн Засгийн газар Бүлэг 6.1.1.-т зээсан шалтгаануудын улмаас СТС-гийн тусламжийн хөтөлбөрт үргэлжлүүлэх хамрагдахын тулд дээрх шалгуурыг эргэн мөрдөх шаадлагатай байна. Энэ бүлэгт дурьдсанчилан багш нарыг хахуульдах эсвэл айлган сүрдүүлэх зэрэг асуудлуудыг Засгийн газар болон тухайн сургуулиуд тусад нь авч шийдвэрлэх хэрэгтэй.

7.7. СТС-гийн тусламжийг зөв чиглүүлэх явдлыг сайжруулах

184. Бүлэг 6.1.5.-д СТС-гийн зээл, буцалтгүй тусламжийг чиглүүлэх өнөөгийн механизмтхай холбоотой нилээд олон асуудлыг дурьдсан. Үүнд эмзэг бүлэгт хамаарахыг тодорхойлсон хэтэрхий олон шалгуур үзүүлэлттэй, эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь зохих төвшинд тогтоогдсон эсэх болон амьдрал дээр хэрэглэдэж байгаа эсэх гэх мэт багтана. Сүүлийн үед СТС-гийн тусламжид хамрагдаж байгаа оюутнуудын тоо үлэмж нэмэгдэж байгаа нь энэ талын асуудлыг хөндөж үзэх нь зүйтэйг харуулж байна.

185. СТС-гийн зээл, буцалтгүй тусламжийг зөв зүйтэй чиглүүлэх талаар олон алхам хийж болно. Эдгээр нь СТС-гийн зээл, буцалтгүй тусламжийг зөв чиглүүлэх болон СТС-гийн үйл ажиллагааг хялбаршуулахад чухал ач холбогдолтой. Үүнд:

- Бүлэг 7.1.-т дурьдсанчилан СТС нь ядуу боловч сурах чадвартай оюутнуудыг дэмжих чиглэл рүү дахин анхаарлаа төвлөрүүлэх,
- Бүлэг 7.3.-т дурьдсанчилан СТС-гийн хүрээнд олгогдож буй тусламжид хамрагдах шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох шаардлагатай. Боломжтой бол цөхөн хэдэн оновчтой шалгуур үзүүлэлттэй байх,
- СТС-гийн хүрээнд олгогдож буй тусламжид хамрагдах эсэхийг тодорхойлохын тулд хөрөнгийг шалгах аргыг өргөн ашиглах.

186. Бүлэг 6.1.5.-д заасанчилан өнөөгийн тогтолцоонд орлогын төвшинг тодорхойлох нь албан бус эдийн засгийн их цар хүрээ болон орлогыг тодорхойлоход ашиглаж буй арга зэргээс хамааран бэрхшээлтэй байдаг. Тиймээс өнөөгийн орлого тодорхойлох тогтолцоог эргэн харах шаардлагатай. Их, дээд сургуулиудад энэ талаар илүү их үүрэг рольтой ажилуулж болох юм. Индонези, Хятад, Чили зэрэг орнуудын туршлагаас үзэхэд ийм хэлбэр нь санхүүгийн хэрэгцээтэй оюутнууд руу тусламжийг чиглүүлэхэд маш амжилттай болсон. Түүнчлэн, оюутнууд өрхийн болон эцэг эхийн орлогын тодорхойлолтоос гадна эмзэг бүлэгт хамаарах эсэхийг тодорхойлсон бас нэмэлт тодорхойлолт гаргана. Жишээлбэл, суралцаж байсан дунд сургуулийнхаа талаар мэдээлэл өгөх эсвэл өрхийн хөрөнгө, эцэг эхийн ажил эрхлэлт, боловсролын төвшин болон амьдардаг газар зэргийн тодорхойлолт гаргана. Эдгээр мэдээллийг аудитын үр дүнд шалгаж болох бөгөөд хэрэв хуурамч мэдээлэл өгсөн гэдэг нь тогтоогдвол цаашид тусламж үзүүлэхгүй байх.

187. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд цаашид тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай. Ойрын хугацаанд 700 малтай гэдэг шалгуур үзүүлэлтийг багасгах шаардлагатай. Энэ нь ядуурлын албан ёсны хэмжээ болон ялангуяа, төрийн санхүүжилтийг анх нэвтрүүлж байх үеийнхээс нилээд дээгүүр байгна.

7.8. Эмзэг бүлэгт үзүүлж буй тусламжийн хүрэлцээг эргэн харах

188. Засгийн газар нь хамгийн эмзэг бүлгийн оюутан хангалттай хэмжээний тусламж авч байхын тулд СТС-гийн тусламжийн хүрэлцээг эргэн харах шаардлагатай. Бүлэг 6.1.6-д дурьдсанчилан СТС-гаас үзүүлж буй тусламжийн хэмжээ болон их, дээд сургуульд суралцах зардал хоёрын зөрүү үлэмж байна. Ихэнх оюутнууд хувийн эх үүсвэрээр энэхүү зөрүүг төлж байгаа хэдий ч хамгийн ядуу буюу эмзэг бүлгийн оюутнуудад ингэх боломж үгүй юм.

Зураг 10. Оюутны тусламжийн хөтөлбөрийн тойм загвар

Оюутны тусламжийн хөтөлбөрийн эрхэм зорилго

Оюутны тусламжийн хөтөлбөрийн эрхэм зорилго нь ядуу боловч сурах чадвартай оюутнуудад санхүүгийн тусалцаа үзүүлэх явдал юм.

Оюутны тусламжийн хөтөлбөрт хамрагдах шалгуур үзүүлэлт

- Зөвхөн ядуу болон эмзэг бүлгийн өрхийн оюутнууд нь тусламжид хамрагдаж болох юм.
- Зээлийн хөтөлбөрийн хүрээнд тусалцаа үргэлжлүүлэн Continued assistance under the loan scheme would be linked to students' academic performance.
- ТАХ-ийн хүүхдүүд нь бусад бүх оюутнуудад тавьдаг шаардлагыг хангагүй тохиолдолд СТС-гийн хөтөлбөрийн тусламжид хамрагдах боломжгүй болно.

Оюутны зээлийн хэлбэр

- 2 төрлийн тусламжийг авах эрхтэй: эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл ба эргэн төлөгдөх нөхцөлгүй буцалтгүй тусламж. Энэ нь одоогоор 6 төрөл байна.
- Нэн ядуу оюутнууд эргэн төлөгдөх нөхцөлгүй буцалтгүй тусламж эрхтэй бөгөөд бусад нь эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл авах эрхтэй.
- Эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл ба эргэн төлөгдөх нөхцөлгүй буцалтгүй тусламж хоёулаа сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг даана.
- Нэг оюутанд ногдох тусламжийн хэмжээ нь сургалтын төлбөр (дээд хэмжээ хүртэл), оюутны өрхийн орлогын төвшин (эмзэгийг тодорхойлох хэмжүүр) болон оюутан нь гэртээ эсвэл гэрээс хол байгаа эсэхээс хамаарна.
- Зээл болон тэтгэлэгийн хэмжээ нь хоорондоо уялдах бөгөөд нэг хэлбэрийн тусламж авсанаар төдийчинээ нөгөө хэлбэрийн тусламжийн хэмжээ буурна.

Зээлийн хүүг тооцох

- СТС-гийн тусламжийн хөтөлбөрийн оюутны зээлийн хувьд хүү тооцогдоно.
- Өнөөгийн хүү тооцох тогтолцоонд 2 янзын хүү боддог бол өөрчлөгдөж 1 ижил хүү тооцогдоно.
- Зээлийн хүүг жилд ганц удаа тогтоох бөгөөд Монголбанкны хүү + 1 хувь. Зээлийн хүүг хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө тогтооно.
- Зээлийг хүүг өнөөгийн 7 дахь жилээсээ төлж эхлэх биш зээлээ авсаны даруй төлж эхлэнэ.

Оюутны зээлийн эргэн төлөлт

- Зээлээр төгссөн оюутан нь зээлээ эргэн төлөх буюу заасан газар ажилд орсоноор хүчингүй болгоно.
- Төгсөөд хувийн компанид ажиллаж буй оюутан болвол өөрийн цалингийн тодорхой хувийг зээлийн төлбөрт өгнө (жишээ нь цалигийн 10 хувь). Энэ нь 2 байдлаар илэрч болно: СТС нь тухайн төгсөгчийн цалингаас татварын тогтолцооны тусламжтайгаар шууд суутгана эсвэл ажил олгогч нь СТС-д хандан зээлийг оюутны цалингаас суутган төлнө.
- Төрийн албанд ажилд орсон оюутангийн цалингийн хэмжээ нь зээлээ эргэн төлөлтийн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд заасан хугацаанд ажиллаж хүчингүй болгох бөгөөд зээлийн тодорхой хэмжээг ажиллах хугацаанд дүйцүүлж хасна.
- Зээлийг эргүүлэн төлөх графикийг оюутан төгсмөгц харилцан тохиролцоно.

Хууль, эрх зүйн эрх мэдэл

- Оюутны зээлийн хөтөлбөрийн бүхий л асуудлууд Засгийн газрын шинэ тогтоолоор батлагдах бөгөөд үйл ажиллагааны дүрэм, журам нь шинэчилсэн үйл ажилаагааны журамд тусгагдсан байна. Одоогийн байгаа 96, 201, 158 and 290/310 Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд хүчингүй болно.

8. Үйл ажиллагааны загварын шинэчлэл

189. Бүлэг 7-д санал болгосон тусламжийн хөтөлбөрийн бодлогын шинэчлэлүүд нь СТС-гийн чадавхийг сайжруулах зорилго бүхий олон тооны санаачилагуудтай хамт хэрэгжсэн цагт амжилттай байх болно. Дээр дурьдсанаар санхүүгийн тусламжийн хөтөлбөрийн үйл ажиллагааг сайжруулахад амаргүй байх болно. Хөтөлбөрийн үндсэн бүтцийн сул талуудаас гадна захиргааны тогтолцоо болон үйл явцад сул тал байна. Хэсэг 6.2-т дурьдсан эдгээр сул талууд дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Зарим чиглэлээр (өргөдөл г.м.) үр ашиггүй үйл явц, зарим талаар бүрэн бус байдал (зээл авагчдын зээлийн хэрэгцээ шаардлагаар нь ангилсан ангилал, зээлийг эргэн төлүүлэх механизм зэрэг);
- Хангалттай УМС байхгүй байдал;
- Хэт түвэгтэй бөгөөд тодорхой бус үйл ажиллагааны журам;
- СТС-гийн захиргааны санхүүжилт хангалтгүй;

190. Энэ бүлэгт санхүүгийн тусламжийн хөтөлбөрийн захиргааны үр ашиг, байгууллагын хүчин чадал ба үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зарим арга замуудыг танилцуулах болно. Уг хөтөлбөрийн захиргааны өөрчлөлт нь уг хөтөлбөрийн үндсэн зорилготой нягт холбоотой юм.

“Суралцах чадвар сайтай, бага орлоготой оюутнуудын дээд боловсрол эзэмших боломжийг дээшлүүлэх ”


191. Энэ зорилгод хүрэхийн тулд бид захиргааны үр ашигтай ажиллах 5 стратегийн зорилтуудыг тодорхойлсон. Үүнд:

- Хамралт - буюу санхүүгийн тусламжийн хөтөлбөрийг зээл тусламж авах эрхтэй оюутнуудад таниулах;
- Тэгш зарчим - буюу зээл, тусламж илүү хэрэгцээтэй байгаа оюутнууд түрүүлж хамрагдах;
- Тогтвортой байдал – буюу суралцагчид зээлээ цаг хугацаанд нь хүүгийн хамт төлүүлж байх.
- СТС-гийн удирдлага, зохион байгуулалтад стратегийн арга хэрэглэх,
- СТС-гийн чадавхийг дээшлүүлэхийн тулд хүний нөц, материаллаг баазад хөрөнгө оруулалт хийх.

192. Хавсралт 6-д СТС-гийн нэг хуудсанд багтах стратегийн төлөвлөгөөг харуулсан бөгөөд түүний талаар Хайрцаг 2-т тайлбарлав.

193. Хавсралт 6-д СТС-гийн нэг хуудсанд багтах стратегийн төлөвлөгөөнд харуулсанчилан дээр дурьдсан стратегийн зорилтуудыг биелүүлэх зорилгоор СТС-гийн чадавхийг буй болгоход хөрөнгө оруулах шаардлагатай. Одоогийн байдлаар бүх хүч чаомайлт, хөрөнгө хүч оюутнуудын материалыг хянахад зарцуулж байгаа бөгөөд чиглэлээ тогтоох, хөтөлбөрийг сурталчлах болон оюутнуудын гэрээний үүргийн биелэлтийг хангахад чиглэгдэхгүй байгаагийн илрэл юм. Нэг хуудсанд багтах стратегийн төлөвлөгөөнд дурьдсан 15 чадавхийг хөгжүүлэх санаачилгыг 3 стратегийн зорилтын хүрээнд тодорхойлсон.

Хайрцаг 2. Нэг хуудсанд багтах стратегийн төлөвлөгөө



8.1. Хамралт - буюу санхүүгийн тусламжийн хөтөлбөрийг зээл тусламж авах эрхтэй оюутнуудад таниулах

194. Энэ зорилт нь зээлийн хэрэгцээтэй оюутнуудад, ялангуяа хөдөө орон нутагт ажилладаг оюутнуудад хөтөлбөрийн талаар танилцуулах, тэдний эрх үүргийг тодорхойлж өгөхөд оршино. Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мээдллийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн нарийн түвэгтэй байдлыг багасгах, хөтөлбөрийн сурталчилгааг сайжруулах болон оюутнуудын хөтөлбөрийн талаар сэтгэл ханамжийн түвшинг үнэлж дүгнэх механизмыг бий болгох зэрэг юм.

8.1.1. Судалгааны чадварыг дээшлүүлж, нэгдсэн мэдээллийн сан байгуулах

195. СЭЗЯ нь СТС-д оролцогчдын хандлагыг үнэлэх судалгааны чадвараа дээшлүүлэх шаардлагатай. СТС нь төсөв, санхүүгийн хязгаарлагдмал байдалтай байгууллага учир дээд боловсрол эзэмших сонирхолтой, зээл тусламж авах эрхтэй бүх оюутнуудыг хамарч чаддаггүй. Бидний бодлоор хөтөлбөрийн ажилтнуудын жил бүр гаргадаг төсөлөл болон бодлогын өөрчлөлт нь дараах чиглэлээр илүү өргөн мэдээлж байхыг шаарддаг. Үүнд:

- Хэрэгцээтэй байгаа хүмүүстээ хүрч байгаа түвшин'
- Хөтөлбөрт хамрагдах тоо хязгаарлагдмал тул зээл тусламж авч чадаагүй оюутнуудын хувь,
- Нийт зээл тусламж хүртэж байгаа хувь, өрөр хэлбэл, авах боломжтой боловч авч чадахгүй байгаа оюутнуудын тоо;
- Эхний 10%-д орсон оюутнуудын орлогын төвшин (энэ 10 хувьд багтаагүй боловч хамрагдаж болох бүх оюутны тоотой харьцуулсан),
- Сургалтын тусламжийн хөтөлбөрийн нийгэм эдийн засгийн нөлө;
- Хөтөлбөрийн зардал.

196. Оюутнуудын боловсрол ба хүн амын мэдээлэл, сурлагын амжилт, амьжиргааны түвшин, нас хүйс, гарал, боловсрол олгогчийн төрөл (их, дээд сургууль/коллеж, магадлан итгэмжлэгдсэн эсэх), сургууль төгссөний дараах орлого зэрэг мэдээллийг СТС-гийн тусламжийн ангилал тус бүрээр цуглуулах шаардлагатай. Оролцооны хандлага нь зээл яг эзэндээ очиж чадаж байгаа эсэхийг мэдэхэд тусална.

197. Мөн түүнчлэн хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд цуглуулсан оюутнуудын боловсрол, хүн амын мэдээллийг нэгтгэж, ингэснээр хөтөлбөрийн сахүүжилтын урсгалыг нарийн мэдэж байх боломжтой болно. Их, дээд сургуульд элсэгчдийн тоо нэмэгдэж байгаа учраас хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад төвлөрсөн төсвөс гадна бусад эх сурвалжийн санхүүжилт улам чухал болж байна. Үүнтэй уялдан, ингэснээр хөтөлбөрийн зээл тусламж авч байгаа нийгмийн ялгаатай бүлгүүдэд үзүүлэх нөлөг анги курс, мэргэжлийн чиглэлээрээ илүү нарийн судлахын тулд БСШУЯ-наас түүний загварын чадварыг сайжруулахад хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гэж бид үзэж байна. Энэ нь уг хөтөлбөрийн ирээдүйн төлөв байдал, үр дүнгийн талаар тодорхой төсөлөлтэй болгоход ач холбогдолтой.

8.1.2. Зээл тусламжийн төрлүүдийг оновчтой болгох

198. Бүлэг 7.3-т бид СТС-гийн хөтөлбөрийг энгийн хялбар болгох санал тавьсан билээ. Үүнийг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг анхааралдаа авах хэрэгтэй. Үүнд:

- Тусламжийн төрөл тус бүрээр тусгай зорилтуудыг боловсруулах;
- Зээл тусламжийн төрөл ба тоог үндэслэлтэй болгох тодорхой логик;
- Хөтөлбөртэй холбоотой шинэчлэлүүд нь хөтөлбөр практикт үр ашигтай хэрэгжих боломжтой эсэх, түүнд учирч буй саад бэрхшээлийг давах талаар нарийн мэдээлэл дээр үндэслэсэн байх.

199. Хэрвээ зээлийн хөтөлбөр төвөгтэй болгохоос зайлсхийж байгаа бол эдгээр үйл ажиллагааны зарчмууд нь маш чухал. Дор дурьдсан санал болгож буй үйл ажиллагааны шинэчлэл нь оюутны тусламжийн ангилал болон хэлбэрийн нарийн хатуу тодорхойлолтоос ихээхэн хамаарна.

8.1.3. Хөтөлбөрийг хөдөө орон нутагт хэрэгжүүлэхэд маркетингийн стратегийг ашиглах

200. Одоо байгаа маркетингийн стратегийг илүү өргөжүүлж, хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа тэлэх шаардлагатай. Үүнд:

- Оюутны зээл тусламжийн төрөл тус бүрээр мэдээллийг сурталчлах, таниулах;
- Оюутнуудад зориулж жижиг танилцуулгын товхимол гаргах;
- Сонирхолын бүлгүүдийн тусламжтайгаар хөтөлбөрийн үр дүн, амжилтыг сурталчлах;
- Сурталчилгааны ажилд их, дээд сургуулиудыг дайчлан оролцуулах;
- Оюутны зээлийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг авч болох вэбсайттай болох;
- Хөдөөгийн олон өрхүүд тог цахилгаан, телевизор байдаггүй ч, олон өрх радиотай учраас радиогоор сурталчилгаа явуулах,
- Зах зээлийн тусгай зориулалтын үүргийг бий болгох..

201. Маркетингийн эдгээд зорилтууд нь зээлийн эерэг орчинг бүрдүүлэхэд оршино. Төгсөгчдийн зээл, түүний хүүгээс чөлөлөх шийдвэр гаргасан нь сургалтын тусламжийн хөтөлбөрийн урт хугацааны тогтвортой байдалд муугаар нөлөлөгүй. Зээлийг эргэн төлөх хариуцлагын сэтгэлгээг хөгжүүлэх нь нэн чухал байна.

8.1.4. Оюутны сэтгэл ханамжийг үнэлж дүгнэх судалгаа тогтмол явуулах

202. Сургалтын тусламжийн хөтөлбөрийн талаар оюутнуудын сэтгэл ханамжийг үнэлж дүгнэх судалгаа нь маркетингийн стратегийн нэг хэсэг болж явагдана. Энэ нь 2 үндсэн зорилготой:

- “Хэрэглэгчдээс” авсан мэдээлэл нь тус хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг үнэлэх чухал хэрэгсэл юм;
- Оюутнуудын хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзсэнээр хөтөлбөрийг цаг тухайд нь сайжруулах хэрэгцээт мэдээлэлээр тогтмол хангагдана.

8.2. Шударга зарчим – Хэрэгцээтэй оюутнуудад хүрч ажиллах

8.2.1. Илүү үр дүнтэй механизм нэвтрүүлэх

203. Зээл тусламж илүү шаардлагатай байгаа оюутнуудад хүрч ажиллахад мэдээллийн сайн үндэс суурь хэрэгтэй. Гэхдээ сайн мэдээлэлтэй байх нь ганцаараа энэ зорилтод хүрэх нөхцөл болж чадахгүй. Тиймээс дараахь өөрчлөлтүүдийг санал болгож байна.

- Их, дээд сургуулиуд нь зээл авах оюутнуудыг шийдэхэд зориулж дагаж мөрдөх ерөнхий журам бий болгож, үйл ажиллагааны журамд тусгах хэрэгтэй;
- Гэр бүлийн эд хөрөнгийн хэмжээ, эцэг эхийн боловсролын түвшин гэх мэт оюутныг сургалтын төлбөрө төлөх илүү боломжтой болгож буй бусад шууд бус үзүүлэлтүүдийг харуулсан орон нутгийн засаг даргын тодорхойлолт, бусад орлогын эх үүсвэртэй эсэхийг тодорхойлох,
- Орон нутгийн засаг дарга нар (Улаанбаатар хотод хорооноос дүүргийн засг дарга, хөдөөд сум, аймгийн засаг дарга) орлогын түвшинг үнэн зөв тодорхолж байгаа эсэхийг шалгах жил бүрийн аудитын үнэлгээг тогтворжуулах.

8.2.2. Өргөдөл шийдвэрлэх процессыг стандартчилж, давхардсан үүргүүдийг хасах

204. Одоогийн өргөдөл шийдвэрлэх үйл явцыг оновчтой болгох шаардлагатай ба ингэснээр оюутнуудын өргөдлийн илүү богино хугацаанд шийдвэрлэх (2,5 сараас богино) боломжтой болно. Дараах өөрчлөлтүүдийг хийхийг санал болгож байна. Үүнд:

- Оюутны зээл хүссэн өргөдлийг интернэтээр бөглөх юмуу цаасан дээр хэвлэсэн стандарт загвартай болох, ингэснээр оюутнуудын бүрэн бус, буруу дутуу мэдээлэлтэй өргөдөл авахаас зайлсхийж чадна.
- Хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө оюутнууд нь урьдчилсан байдлаар батлагдаж Өнөгийн мөрдөж буй журмын шинэчлэснээр оюутнуудыг хичээлийн жил эхлэхээс өмнө өргөдөл гаргана. Зээл батлагдах эсэх нь дараах 4 нөхцлөр хамаарна:
- Оюутан өрийн хүсэлтээр магадлан итгэмжлэгдсэн сургууль элсэн орсон байх,
- Их, дээд сургуульд орсон эхний долоо хоногтоо өргөдөлө холбогдох бичиг баримтын хамт бүрдүүлсэн байх;
- Оюутны бүрдүүлсэн материалыг СТС дахин хянах шатлалыг хүчингүй болгох;
- Их, дээд сургууль, СТС-гийн гаргасан материалыг оюутан дахин оруулахаас зайлсхийх зорилгоор өргөдлийн эхлэл ба төгсгөлийн хэсгийг нэгтгэн ижилсгэх.

8.2.3. Оюутны санал гомдолыг шийдвэрлэх процессийг нэг хэвд оруулах

205. Олон оюутан Улаанбаатар дахь СТС-гийн албанд зээл тусламж авч чадсангүй, зээл туслаамийн түвшин хангалтгүй байна гэсэн гомдолтой ирдэг. Сангийн ажилчид оюутнуудын гомдолыг барагдуулах, холбогдох сургуульд нь уламжилж байх үүрэгтэй. Ерөнхийдө, СТС-гийн ажилчдад үйл ажиллагааны журамд тусгасан суралцагчдын зээл тусламж авах нөхцлүүдийг тусгасан гомдол саналын захидал гэж байдаг. Гэхдээ, нэг стандарт журам өнөг хүртэл байхгүй. Бид дараах өөрчлөлтүүдийг санал болгож байна. Үүнд:

- Оюутны гомдлуудыг загварчилж, үйл ажиллагааны журамд тусгана.
- СТС-гийн хүрээнд оюутнуудын өргөдөл гомлын барагдуулах тусдаа үүргийг бий болгож, оюутнуудтай мэргэжлийн, найрсаг үүднээс хандах чадвартай боловсон хүчний чадварыг дээшлүүлэх;
- Захидал, хариултыг нэгтгэн нэг стандартад оруулж, гомдлыг уялдаатай болгоно,
- Оюутнуудын зээл тусламж авах эрхийн шалгууруудыг үнэн зөв байлгахад их, дээд сургуулиудтай холбоотой ажиллах.

8.3. Тогтвортой үйл байдал: Оюутнуудаар зээлийг нь хугацаанд нь төлүүлэх

206. Дэлхийн банкны туршлагаас үзэхэд зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагааг ухамсарыг нь дээшлүүлэх, хар данс хөтлөх, барьцаа хөрөнгийг сонинд жагсаах. Иймэрхүү арга хэрэгслийг тухайн орны заншил соёлоос шалтгаалан ашиглаж болно¹⁷. Энэ талаар сургалтын төрийн сан тодорхой ажил санаачилан ажиллаж байгаа нь сайшаалтай.

8.3.1. Оюутнуудыг хянах, түүнийг хэрэгжүүлэх механизм

207. Сургалтын төрийн сан нь зээлээ төлөгүй мөн тэмдэглүүлсэн хаягийн дагуу олдохгүй байгаа оюутнуудыг эрж тогтоох болон зээлээ эргэн төлөх оюутнуудын хариуцлагыг нь ухамсарлуулах үйл ажиллагааны горимыг бүрдүүлэх хэрэгтэй. Саналууд:

- Төгссөний дараах орлого, ажлын байрны тухай мэдээллийг цуглуулах үе шатыг боловсруулах,
- Зээлээ эргэн төлөхгүй байгаа оюутнуудыг мөрдөн олж авах үр дүнтэй аргыг олох (2 айлын хаяг, холбогдох нэрсийг олох),
- Сонин хэвлэлээр дамжуулан зээлээ төлж барагдуулахгүй байгаа оюутнуудын нэр, хаягийг олон нийтэд мэдэгдэх,
- Зээлийн төлөлтийг сайжруулах талаар Засгийн газраас хатуу арга хэмжээ авахыг анхааруулах мэдээллийн кампанит ажлыг тогтмолжуулах,
- Өрө төлөхгүй байгаа гадаадад сурч байгаа оюутнуудыг эргэн эх орондоо ирэхэд саад хийх.

¹⁷ Салми, Жамил (2003) *Оюутны зээлийн олон улсын Хандлага: Дэлхийн Банкны Туршлага*, Дэлхийн Банк, Вашингтон хот, х 16.

8.3.2. Оюутнуудаар зээлийг нь түргэн төлүүлэхийн тулд зээлийн хүүг тогтоох механизмыг сайжруулах

208. Бүлэг 7.4-т дурьдсанчилан оюутны зээлийн хүүг тогтоох загварыг сайжруулах аргуудыг санал болгосон. Зээлийн хүүг тооцох, тогтооход бодлогын өөрчлөлттэй хамт дараах зүйлсийг анхааран үзэхийг санал болгож байна. Үүнд:

- Арилжааны банкны ханшийг хянах механизм, хүүгийн татаасын түвшинг тооцох,
- Хугацаа болосн даруй хүүг автоматаар тооцох,
- Зээлийн хүүг цуцлах журам,
- Энгийн болон байнгын эргэн төлөлтийг урамшуулах зорилгоор нийлмэл зээлийн хүүг бий болгох.

209. Удирдлагын мэдээллийн системээр зээлийн хүүг тогтоох механизмыг урамшуулах ёстой. Бүлэг 8.3.4 б-д удирдлагын мэдээллийн шинэ системд тавигдах шаардлагуудыг авч үзсэн.

8.3.3. Эргэн төлөлтийн шалгуурыг сайжруулах, албадан төлүүлэх горимыг чангатгах

210. Зээлээ эргэн төлөхгүй байх байдлыг багасгах механизм бий болсон нөхцөлд л тодорхой өөрчлөлтийг хийж болно. Одоогийн зээлийн өрийг цуглуулах механизм нь оюутнуудыг заавал өрсдийг нь биеэрээ сургалтын төрийн сан дээр ирүүлж зээлсэн мөнгийг нь төлүүлэх ёстой байдаг. Хэрэв оюутнууд өрсдө ирэхгүй бол зээлийг төлүүлж чадахгүй болно. Энэхүү механизм нь сургалтын төрийн сангийн ажилтнуудын хувьд маш их цаг зарцуулсан, үр дүн муутай байдаг бөгөөд оюутнуудад ч чирэгдэл учруулдаг. Шинэ механизм нь дараах үйл ажиллагааг хангах ёстой:

- Сургалтын төрийн сангийн ажилтнууд цаг тухайд нь хугацаа хэтэрсэн зээлийг мөрдөн мөшгих,
- Оюутнууд нь сургалтын төрийн санд мөнгө автоматаар шилжүүлдэг байх,
- Зээлээ төлж байгаа болон ажил хийж зээлээ барагдуулах сонирхолтой оюутнуудыг бүртгэх,
- Оюутны хувийн байдалд гарсан өөрчлөлтүүдийг хамрах тогтолцоо,
- СТС нь эргэлзээтэй зээлийг хүчингүй болгох буюу тооцох,
- Сургалтын төрийн сангаас хэдийгээр төлбөрийн чадвартай ч зээлээ төлөх хүсэлгүй байгаа оюутнуудын зээлийг албадан төлүүлэх.

211. Сургалтын төрийн сан дээрхи механизмыг өрийн хүчин чадалд тулгуурлан бүрдүүлэхээс гадна Өр Барагдуулах Албатай зээлийн өрийг албадан цуглуулах чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Дээрх сонголтуудын боломжит байдлын судалгааг хийх шаардлагатай.

8.3.4. Удирдлагын мэдээллийн системийг шинээр хөгжүүлэх

212. Оюутны тусламжийн хөтөлбөрийг хэрэгжилтэд мэдээлэл дутмаг, хомсдолтой байгааг энэхүү судалгааны явцад харагдлаа. Энэхүү судалгааны явцад шаардлагатай бүхий л мэдээллийг сургалтын төрийн сан, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам болон Санхүү, Эдийн Засгийн Яамнаас цуглуулсан билээ. Тэр тусмаа зарим нэгэн чухал мэдээллүүд бүрэн бус. Жишээ нь: 96-р тогтоолын дотор зээлийн нарийвчилсан мэдээлэл байхгүй. Учир нь одоогийн мэдээллийн систем нь гар аргаар боловсрогддог, хүний хүчин зүйлээс илүү их хамааралтайгаас мэдээлэл цуглуулах, эмхтгэхэд саад бэрхшээл ихтэй.

213. Одоогийн ашиглаж байгаа Эксел, Кард зэрэг гар ажиллагаа ихтэй системүүдийг илүү боловсронгуй автомат Удирлагын Мэдээллийн системээр шинэчлэн солих шаардлагатай. Боловронгуй болсон УМС нь доорхи үйл ажиллагаа явуулах боломжтой:

- Өгөдлийг зөвхөн нэг удаа оруулна,
- Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг харьцуулан жиших нэгдсэн мэдээллийн систем,
- Дээд зэргийн нэгдмэл байдал,
- Автоматжуулсан нэгтгэл,
- Өгөгдлийн давхцал, эх сурвалжийг багасгах,
- Сүлжээний мэдээлэл хайлт,
- Товч дарахад л хэрэгтэй мэдээллээ авах,
- Тогтмол давхар хадгалах төхөрөмж.

214. Удирдлагын мэдээллийн систем нь уг тусламжийн хөтөлбөрийн бүхий л мэдээллийг цуглуулах, хадгалах, тайлагнах боломжтой байх ёстой.(орлого, ажлын байрны судалгаа, бага орлоготой байсан үе, эргэн төлөх хугацаа, цуцалсан хэмжээ, зарим төрлийн тусламж авсан оюутны гадаадад байсан хугацаа). УМС нь мөн санхүүгийн гол үзүүлэлтүүдийг судлах боломжтой байх ёстой.(зээлийн зөвшөрөгдсөн хэмжээ, хугацаа алдсан болон төлөгдөхгүй байх түвшин, хүүгийн тэтгэмжийн түвшин гэх мэт) Хэрвээ эдгээр үйлдлүүдийг гүйцэтгэх боломжгүй бол энэхүү бүлэгт дурьдсан өр цуглуулах, албадан төлүүлэх талаар гаргасан санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх боломжгүй болно.

8.4. Стратегийн удирдлагын хандлагыг нэвтрүүлэх

215. Дэлхийн банкны туршлагаас үзэхэд аливаа СТС-гийн амжилт ба уналт нь манлайлал, удирдлагын дадал, тогтолцооны чанар, асуудал гарсан даруйд хурдан уян хатан шийдвэрлэх чадвар зэргээс хамаарна¹⁸. Бидний үнэлгээгээр бол СТС-д эдгээр амжилтын хүчин зүйлс одоогийн байдлаар байхгүй байна. СТС-д товч тодорхой стратегийг тодорхойлсон боловч стратегийн хүчтэй удирдлага маш чухал. Бид тусгай анхаарал шаардлагатай 4 чиглэлийг дор авч үзсэн.

¹⁸ Салми, Жамил (2003) *Оюутны зээлийн олон улсын Хандлага: Дэлхийн Банкны Туршлага*, Дэлхийн Банк, Вашингтон хот, х 21

8.4.1. Бизнес төлөвлөгөө зохиох, сургалтын төрийн сангийн үйл ажиллагааг тогтмол тайлагнах

216. Сургалтын төрийн сан нь одоогоор мэдээлэл болон стратегийн хоосон орон зайд ажиллаж байна. Тиймээс сургалтын төрийн сан нь заасан үр дүнтэй харьцуулахад хэр ажиллаж байгааг нь хянахад бэрх. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд нь дараах зүйлээс бүрдэнэ:

- Эрэлт болон чиглэлийн шалгуур үзүүлэлтүүд,
- Санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд,
- Байгууллагын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд¹⁹.

217. Хавсралт 3-аас мониторингийн нарийвчилсан шалгууруудыг үзнэ үү. СТС нь холбогдох шалгуур үзүүлэлтүүдээ сонгон жил бүр үйл ажиллагааныхаа тайланг гаргах шаардлагатай.

218. Үнэлгээ нь тайлагналын зардал\ашгийг мониторингийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлэх хийхийг бид зөвлөж байна. Энэхүү үнэлгээ нь оюутны зээлийн зөвшөрөгдөх загварын хүрээнд стратегийн бизнес төлөвлөгөөний дагуу хэзээ, яаж хийгдэхээс хамаарна.

8.4.2. Бүтэц, зохион байгуулалт болон ажиллагчдын чадавхийг уялдуулах

219. Бидний санал болгож байгаагаар сургалтын төрийн сангийн бүтэц нь санал болгож буй стратегитай уялдах хэрэгтэй. Стратегийн зорилгодоо хүрэхийн тулд маш сайн багийг бүрдүүлэх шаардлагатай. Стратегийн төлөвлөгөөнд тодорхойлсон үйл явцыг хариуцсан баг юмуу хувь хүн гүйцэтгэнэ. Одоогийн байгаа бүтцийг ийм байдлаар өрчлөх нь 2 чухал ач холбогдолтой. Нэгд, сургалтын төрийн сангийн ажилтнууд тодорхой үр дүнд хүрэхийн тулд үүрэг хариуцлагыг нь тодорхой болгоно. Хоёрт, ажилтнуудад өргөн хүрээнд харах боломж олгох бөгөөд нэлээд чухал сорилт болно.


220. 6.2.11-р бүлэгт заасанчилан СТС-ийн захирал мэдээлэл түгээх, зээлийн эргэн төлөлтийг хангах зэрэг ажлыг хийдэг. Хэрэв энэхүү хөтөлбөр нь ирээдүйд үр дүнтэй байя гэвэл СТС-ийн талаарх хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлж, оюутнууд зээлээ эргэн төлж, үүргээ биелүүлдэг болно.

221. Хавсралт 5-т үзүүлсэн нэг хуудас стратегийн төлөвлөгөөг үндэслэн СТС-гийн бүтцийн загварыг Зураг 11-т гаргасан.

222. Зохион байгуулалтын бүтцийн аливаа өөрчлөлтийг хийхдээ СТС-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвараа дээшлүүлэхэд нэмэлт эх үүсвэр шаардлагатай. Сургалтын төрийн сангийн ажилтнууд бизнесийн үйл явцад өрсөлдөх чадвараа дээшлүүлэх төлөвлөгөөтэй байх шаардлагатай. Дараагийн шинэ явцыг төлөвлөх хүртэл өрсөлдөх чадвараа тодорхойлох боломжгүй юмаа.

¹⁹ Салми, Жамил (2003) *Оюутны зээлийн олон улсын Хандлага: Дэлхийн Банкны Туршлага*, Дэлхийн Банк, Вашингтон хот, х 22

Зураг 11. СТС-гийн бүтцийн загвар



8.4.3. Бодлогын болон үйл ажиллагааны үүргийн хоорондын хариуцлагыг тодруулах

223. Одоогийн байдлаар СТС нь БСШУЯ-ны харьяа оюутны тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх газар хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. БСШУ-ны сайдаар ахлуулсан Удирдах зөвлөл нь СТС-гийн үйл ажиллагааг зохион байгуулж, сангийн хөрөнгийг захиран зарцуулж байна. СТС-гийн гүйцэтгэх захирал нь БСШУЯ-тай үр дүнгийн гэрээ байгуулж ажилладаг байна. Бүлэг 6.1.11-д дурьдсанчилан СТС-тай холбоотой бодлогын болон үйл ажиллагааны хариуцлагын тогтолцоо нь тодорхой бус асуудал байна.

224. БСШУЯ, СТС болон түүний Удирдах зөвлөлийн хариуцах үүрэг, хариуцлагыг тодорхой болгох үүднээс СТС-гийн үйл ажиллагааны шинэ загварыг бий болгох хэрэгтэй. БСШУЯ-ны хариуцах бодлогын үүрэг хариуцлагаас зааглахын тулд СТС-г төсвийн буюу улсын үйлдвэрийн газар хэлбэрээр ажиллуулах шаардлагатай. Хүснэгт 14-т Шинэ Зеландын төсвийн буюу улсын үйлдвэрийн газрын загварыг үзүүлэв.

225. Хүснэгт 14-өс үзэхэд төсвийн буюу улсын үйлдвэрийн газрын хэлбэр нь СТС-нд илүү бие даасан буюу үйл ажиллагааны хувьд илүү эрх чөлөтэй болгоно. Бидний үзэж байгаагаар СТС-гийн хувьд төсвийн байгууллагын хэлбэр нь улсын үйлдвэрийн газрын хэлбэрээс илүү их тохиромжтой юм. Учир нь СТС нь арилжааны үйл ажиллагаа бага явуулдаг бөгөөд хэрэв зөв зохион байгуулах юм бол бүрэн бие даасан байдал болон яамны шууд харьяа байх хоёрын дундажийг барьсан илүү их хүчтэй засаглалын болон хариуцлагын тогтолцоотой болно.

226. СТС-гийн үйл ажиллагааг илүү үр ашигтай бөгөөд өгөтэй явуулахын тулд удирдах зөвлөлийн тус сангийн эзэмшил болон худалдан авах сонирхолын зөрчлийг арилгах зорилгоор бие даасан зөвлөлийг байгуулах шаардлагатай. Гэхдээ энэ нь тодорхой үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд (Хавсралт 3-аас үзнэ үү) болон мониторингийн болон тайлагналын үр ашигтай тогтоолцоотой бол биелэх боломжтой. Ингэснээр БСШУЯ нь СТС-ийн үйл ажиллагааг бодитой дүгнэх боломжтой болно.

227. СТС-гийн бүтцийг өрчлөхөс өр нэг хувилбар бол хувийн хэвшлийн байгууллага болох банк буюу компаниар гэрээгээр гүйцэтгүүлэх явдал юм. Үүнийг зөв шийдвэрийг эсэхийг тодруулахын тулд энэхүү үйл ажиллагааг төр худалдан авах уу эсвэл өр хийх үү гэдгийг шийдэх хэрэгтэй. Ийнхүү гэрээгээр гүйцэтгүүлэхийн тулд гэрээг (үнэ, тоо ширхэг, чанар болон гүйцэтгэх хугацаа г.м.) маш тодорхой байлгах ёстойгоос гадна гэрээ биелэлтийг хянах, хариуцлага тооцох механизм нь маш сайн байх ёстой. Тиймээс ийм маягаар олон

хувилбаруудыг авч үзэн үнэлгээ өгөх шаардлагатай. Мөн түүнчлэн, СТС-гийн бүх үйл ажиллагаа эсвэл зарим нэгэн үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлж болох хувилбар байна.

Хүснэгт 14. Шинэ Зеландын төсвийн болон улсын үйлдвэрийн газрын тухай тойм мэдээлэл

	Төсвийн байгууллага	Улсын үйлдвэрийн газар
Төсөвтэй харьцаж буй байдал	Төсвийн байгууллага нь хууль, эрх зүйн хувьд төсвөс ангид байдаг боловч төсөвтэй байнга харьцдаг байна. Тэдгээр нь 1989 оны төсвийн санхүүжилтийн 4 дэх хэсэгт багтсанаар тодорхойлогддог.	Улсын үйлдвэрийн газар нь төсөвт шууд харьяалагддаг байна.
Зорилтууд	Тэдгээр нь зохицуулах, хагас хууль зүйн, үйлчилгээний болон арилжааны зэрэг олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Төрийн бодлогын болон арилжааны холимог шинж чанартай байдаг.	Төрийн бодлогын болон арилжааны холимог шинж чанартай байдаг. Тэдгээрийн зорилтууд нь нийгмийн, соёлын, төрийн болон арилжааны мэдэгдлийн шиж чанартай байх бөгөөд хариуцлагын тогтолцоотой байна.
Удирдлага, зохион байгуулалтын эрх чөлөний хүрээ	Өөрийн үйл ажиллагаа явуулахдаа үлэмж хэмжээний мэдэлтэй байдаг.	Өөрийн үйл ажиллагаа явуулахдаа үлэмж хэмжээний мэдэлтэй байдаг.
Хамардаг хэлбэрүүдийг	Төсвийн байгууллага дотроо 3 ангилалд: <ul style="list-style-type: none"> Төсвийн агентууд: Засгийн газрын бодлогыг үр дүнтэй болгохын тулд ажилладаг байгууллага Бие даасан төсвийн байгууллага: харьцангуй бие даасан хагас шүүхийн болон мөрдөн шалгах байгууллага Бие даасан төсвийн байгууллага: Засгийн газрын бодлогын талаар анхаарал тавьж ажиллах байгууллага 	Улсын үйлдвэрийн газар нь тавьсан зорилт, хуулийн дагуу байгуулагддаг.
Үйл ажиллагааны хяналт	Мониторингийн газар нь төсвийн байгууллагын хувьд яухал үүрэг гүйцэтгэнэ: <ul style="list-style-type: none"> Бодлогын болон хууль, эрх зүйн зөвлөгө өгөх Удирдах зөвлөлийн томилгоо Үйл ажиллагааны хүлээлт Үйл ажиллагааг хянах Яам, Засгийн газарт зөвлөгө өгөх 	Үйл ажиллагааг улсын үйлдвэрийн газрын мониторингийн хэлтэс Компаний хуульд засаглалын тухай заасан
Шинэ Зеландын жишээ	Шинэ Зеландын Чанарын хэрэг эрхлэх газар, газрын тээврийн аюулгүйн алба, иргэний нисэхийн эрхлэх алба	Шинэ Зеландын телевиз, эмнэлэг,

Эх сурвалж: Source: http://www.treasury.govt/crown_entity/paper3.asp. <http://www.ccmaw.govt.nz/croc/overview.asp>.

228. Бидний ойлгож байгаагаар Азийн хөгжлийн банкны төрийн салбарын удирдлагын шинэчлэлийн судалгааны хүрээнд хариуцлагын 3 загварыг авч үзсэн байна. Төсвийн удирдлага, санхүүжилтийн 1999 хуулийн төслийн 19-р зүйлд чиглэлийн яамдын сайд нь хэрэв тухайн агентлаг бүтээгдэхүүнээ илүү үр ашигтай ажиллана гэж бодсон тохиолдолд түүнийг байгуулах саналыг боловсруулна гэж заажээ.

8.4.4. Үйл ажиллагааны журмыг хялбаршуулах

229. Бид энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан үйл ажиллагааны журмыг засаж сайжруулсан. Гол засварууд нь:

- Тусламжийн ангилал тус бүрийн зорилтуудыг тодорхойлох,
- Журмын тогтоолын дагуу байсан хэлбэрийг өрчилж үйл ажиллагааны журмын дагуу болгох,

- Журмын гарын авлагын хэрэглэгчдийн хүрээг нарийн тодорхойлох. Боловсрол Шинжлэх Ухааны Яам, сургалтын төрийн сангийн ажилтнууд болон их, дээд сургуулиуд гэх мэт.. Одоогоор хэрэглэгдэж байгаа гарын авлага оюутнуудад зориулагдсан байна.
- Журмын гарын авлагын ялангуяа сүүл хэсгийн илүү дэлгэрэнгүй болгох. Журмын гарын авлагын дутуу буюу байхгүй байгаа хэсгийн ерөнхий бүтэц гаргаж өгсөн (эргэн төлөлт, хүү, зээлийн цуцлалт гэх мэт.)

230. Санал болгож буй бодлогын болон үйл ажиллагааны өөрчлөлтийн хүрээнд хийгдэх шинэ журамтайгаа тохируулан журмын гарын авлага шинэчлэх шаардлагатай. Санал болгож буй бодлогын болон үйл ажиллагааны хүрээнд одоогийн журмын гарын авлагыг түүнд тохируулан хийх боломжгүй юм. Үүнийг бодлогын болон үйл ажиллагааны шинэчлэлийн талаар тохиросны дараа хийж болох асуудал юм. Журмын гарын авлагын ерөнхий иж бүрдлийг Хавсралт 4-т үзүүлсэн болно.

8.5. СТС-гийн тогтвортой ирээдүйг бий болгоход хөрөнгө оруулалт хийх

231. Хүний нөц болон материаллаг баазад хөрөнгө оруулалт хийгүйгээр СТС-гийн үйл ажиллагааг сайжруулах боломжгүй. Дээр дурьдсан сул талуудыг байгаа гэж үзээд СТС-гийн захиргааны төсөвийг нэмэгдүүлэх шаардлагатай. Бага хэмжээний өөрчлөлт нь өнөөгийн тогтолцоо болон үйл ажиллагаанд сайжиралт үзүүлэхгүй.

232. Дээр дурьдсанчилан СТС-гийн төсвийн хязгаарлалттай байгаагаас шалтгаалан ихэнх цагаа өргөдөл материал хянахад зарцуулж байна. Хавсралт 6-дахь нэг хуудас стратеги нь ядуу боловч сурах чадвартай оюутныг дэмжих зорилгод хүрэхийн тулд хамрагдаж болох оюутнуудын дунд өргөн сурталчлах (Чиглэл 1) болон оюутнуудыг зээлээ хүүгийн хамт хугацаанд нь төлүүлэхэд (Чиглэл 3) их чармайлт гаргана. Энэ нь СТС-гийн үйл ажиллагааг санхүүгийн хувьд тогтвортой байлгахад чухал юм.

233. Бүлэг 6.2.9.-д заасанчилан СТС-гийн захиргааны зардал нь нийт сургалтын төрийн сангийн төсвийн ойролцоогоор 1 хувьтай тэнцэж байна. Ихэнх үр ашигтай ажиллаж буй сургалтын төрийн сангуудын захиргааны төсөв нь 3 хувь байдаг бөгөөд ийм түвшинд хүрэхийн тулд Монголын сургалтын төрийн сангийн одоогийн захиргааны төсөв болох 18.2 сая төгрөгийн доод тал нь 10 дахин өсгөх шаардлагатай.

234. Түүнчлэн, захиргааны төсвийг нэмэгдүүлэхээс гадна Бүлэг 7 болон 8-д тусгасан санал болгож буй бодлогын шийдэл, чадавхийг дээшлүүлэх санаачилгуудын ихэнх нь өмнө дурьдсан сул талуудыг шийдэхийн тулд удирдлагын чадавхи, тогтолцооны өөрчлөлт, үйл явцын загвар болон хэрэгжилтийн зардал зэргийг санхүүжүүлэх урьдчилсан хөрөнгө оруулалтыг шаардана.

235. Тиймээс захиргааны хувьд үр ашигтай, санхүүгийн хувьд тогтвортой оюутны сургалтын тусламжийн тогтолцоог бий болгохын тулд өнөөгийн үйл ажиллагаатай холбоотой эх үүсвэр болон сайжруулахад шаардагдах урьдчилсан хөрөнгө оруулалтын тоон судалгааг хийхийг бид санал болгож байна.

9. Дүгнэлт

236. 1990 ээд оны эхэн үеэс эхлэн Монгол Улсын дээд боловсролын салбар өөрчлөлт шинэчлэлт хийгдсээр өнөг хүртэл энэ хугацаанд багагүй дэвшил гарлаа. Сургалтын төлбөртэй болсон, оюутны тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа, дээд боловсролын салбарт хувийн хэвшлийнхэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн зэрэг нэлээд өөрчлөлт дэвшил гарсан байна. Буцалтгүй болон эргэн төлөгдөх нөхцөлтэй төрөл бүрийн тусламжуудыг үзүүлдэг санхүүгийн тусламжийн хөтөлбөр нь дээд боловсролын салбарыг өргөжүүлэн дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Гэвч сургалтын төрийн санд бодлогын болон орчны хүчин зүйлүүдээс шалтгаалан бий болсон хэд хэдэн сорилтууд гарч байна.

237. Энэхүү тайланг БШУЯ болон Дэлхийн Банкнд зориулан бэлтгэсэн болно. Сургалтын төрийн сангаас хэрэгжүүлж байгаа Монголын санхүүгийн тусламжийн хөтөлбөрийн хэрэгжилт түүний явцын тухай тоймлон, тус хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгийг танилцуулсан билээ. Тайландаа уг тусламжийн хөтөлбөрийн сул талуудын тухай судлан үзэж, сургалтын төрийн санг үр дүнтэй, шударга, тогтвортой байлгах зорилгоор бодлогын болон үйл ажиллагааны өөрчлөлт хийх хэрэгтэй талаар санал болгосон.

238. Санал болгож буй өөрчлөлтийн хүрээнд оюутны зээлийн хүү болон эргэн төлөлтийн механизм зэрэг гол чухал бодлогын хүчин зүйлүүдийг өрчлөн шинэчилэх ба боловсруулах санал тавьж байна. Үүнээс гадна одоогийн бодлогын хүрээнд ч хэрэгжүүлж болох бага хэмжээний бусад өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлага гарч байна. Дүгнэн хэлэхэд, зээлийн хөтөлбөрийн удирдлага, хэрэгжилтийг сайжруулах үйл ажиллагааны цогц өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлагатай байна.

Ашигласан материал

Албрехт, Дуглас ба Адриан Зидерман (1991) *Дээд боловсролын зардлыг нөхөн төлөх: Хөгжиж буй орнуудын оюутны зээлийн хөтөлбөр*, Дэлхийн банкны судалгааны ажил № 137, Вашингтон, Колумби муж.

Алтанцэцэг, Содномцэрэн (2002) *Монгол дахь Төрийн өмчийн Их Дээд Сургуулиудын Санхүү: Бэрхшээл ба Боломжууд*, МУИС, Нээлтэй Нийгэмлэгийн Сан

Монголбанк (2004) *Сар бүрийн эмхэтгэл*, 3-р сар www.mongolbank.mn

Тагнуулын төв газар (2003) *Монгол улсын тухайн үндсэн мэдээллүүд*
www.cia.gov/cia/publications/factbook

Эскола, Мери-Сиско ба Батхүү (2003) *Хөдөөлмөрийн зах зээл ба ажлын байрны үйлчилгээ судалгаа*, STAKES, Финланд улс

2000-2004 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Улаанбаатар хот

Монгол улсын Засгийн газар (2003) *ЭЗДЯБС*, Монголд хандивлагчдын уулзалт, 11-р сарын 19-21. Япон улс

Олон улсын валютын сан (2002) *Монгол улс: Статистикийн мэдээллүүд, ОУВС-гийн тайлан*, 02/253, Вашингтон, Колумби муж.

Лароке, Норман (2000) *Филиппины хувийн боловсрол: Зах зээл ба зохицуулалтын судалгаа*, АХБ, Манила, Филиппин

Боловсролын яам (2003) *Оюутны зээлийн сангийн жилийн тайлан*, Веллингтон, Шинэ Зеланд, 11-р сар, www.minedu.govt.nz.

Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яам (1999), *Боловсролын Салбарын Стратеги 2000-2005*, Монгол улсын Засгийн газар, Улаанбаатар

Үндэсний статистикийн газар (2004) *Статистизийн сар бүрийн эмхэтгэл*, МУ-ын ЗГ, Улаанбаатар хот, 3-р сар

Үндэсний статистикийн газар (2003) *2002 Статистизийн жилийн ном*, МУ-ын ЗГ, Улаанбаатар хот

Ньюперт, Рикардо (1992) *Монголын хүн амын өсөлтийн төсөлөл, 1989 – 2019*, НУБ-ын Ази, Номхон далайн орны хүн амын сэтгүүл, Боть № 7, № 4, 61-80 хх.

Отгонжаргал, Охидой (2003) *Mongolia*,
www.gse.buffalo.edu/org/inthigheredfinance/region_asia_Mongolia.htm

Салми, Жамил (2003) *Оюутны зээлийн олон улсын Хандлага: Дэлхийн Банкны Туршлага*, Дэлхийн Банк, Вашингтон хот

ЮНЕСКО (1995), *ЮНЕСКО Статистикийн эмхэтгэл 1995*, ЮНЕСКО хэвлэлийн газар, Парис.

Вайдман, Жон (1995) *Гуравдагч Орнуудын Дээд Боловсролын Системийн Санхүүгийн Асуудал: Кен ба Монголын жишээ*, Боловсролын бодлогын шинжилгээний архив, 3 дугаар дэвтэр, Дугаар 5, 1995 оны 2 сарын 24

Адриан Зидерман (1991) *Тайландын оюутны зээл: Үх ашиг, эрх тэгш, тогтвортой байна уу?*, Бодлогын судалгаа ба Ази дахь оюутны зээлийн талаарх ярилцлага цуврал, Боть 1, № 1, ЮНЕСКО, Банконг

Хавсралт 1:

Монгол Улс

Боловсрол болон Сургалтын Санг Сайжруулах Техникийн Тусалцаа

Ажлын Удирдамж

Удиртгал

Монгол Улсын Засгийн Газар нь их, дээд сургуульд суралцагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүднээс сургалтын төрийн санг бий болгосон билээ. Уг Сан нь Сургалтын Зээл болон Тэтгэлэгт хөтөлбөр гэсэн 2 хэсгээс бүрддэг. Сургалтын зээл нь 10 жилийн өмнөс эхэлсэн бөгөөд 8,500 оюутныг хамарсан нь тус сангаас дэмжлэг авсан нийт оюутнуудын 25 хувийг эзэлж байна. Дээд боловсролд оруулсан хөрөнгө рхуулалтын эдийн засгийн өгөж өндөр; хөгжиж буй орнуудад мэргэжлийн өндөр түвшний хүний нөц шаардлагатай бөгөөд төрийн/Засгийн газрын нөц хангалтгүй; эдгээр зээл нь дээд боловсролын санхүүгийн тогтвортой байдлыг бий болгодог; бага орлоготой оюутнуудыг суралцах бололцоогоор хангадаг (эрх тэгш байдлыг сайжруулдаг); хувь хүний сургалтын үр дүнг сайжруулдаг; дээд боловсролын байгууллагуудын дотоодын үр ашгийг дээшлүүлдэг; чанарыг сайжруулдаг зэрэг нь дэлхий нийтийн сургалтын зээлийн хөтөлбөрүүдийн үндэслэл болно. Тэтгэлэгт хөтөлбөр нь бага орлоготой өрхийн оюутан хүүхдүүдийг дээд боловсрол олоход дэмжлэг үзүүлдэг. Монгол улсад тус сангийн үр ашгийг хүртэгчдийг сонгох шалгуур нь орлого/ хөрөнгө чинээ (тэтгэлэгт хөтөлбөрт нийт хамрагдагсдын 40 хувь)-тай холбоотой хэд хэдэн үзүүлэлтийг батаадаг боловч хамрагдагсдын ихэнх нь төрийн албан хаагчдын хүүхдүүд байдаг²⁰.

Сургалтын зээл авагчдын тоо буурсан (нэг талаар 2000 онд тэтгэлэгт хөтөлбөрийг нэвтрүүлсэнтэй холбогдуулж). Энэхүү байдал болоод зээлийн эргэн төлөлтийн түвшин доогуур байгаа зэргээс уг хөтөлбөр санхүүгийн хувьд тогтвортой байх чадваргүйд хүрэх аюулыг бий болгож байна. Төрийн албан хаагчдын хүүхдүүдэд тэтгэлэг үзүүлэх хөтөлбөрт 2000 онд 12,262 оюутан хамрагдсан нь энэ онд 15,915 болж нэмэгдсэн бөгөөд цаашид хөтөлбөрийн сул талууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор үнэлгээ хийх нь чухал байна.

Дэлхий нийтэд амжилттай хэрэгжсэн сургалтын зээлийн хөтөлбөрүүд нь дараахь шинж чанарыг агуулдаг: үр ашигтай зохион байгуулалт, зохистой санхүүгийн гүйцэтгэл, сонгон шалгаруулалт болон сонгон шалгаруулалтын механизм ил тод, зээлийн эргэн төлөлтийн тогтолцоо үр ашигтай, удирдлагын мэдээллийн систем хангалаттай, сурталчилгаа сайн хийгдсэн, удирдлагын тогтвор суурьшилтай ажиллагаа.

Оюутны сургалтын зээлийн хөтөлбөрийн зорилго. Оюутны сургалтын зээлийн хөтөлбөрийн зорилго нь: (i) бага орлоготой, суралцах чадвартай оюутнуудыг төлбөрийн чадваргүйгээс болж суралцах боломжоос орхигдуулахгүй байх үүднээс тэдэнд санхүүгийн тусалцаа үзүүлэх оюутны сургалтын тогтвортой зээлийн тогтолцоог хөгжүүлсэнээр Засгийн газрын бодлогыг дэмжих. Хөтөлбөр нь (i) магадлан итгэмжлэгдсэн дээд сургуулиудад суралцаж байгаа бага орлоготой оюутнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, (ii) бага орлоготой оюутнуудад боловсрол эзэмших боломжийг адил тэгш олгох болон (iii) тогтолцооны санхүүгийн тогтвортой байдал болон түүний зохион байгуулалтын үр ашгийг дээшлүүлэх.

Хийх ажлын зорилго

Уг ажлын зорилго нь тус хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр ашиг болон тэгш байдлыг сайжруулах, хөтөлбөрүүдийн хамрах хүрээг өргөжүүлэх, оюутны сургалтын зээлийн хөтөлбөрийн санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх үүднээс Засгийн газарт техникийн тусалцаа үзүүлэх явдал юм.

²⁰ Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд гадаад орнуудад магистр, докторын сургалтад хамруулдаг ба ихэвчлэн төрийн албан хаагчид үүнд хамрагддаг. 1997 онд 79 хүн энэхүү хөтөлбөрт хамрагдсан бол 2002 онд 280 хүн хамрагдсан нь тус сангийн төсвийн 20%-тай тэнцэж байна.

Үүргүүд

Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд: (i) өргөдөл гаргагчдыг сонгоход хэрэглэх шалгуур, үүний дотор ядуурлын түвшинг хэмжих арга хэрэгслүүд, (ii) хөтөлбөрийн хамрах хүрээ, (iii) оюутнуудын сургалтын амжилт (хөтөлбөрт үргэлжлүүлэн хамрагдахад тавигдах шалгуур) болон сонгох их, дээд сругуулиудыг хянах Удирдлагын мэдээллийн систем болон (iv) захиргааны зардал²¹ болон аудитын үйл ажиллагаа зэргийг судлана.

Оюутны сургалтын зээлийн хүрээнд (i) хөтөлбөрийн санхүүгийн төлөвлөгөөг үнэлэх болон хөтөлбөрт хамрагдагсдаас авах бодит зээлийн хүүг тогтоох, (ii) зээлийн хэмжээ болон эргэн төлөх хугацааг тодорхойлох, (iii) өргөдөл гаргагчийн санхүүгийн хэрэгцээ, сургалтын амжилт зэрэг хэмжих хэрэгслүүдийг оролцуулан сонгон шалгаруулалтад ашиглаж байгаа шалгууруудыг судлах, (iv) хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох, (v) зээл авагчдын талаарх мэдээллийг багтаасан Удирдлагын мэдээллийн системд үнэлгээ хийх болон (v) зээлийн эргэн төлөлтийн механизм, хяналт болон тайлагнал, захиргааны зардал болон аудитын ажиллагааг хэргийг оролцуулан удирдлагын журмыг судлана.

Төслийн хэрэгжилтийн боломжит үзүүлэлтүүдэд дараахь орно. Үүнд:

А. Байгууллагыг бэхжүүлэх

Уг хөтөлбөрийг зохицуулах албаны удирдлагын зохион байгуулалт, одоогийн Удирдлагын мэдээллийн систем, түүнийг ажиллуулж байгаа хүмүүсийн сургалтын хэрэгцээ болон Санхүүгийн мэдээллийн системийг зохистой эсэхийг тогтоох үүднээс судалгаа хийнэ. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд (дотоод журмын чанар болон үр ашгийн хэмжүүр). Зээл авагчдын шаардлага хангасан байдал. Үйл ажиллагааны заавар зохистой эсэхийг тогтоох үүднээс үнэлгээ хийж, судалгааны явцад олж мэдсэн зүйлд үндэслэн өөрчлөлт оруулна.

Б. Оюутны сургалтын зээл

Сонгон шалгаруулалтын шалгуур болон зээлийг эргэн төвлөрүүлэх хэрэгслэлийг тодорхойлж, мэдээллийг судлах. Батлагдсан зээлийн өргөдөлийн тоо, үндсэн сургууль, сургалтын хөтөлбөр, хүйс болон яс үндэс, зээлийн дундаж хэмжээ, жил бүрийн статистикийн тоо мэдээг ашиглан хэрэгслүүдийг судлана.

В. Олон нийтийн сурталчилгааны компанит ажил

Оюутны сургалтын зээлийн төлөвлөгөөний талаар олон нийтэд сурталчилгаа хангалттай хийгдсэн эсэхийг тогтоох. Сурталчилгааны үзүүлэлтүүд нь (хөтөлбөрийн талаархи мэдлэг болон хүлээх үүрэг хариуцлагын тухай ойлголт).

2-р хэсэг: Явцын үзүүлэлтүүд

А. Санхүүгийн үзүүлэлтүүд. Зөвлөх нь дараахь явцыг тодорхойлно. Үүнд: Зээл олголтын хэмжээ - үүнийг дор хаяж жилд нэг удаа хийдэг байх ёстой; төлбөрөс зайлсхийх хэмжээ – сар бүр гаргадаг байх; төлбөрө төлөгүй хойшлуулсан болон төлбөрөс зайлсхийх хэмжээ (нийгэм-эдийн засгийн бүлэг, хүйс, байгууллага, сургалтын салбар/ хичээл болон зээлийн хэмжээгээр гаргах); зээлийн хүүгийн татаасын хэмжээ; зээл буцаан төлөлтийн хувь хэмжээ, удирдлагын зардлыг нийт зээлийн багцад харьцуулсан харьцуулалт (зарцуулалтын ангилалын хуваарилалт); хөрөнгө төсөвлөлтийн урсгал; капитал хөрөнгийн бодит үнэ цэнэ (нийт үнэ цэнэ/хөрөнгө), санхүүжилтийн эх үүсвэрийн хуваарилалт (хэрвээ Засгийн газрын төсвөс давсан бол); хөрөнгө оруулалтын өгөж болон Засгийн газрын эх үүсвэрээс хамааралтай байдал.

²¹ Тэтгэлэгт хөтөлбөрт эрх тэгш оролцоотой холбоотой асуудал байгаа нь зээл авагчдын . . . хувь нь төрийн албан хаагчийн хүүхдүүд байгаатай холбоотой. Ингэснээр төрийн албан хаагчдад нэмэгдэл орлого бий болж байгаа юм. 2000 оноос тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс Сангийн хөрөнгө нийт боловсролын салбарын төсвийн 10 хувьтай тэнцэхүйц болж өссөн.

Б. Биет үзүүлэлтүүд

Нөлөллийн үнэлгээний үр дүнд үндэслэн жил бүр судалгаа хийдэг эсэхийг үнэлэх Олон нийтийн сурталчилгааны компаниг ажлуудыг зохион байгуулдаг эсэхийг үнэлэх (жил бүр хийх ёстой)

3-р хэсэг: Нөлөллийн үзүүлэлтүүд

А. Ядуу болон бага ястангуудад боловсролын үйлчилгээний хүртээмж адил тэгш нэмэгдсэн эсэхийг үнэлэх.

Хүн амыг орлогын түвшинээр 5 бүлэгт хуваасан ангиллын доод 3 түвшний хүмүүсийн зээл авалтын хувийн жинг тооцсон эсэх (ө.х. зорилт: 75-80% (?)). Өөр нэг үзүүлэлт нь дараахь байж болно: арван бүлэгт хуваасан ангиллаар 9 дэх бүлэгт 2004 онд 50 хувиас илүүгүй, 2005 онд 40 хувь, 2006 онд 30 хувь

Б. Сургалтын зээлийн хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэх

Зээлийн өргөдлийг боловсруулах хугацааг багасгах арга замыг дэвшүүлэх. Зорилт: Ихэнх орнуудын жишгээр 3-аас цөн долоо хоногийн дотор байлгах

В. Сургалтын зээлийн хөтөлбөрийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх

Захиргааны зардлыг үнэлэх (үйл ажиллагааны зардлын нийт багцад эзлэх хувь); зорилт: 5% - иас бага бол зөвшөрөгдөхүйц гэж үзнэ. 3% бол бүр сайн үзүүлэлт бөгөөд үр ашигтай хөтөлбөрийн ихэнх ийм хувьтай байдаг.

Эргэж төлөгдөгүй зээлийн хувийг тогтоох. Зорилт: 10% -иас бага байх

Хүүгийн хувийг тогтоох. Зорилт: 2% -иас багагүй байх (Бодит хүүгийн хувь, ингэснээр хөтөлбөрт инфляцийн түвшинд гарах өөрчлөлтүүдийг тусгах хэрэгтэй болно.)

Тайлангууд

Зөвлөх нь дараахь тайлангуудыг боловсруулж гаргана: а) судалгааны гол ололтуудыг тайлбарласан тайлан, б) энэхүү томилогдсон ажлаас гарах зөвлөмжүүдийг тусгаж Үйл ажиллагааны гарын авлагыг хянан засварласан төсөл

Харилцан холбоотой ажиллах шаардлага

Зөвлөхтэй Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас хамтарч ажиллах гол хүн нь [нэр, албан тушаалыг бич, БСШУЯ шийдвэрлэнэ] байна. Зөвлөх нь Санхүү, Эдийн Засгийн Яамны [нэр, албан тушаалыг бич]-тай, мөн Төрийн Сургалтын Сангийн (Боловсролын сан) Дарга Пүрэвийн Лхагвасүрэнгтэй нягт холбоотой ажиллана.

Зөвлөх нь хуулийн бүх баримт бичгүүдийг үзэх эрхтэй бөгөөд судалгааг явуулахад шаардлагатай болон холбоотой гэж үзсэн бусад бүх мэдээллээр нь түүнийг хангана.

Зөвлөхөд Тавигдах Шаардлага

Ажлыг хоёр зөвлөхөс бүрдсэн баг гүйцэтгэх ба багийг ахлах эдийн засагч/ удирдлагын мэргэжилтэн удирдана. Түүний удирдлага дор үр ашгийн судалгаа хийсэн туршлагатай санхүүгийн менежментийн мэргэжилтэн ажиллана.

Гэрээний зохион байгуулалт

Ажил нь 2003 оны 6 сард эхлэх төлөвлөгөөтэй бөгөөд эцсийн тайланг 2003 оны 8 сарын сүүл гэхэд боловсуулсан байна. Ажлыг гүйцэтгэхэд ойролцоогоор 12 хүн/ сар шаардагдана. Гэрээнд замын зардал, байр, амьжиргаа, аман болон бичгийн орчуулга зэрэг бүх зардлуудыг тусгана.

Удиртгал

Монгол Улсын хувьд өнгөрсөн хугацаанд боловсролын салбарт зарцуулж байсан хөрөнгөс бага хэмжээний хөрөнгөр боловсролын түвшин болон бичиг үсэг тайлсан байдлыг түвшинг өндөр хэвээр байлгах томоохон зорилт тулгарч байна.

Түүхэн замналын хувьд Монгол Улс нь боловсролын салбарт улсын хөрөнгийн ихээхэн хувийг зарцуулсаар ирсэн. 1990-ээд оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих энэхүү бэрхшээлтэй шилжилтийн үед Монгол Улс хүүхэд бүрт чанартай анхан шатны боловсролыг үнэгүй хүргэж байсан билээ. Тухайн үед боловсролын болон бичиг үсэг тайлсан байдал, сургуульд хамрагдалтын түвшин өндөр байсан байна.

Шилжилтийн эхний жилүүд нь гэнэтийн хүнд цохилтын шинжтэй байснаас тэдгээр жилүүд боловсролын үр дүнд нилээд сөргөр нөлөлсөн. Улсын орлого, бүтээгдэхүүн огцом бууралт, мөнгөний ханшны эрс уналт нь ядуурлын түвшинг огцом нэмэгдүүлж, ажилчдын цалин хөлсийг муутгасан байна. Хувьчлал болон төрөс өгөх татаас үгүй болсон, үнийн хэлбэлзэл зэргээс үнийн өсөлт нэн ялангуяа эрчим хүчний салбарын үнийн өсөлтөс үйлчилгээний өртөг нэмэгдсэн. Малыг хувьчилснаар хүүхдийн хөдөөлмөр эрхлэлт нэмэгдэж, эрэгтэй хүүхдүүдийн сургууль завсардалт нэмэгджээ. Боловсролын салбарт олгодог байсан төрийн зарлага ДНБ-ний 11% -иас 7% хүртэл буурсан. Төвлөрлийг бууруулж, аймаг, орон нутгийн засаг захиргаа ерөнхий боловсролын зардлыг хариуцах хүндхэн үүргийг авсан. Сургууль болон дотуур байрнууд хаагдаж, цалингийн бус санхүүжилт огцом буурч, хувийн боловсролын зардал асар өсөж, дэд бүтэц засвар үйлчилгээгүй, үндсэн хэрэглээний зүйлсийг олж авахад гадны тусламжид (голдуу зээлийн хэлбэрээр) найдах явдал нэмэгдсэн. Боловсролтой болох боломж харьцангуй болж ирсэн. Сургууль завсардалт ялангуяа хөвгүүдийн дунд ихэссэнээс ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт багасжээ.

2000 оны байдлаар ДНБ-ний нэг хүнд ноогдох хувь тодорхой хэмжээгээр сайжирсан хэдий ч ядуурал, ялангуяа Улаанбаатар хотод харьцангуй нэмэгдсэн байна. Ажилгүйдлийн түвшин голчлон ажил мэргэжилгүй хүмүүсийн дунд өсжээ. Төрөс боловсролын салбарт гаргаж буй зарлага нэмэгдэж ДНБ-ний 7.5%-тай тэнцэхүйц болсон нь олон улсын стандартын дагуу өндөр байна. Шилжилтийн өмнөх үетэй харьцуулахад зарлага голчлон орон нутгийн түвшинд (анхан болон дунд боловсрол) буурсан байхад төв засгийн газрын үйл ажиллагааны (их, дээд сургуулиуд, сургалтын сан) зарлага нэмэгдсэн. Ерөнхий боловсролын сургуульд хамрагдах байдал тодорхой хэмжээгээр нэмэгдсэн хэдий ч шилжилтийн өмнөх үед байсан түвшинд хүрэхгүй байгаа нь ядуу айл өрхийн хүүхдүүд, мөн түүнчлэн хөдөө орон нутагт ядуу биш боловч мал ихтэй айлуудын хөвгүүд сургуульд явахгүй байгаатай холбоотой. Дээд боловсролын хувьд төрөс санхүүжүүлэх хүнд ачааг бууруулах үүднээс их, дээд сургуулиудыг сургалтын төлбөрийн хэмжээг өрчлөх, өр эх үүсвэрээр орлого олохыг зөвшөрсөн байна. Хувийн их, дээд сургуулиудыг бий болгох хууль зүйн орчинг бүрдүүлж, төрөс сургалтын тэтгэлэг, зээл олгох явдал нэмэгдсэн. Их, дээд сургуулиуд санхүүжилтээ өрсдө хийдгийн хувьд улс төрийн болон хууль зүйн үүднээс бие даасан болох эрмэлзэлтэй болсон. Үүний үр дүнд Засгийн газар нийгмийн салбарыг хувьчлах асуудлыг авч үзэх болов. Туршилтын журмаар нэг сургуулийг (Санхүү, эдийн засгийн дээд сургууль) менежментийн гэрээгээр хувьчлаад байна.

Дунд хугацаанд орлогын түвшин хязгаарлагдмал хэвээр байх болно. Өсөлтийн хувь хэмжээ төдийлэн их биш буюу ДНБ-ний жилийн бодит өсөлт 4-5% -тай байхаар байна. Монгол Улс болон Лаос улсууд нь нэг хүнд ноогдох гадны зээл, тусламжийг хамгийн их авдаг орнууд ба цаашид энэхүү нэг хүнд ноогдох түвшин одоогийнхоос төдийлэн нэмэгдэхээргүй байна. Үндсэн зорилго нь бүх залуучуудад ерөнхий боловсролтой болгох явдал ба үүний сацуу боловсролын чанарыг сайжруулж, дээд боловсрол олох боломжийг өргөжүүлэх, Монголын боловсролын түвшинг олон улсын стандартанд хүргэх явдал билээ.

Энэхүү техник туслалцааны зорилго нь Дэлхийн Банкнаас хийсэн Төсвийн зарлагын судалгааг гүнзгийрүүлэх, ялангуяа боловсролын салбарт гаргаж байгаа төсвийн зарлагын үр ашиг, адил тэгш байдал, ядуурлыг бууруулахад үзүүлэх нөлө зэрэг боломжийг олж илрүүлэхэд БСШУЯ-нд туслах явдал юм. Энэхүү судалгаа нь Засгийн газрын ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах стратеги болон БСШУЯ-ны Боловсролын бүхий л төлөвлөгөө болон салбарын бодлогыг боловсруулах зэрэгт хувь нэмэр болох учиртай.

Судалгаа дараахь чиглэлийг судлахыг голчлон анхаарна:

- Боловсролын салбарт гаргаж буй зарлага нь тухайн салбарын бодлогыг тэргүүлэх чиглэл/ зорилготой нийцэж байгаа эсэх
- БСШУЯ-ны бодлогын тэргүүлэх чиглэлийн дунд хугацааны төсвийн нөлөлөл
- Одоогийн боловсролын тогтолцооны өртөг болон орлогын бүтэц
- Одоогийн хэрэглэж буй норматив болон төсвийн төсөлөл хэр нийцтэй эсэх
- Засгийн газрын боловсролд гаргаж буй зарлагын хэдэн хувь нь аймаг, сумдын сургуулиудад очдог болон цаг тухайдаа хүрдэг эсэх
- Нэмэлт татаас нь хэнд тэтгэмж болдог вэ (хүнс, хичээлийн хэрэгслэлийн тэтгэмж, сургалтын тэтгэлэг, сургалтын зээл гэх мэт) ядуучуудад хүрдэг эсэх
- Төсөвлөлт болон төсвийн зарлагын удирдлагаас үүдэн үйлчилгээ үзүүлэхэд гардаг аливаа бэрхшээл, хязгаарлалтууд
- Санхүүжилтэнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх боломж, бүх шатанд, ялангуяа дээд боловсролын түвшинд хэр хүрч байгаа

Ядуурлын асуудалд чиглэх явдлыг нэмэгдүүлэх, хөрөнгө нөцийг аймаг, дүүрэг болон сургуулиудад хэрхэн хуваарилах боломжийн талаарх томъёолол, хөрөнгө нөцийн урсгалын үр ашиг, зарлагын үр дүнг нэмэгдүүлэх үүднээс төсвийн зарлагын удирдлагыг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж гаргах.

Үр ашиг –

Үр дүн-

Адил тэгш байдал –

Судалгаанд дараахь асуудлуудыг хамруулах ба заавал энэхүү дарааллаар байх шаардлагагүй:

1. Зах зээлд эзлэх хувь

- Улсын болон хувийн салбарын боловсролын салбар дахь ач холбогдол, өнгөрсөн үеийн чиглэл болон ирээдүйн чиг хандлага
- Улсын болон хувийн салбаруудын өртөг, чанар
- Санхүүжилтийн эх үүсвэр

2. Төсвийн зарлага болон бодлогын тэргүүлэх чиглэл

- Бодлогын тэргүүлэх чиглэл, зорилт болон зардлын урьдчилсан тооцоо, өнгөрсөн жилүүд болон дунд хугацааны төлөвлөгөө, хэрэгжүүлсэн болон төлөвлөж буй шинэчлэлийн хөтөлбөрийн талаарх нэгдсэн дүгнэлт
- Нийт боловсролын санхүүжилтийн эх үүсвэрийн чиг хандлага – Төв Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, эцэг эх, гадаадын эх үүсвэр 1995-2002 онд
- Зарлагын хуваарилалтыг дараахь чиглэлээр хувааж судлах:
 - БСШУЯ болон Засгийн газрын бүх шатны салбаруудын нийт зарлага – төв Засгийн газар, аймаг, дүүрэг гэх мэт – тогтмол болон хөрөнгийн капитал зардал тус бүрээр нь
 - Зардлын хөтөлбөр тус бүрийн ангилал – стандарт хөтөлбөрийн ангилалыг төсвийн статистикийн албан ёсны мэдээнд хуваарилсан байдлаар нь

(цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд, их дээд сургуулиуд, коллеж, мэргэжлийн болон техникийн сургалтууд)

- Орцоор нь зардлыг ангилна: тогтмол зардлыг төсвийн статистикийн албан ёсны мэдээнд хуваарилсан байдлаар нь (цалин, тэтгэлэг гэх мэт) болон хөрөнгийн капитал зарлагаар нь буюу тоног төхөрөмж, барилга байгууламж, газар өмчлөл болон бусад ангилалаар хуваарилна.
- Аймаг, сум болон сургуулиудаар нь зарлагын хуваарилалт – тогтмол зарлага болон хөрөнгө оруулалтын зарлага тус бүрээр нь
- Олон улстай харьцуулсан байдлаар: Азийн бусад орнууд болон шилжилтийн эдийн засагтай орнууд ДНБ-нийхээ хэдэн хувийг боловсролын салбарт зарцуулдаг болох (функциональ болон эдийн засгийн ангилалаар нь)
- Капитал хөрөнгийн, ажиллах хүчний, үйл ажиллагааны болон засвар арчилгааны зарлагын тэнцэл.

- Зарлагын чиг хандлага нь тэргүүлэх чиглэл, хөтөлбөрүүдтэй нийцэж байгаа эсэх дээр санал өгөх. Бэрхшээлийг бий болгож буй цэгийг тодорхойлох.

3. Үнийн бодлого болон орлого

- Албаны бичиг баримтыг ашиглан үнийн зохицуулалт, боловсролын байгууллагууд орлогоо хэрхэн зарцуулж буйг тусгасан тайланг багтаасан Засгийн газрын бодлогыг тодорхойлох
- Төлбөрийн үнэ болон үндэслэлийг тусган бодлогын гол зорилтуудыг тогтоох
- Улсын болон хувийн сургалтын байгууллагуудад төлж буй үнийн түвшин, бүтцийн ангилал (хураамж, барилга байгууламжинд оруулах хувь хэмжээ, ном гэх мэт) болон боловсролын түвшингийн талаар бодит тоо мэдээг цуглуулах
- Улсын сургуульд суралцахад төлөх төлбөрөс бүрддэг нийт орлогын түвшингийн талаар тоо мэдээ цуглуулах, сургалтын байгууламжуудын хувьд зардал эргэн нөхөлтийн судалгааг хийх

4. Боловсролын бүтээгдэхүүн

Үр дүн

- Боловсролын гол бүтээгдэхүүнүүдийг (сургууль элсэлт, сургуулиас гаралт, төгсөлт, сургалтын ололт, амжилт, зах зээлийн эдийн засагтай хэр хамааралтай) боловсролын түвшин тус бүрээр нь гаргах
- Газар зүйн, үндэс угсааны болон эдийн засгийн (ядуу/ ядуу биш) бүлгүүдийн ялгааг тогтоох
- Хүсэн хүлээсэн бүтээгдэхүүнийг (сургуулийн элсэлт их байх, сургуулиас гарах явдал бага байх гэх мэт) бий болгоход зарцуулж буй зарлагын үр дүн хэр байгааг судлах, ингэхдээ төрөс олгож буй татаас (жишээ нь цэцэрлэгт хүнс олгох, хичээлийн хэрэгслэлийн хангамж, тэтгэмж болон сургалтын зээл олгох гэх мэт) үр дүнтэй эсэхийг анхаарах хэрэгтэй

Адил тэгш байдал – боломж харилцан адилгүй байх (засаг захирагааны, орлогын болон бусад холбогдох ангилалаар)

- Боловсролын үйлчилгээний хүртээмж
- Үзүүлж буй үйлчилгээний чанар
- Ашиглалтын түвшин болон саад тотгор
- Нэг хүнд болон нэг оюутанд ноогдох зарлагын хэмжээ
- Өрхөд ноогдох боловсролын үйлчилгээний өртөг (дээрхийг харна уу, албаны/ албан бус/ зохицуулалтын асуудлууд)
- Улсаас боловсролын салбарт гаргах зардлын үр өгөж, ялангуяа Нэгдсэн арга хэмжээ болон Сургалтын санд төрөс татаас өгөх нь хэнд үр өгөжө өгөхийг харгалзах

5. Санхүүжилт дутуу, илүү болон үр ашиггүй байдаг хэсгийг илрүүлэх

- Улсын хөрөнгийг ерөнхий боловсролд хуваарилахад ашиглагддаг норм нь үйлчилгээг дундаж түвшинд үзүүлэхэд гарах тооцоо хоорондоо хэр нийцтэйг судлах. Тэдгээрийг сайжруулах хувилбарыг санал болгох
- Зарлага төдийлэн шаардлагагүй хэсгийг илрүүлэх
- Мөн түүнчлэн
 - Ажиллах хүчний хэмжээ болон тэдэнд зарцуулж буй зарлага
 - Татаасын үр дүн, үр ашигтай байдлыг голчлон судлах

6. Төсвийн зарлагын удирдлага

- Төлөвлөх болон төсөвлөх
 - Үйл явц
 - Төсөвт тусгагдаагүй орлогын эх үүсвэр, үүнд хэрэглэгчдийн хураамжийг оруулна.
- Төсвийн гүйцэтгэл
 - а) Урсгалын тодорхойлолт
 - б) Бодит зарлага болон урьдчилан төсөвлөлтийн харьцуулалт
 - в) Яам, орон нутгийн засаг захиргаа болон үйлчилгээ үзүүлэгч нэгжүүдэд зарцуулалтын хийгддэг хугацаа болон хуваарь
 - д) Үйлчилгээ үзүүлэгч төвүүдэд бэлэн мөнгө болон бараа бүтээгдэхүүнийг хичнээн хэмжээгээр төсөвлөдөг болох
 - е) Боловсролын байгууллагуудын санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой бодлого болон практик ажиллагааг сайжруулах шаардлагатай хэсгийг тодруулах

7. Хяналт болон хариуцлага

- Зарлагын хяналтын механизм хэр зохистой
- Дотоодын аудит болон өргөн хүрээний хяналтын үйл явц хэр зохистой
- Үйлчилгээний хүргэлтийг хянах механизм

8. Хийгдэж буй болон хийгдэх гэж буй зохион байгуулалтын өөрчлөлтүүдийн нөлөлөл: төсөвт өөрчлөлт оруулах санал

- Төвлөрөлийн бууруулалт
- Төрийн албаны өрчлөн байгуулалт
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хууль

9. Зохистой бол дараахь чиглэлээр зөвлөмж өгөх:

- Төрийн секторын өрчлөн байгуулалтыг дэмжих зорилгоор өр секторт хэрэгжүүлж буй арга хэмжээ/ үйл ажиллагаа
- Төсвийн зарлагын хуваарилалтыг ерөнхийд нь болоод нарийвчилбал тэтгэлэг, хөнгөлөлттэй (татаастай) зээл, хоолны зардал болон хичээлийн хэрэгцээнд оюутнуудад шууд олгож буй тусламж зэргийг хүн амын ядуу хэсэгт түлхүү чиглүүлэх явдлыг сайжруулах хувилбарууд
- Боловсролын адил тэгш байдлыг сайжруулж, чанарыг дээшлүүлэх төсвийн зарлагын хуваарилалтыг тодорхойлох санхүүгийн томъёоллын хувилбарууд
- Боловсролын сангийн тогтвортой байх чадвар
- Боловсролын бүх түвшинд хувийн хэвшлийг хөгжүүлэх хувилбарууд
- Төсөв зохиох болон төсвийн зарлагын менежментийг сайжруулах арга хэмжээнүүд

Шаардлагатай ур чадвар болон хугацаа

Ажлыг гүйцэтгэхэд тооцоогоор . . . хүн/сарын зөвлөх үйлчилгээ шаардлагатай. Баг нь олон улсын 2 зөвлөх (боловсролын эдийн засагч болон санхүүгийн удирдлагын мэргэжилтэн), дотоодын 2 зөвлөхөс (эдийн засагч болон санхүүгийн удирдлагын мэргэжилтэн) бүрдэнэ.

Олон улсын ахлах эдийн засагч (багийн ахлагч) нь:

- Эдийн засгийн боловсролын бакалавраас дээш зэрэгтэй
- Дор хаяж 8 жилийн холбогдох туршлагатай
- Бусад орнуудад эдийн засгийн төсөтэй судалгаа шинжилгээ хийсэн
- Зөвлөхүүдийн багийг удирдаж байсан туршлагатай байна.

Монгол улсад буюу шилжилтийн эдийн засагтай орнуудад ажилласан туршлагатай бол давуутайд үзнэ.

Ахлах санхүүгийн удирдлагын мэргэжилтэн нь:

- Санхүүгийн боловсролын бакалавраас дээш зэрэгтэй
- Дор хаяж 8 жилийн холбогдох туршлагатай
- Бусад орнуудад эдийн засгийн төсөтэй судалгаа шинжилгээ хийсэн байна.

Монгол улсад буюу шилжилтийн эдийн засагтай орнуудад ажилласан туршлагатай бол давуутайд үзнэ.

Дотоодын зөвлөх эдийн засагч нь:

- Эдийн засгийн боловсролын бакалавраас дээш зэрэгтэй, ингэхдээ микро эдийн засаг, хүний нөцийн эдийн засаг буюу холбоотой салбарт мэргэшсэн
- Холбогдох чиглэлийн судалгааг хийсэн дор хаяж 5 жилийн туршлагатай
- Монгол улсын боловсролын системийн талаар ойлголт мэдлэгтэй
- Төрийн санхүүгийн системийн талаар ойлголт мэдлэгтэй байна.

Дотоодын зөвлөх санхүүгийн удирдлагын мэргэжилтэн нь:

- Санхүүгийн боловсролын бакалавраас дээш зэрэгтэй
- Холбогдох чиглэлийн судалгаа хийсэн дор хаяж 5 жилийн туршлагатай
- Монгол улсын боловсролын системийн талаар ойлголт мэдлэгтэй
- Төрийн санхүүгийн системийн талаар ойлголт мэдлэгтэй байна.

Бүх зөвлөхүүд нь бичгийн болон ярианы англи хэлний өндөр мэдлэгтэй байна.

Тайлагнах шаардлага болон Зөвлөхөд үзүүлэх дэмжлэг

Баг нь (БСШУЯ-наас томилсон хүний нэр, албан тушаал)-д тайлагнах бөгөөд БСШУЯ-ны багтай ажиллана.

БСШУЯ нь ажлын байр, ерөнхий хангамжаар хангах бөгөөд уулзалт, газар дээрх айлчлалыг зохион байгуулна.

Мэдээллийн эх үүсвэр

Дэлхийн Банк, Төсвийн Зарлагын Тойм Судалгаа

АХБ, Ядуурлын Үнэлгээ

НҮБХХ, Ядуурлын Үнэлгээ

Боловсролын жишээ байгууллагуудын албан ёсны тарифууд

Айл өрхүүдийн боловсролын зардлыг судалсан тоо мэдээ

Хавсралт 2:

Уулзсан хүмүүсийн жагсаалт

Баасанхүү, Д. СЕЗЯ-ны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга
Цэвээндорж, БСШУЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын орлогч дарга
Нанзаддорж, СЕЗЯ-ны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын зарлагын хэлтсийн дарга
Нарантуяа, Ш. БСШУЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын ахлах мэргэжилтэн
Буянжаргал, БСШУЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын мэргэжилтэн
Цагаач, Г. АХБ-ны Төрийн захиргааны шинэчлэлтийн төслийн боловсрол хариуцсан зөвлөх
Алтанцэцэг, Ш. Дэлхийн банкны суурин төлөлөгчийн газрын эдийн засагч
Одгэрэл, Үндэсний аудитын газрын ахлах аудитор
Лхагвасүрэн, П. СТС-гийн гүйцэтгэх захирал
Оюунцэцэг, С. СТС-гийн мэргэжилтэн
Адьяа, Д. СТС-гийн мэргэжилтэн
Отгонжаргал, С. СТС-гийн мэргэжилтэн
Мишигдорж, Д. СТС-гийн мэргэжилтэн
Дэлгэрмаа, С. СТС-гийн мэргэжилтэн
Батзаяа, СТС-гийн нягтлан бодогч
Алтанцэцэг, С. МУИС-ийн гадаад харилцааны газрын дарга
Батмөнх, Дэлхийн банкны төсвийн техник туслалцааны төслийн ажилтан
Уранбилэг, Дэлхийн банкны төсвийн техник туслалцааны төслийн зохицуулагч
Чулуунцэцэг, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн мэргэжилтэн
Алтанцэцэг, Д. СЕЗЯ-ны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Хавсралт 3:

Мониторингийн үзүүлэлтүүд

Эрэлт болон чиглүүэх үзүүлэлтүүд	Санхүүгийн үзүүлэлтүүд	Байгууллыгн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
<ul style="list-style-type: none"> • Дээд боловсролд хамрагсадын хэмжээ нэмэгдэх • Хамралт (нийт оюутанд эзлэх хувь) • Нийт өргөдөл гаргагсдад шинээр хамрагдсан оюутны эзлэх хувь • Бага, дунд орлоготой өрхийн оюутнуудын эзлэх хувь • Хамрагдсан оюутнуудын хүйсийн хуваарилалт • Хамрагдсан оюутнуудын газар зүйн хуваарилалт • Хамрагдсан оюутнуудын суралцаж буй программын хуваарилалт • Хамрагдсан оюутнуудын сурлагын амжилт (нийт оюутнуудтай харьцуулахад) • Зээлийн дундаж эргэн төлөлт, хүйс болон ястанаар • Элсэлтийн тоо болон хичээл • Сургалтын төлбөрийн зээл авагч сургуулиар • Төгсөгчдийн ажилгүйдлийн түвшин, нийт ажилгүйдлийн түвшинтэй харьцуулахад 	<ul style="list-style-type: none"> • Төлөгдөхгүй буюу хугацаандаа төлөгдөхгүй байгаа зээлийн хэмжээ (нийгмийн байдал, хүйс, сургууль, мэргэжил болн зээлийн хэмжээгээр) • Чанаргүй зээлийн багцын нийт багцад эзлэх хувь • Хугацаандаа төлөгдөхгүй байгаа зээлийн нийт чанаргүй зээлийн багцад эзлэх хувь • Бодит зээлийн хүү болон татаасын түвшин • Зээлийн эргэн төлөгдсөн харьцаа • Захиргааны зардал нийт багцтай харьцуулахад (шол зүйл ангиудын хуваарилалт) • Бэлэн мөнгөний урсгалын төсөлөл • Хөрөнгийн бодит үнэлгээний өсөлт • Хөрөнгийн эх үүсвэрийн хуваарилалт • Төсвөс хараат байдал • Төсвийн бус хөрөнгийн төвлөрөлт • Хөрөнгө оруулалтын өгөж (хөрөнгийн өгөж) • Зээлийн хүүгийн хөнгөлөлт • Эргэлзээтэй зээлийн сангийн хэмжээ • Төсвийн эдийн засгийн зардал • Хугацаа хэтэрсэн зээлийн төлөлт 	<ul style="list-style-type: none"> • Үзүүлэлтүүдийн удирдлага (дотоод үйл ажиллагааны үр ашиг, чанарыг хэмжих) • Оюутны сэтгэл ханамж • Ажилтнуудын эргэц • Оюутны зээлийн хөтөлбөрийн сурталчилгааны үзүүлэлтүүд (awareness of the program and хөтөлбөрийн талаарх мэдлэг, үүргийн ухамсарлалт) • Хамрагдах шийдвэрийн зохицолдлого • Өргөдлийг боловсруулах хугацаа • Өргөдөл буцаах хувь хэмжээ • Оюутны үндэслэлтэй өргөдөл гомдолын тоо, цар хүрээ • Оюутны гомдлыг шийдвэрлэх хувь хэмжээ • Зээлийн төлбөрийн хугацаа өнгөрөх ба арга хэмжээ авах хоорондын хугацаа • Шүүхийн шийдвэрлэх явцад байгаа хэргүүд • Аудит

Хавсралт 4:

Сургалтын төрийн сангийн сайжруулсан журам

Оршил

Энэ тайланд СТС-гийн оюутны зээл тусламжийн хөтөлбөрийг судалсаны үндсэн дээр уг сангийн үйл ажиллагааны журмын нилээд хэдэн өөрчлөлтүүд болон бодлого, үйл ажиллагааны чанартай саналуудыг тусгасан болно. Монголын БСШУЯ ба Дэлхийн Банкнд зориулагдсан 2004 оны энэхүү тайланд одоо хэрэглэж байгаа хөтөлбөрийн бодлогын ба үйл ажиллагааны зарим дутагдалтай талуудыг харуулсан. Эдгээр өөрчлөлтүүд үйл ажиллагааны журмыг илүү тогтвортой нэгдмэл, бүтцийг бий болгоход чиглэгдсэн юм.

Энэ хавсралт уг хөтөлбөрийн өөрчлөлт оруулсан ерөнхий санааг илэрхийлсэн юм. Энэ нь зөвхөн өөрчлөлтийн ерөнхий төлөвлөгөө бөгөөд одоогоор эцсийн байдлаараа боловсруулагдаагүй байна. Шинэчлэгдсэн зээл тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд БСШУЯ ба СТС, их дээд сургуулиудын гүйцэтгэх алхмуудыг тодруулахад чиглэгдсэн.

Тус сангийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны шинэ загварыг тодорхойлсны дараа үйл ажиллагааны нарийвчилсан журмыг боловсруулах хэрэгтэй.

СТС-ын журмын зорилго

Энэхүү журам нь СТС-гийн үйл ажиллагааг эрхлэн явуулж буй хэрэгжүүлэгчдийн гарын авлага болно. Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамрагдсан БСШУЯ, СЭЗЯ-ны ажилтнууд;
- СТС-ын ажилтнууд;
- Санхүүжилт авс буй их дээд сургуулиудын сонгон шалгаруулах комисс ба сургалтын алба.

Мэдээллийн ном, гарын авлагаар оюутнуудыг хангаж, СТС-гийн тухай мэдээллийг бичгээр тараах нь тохиромжтой.

Үйл ажиллагааны журам нь дараахь хэсгүүдээс тогтоно.

- Хэсэг 2: Хөтөлбөрийн тухай
- Хэсэг 3: Статистикийн судалгаа хийх
- Хэсэг 4: Зээл авах давуу эрхийг тодорхойлох
- Хэсэг 5: Оюутнуудын СТС-гийн талаар мэдлэгийг дээшлүүлэх
- Хэсэг 6: Зээл тусламж авах эрхийг тодорхойлох
- Хэсэг 7: Гэрээ байгуулах
- Хэсэг 8: Санхүүжилтийг сургуулиудад шилжүүлэх
- Хэсэг 9: Төгссөний дараах орлогыг тодорхой мэдэж байх
- Хэсэг 10: Зээлийн хүүгийн тухай
- Хэсэг 11: Зээлийг эргэн төлүүлэх

Дараах стандартчлагдсан баримтуудыг хавсаргав:

- Зээл тусламж хүсэх өргөдлийн загвар
- Зээлийн гэрээ
- Тусламжийн гэрээ

Хөтөлбөрийн тухай

Сургалтын зээл тусламжийн хөтөлбөрийн хамгийн гол зорилго бол сурлагандаа сайн боловч бага орлоготой учраас үргэлжлүүлэн их дээд сургуульд суралцах боломжгүй болсон оюутнуудад санхүүгийн талаар туслах явдал юм. Уг журам нь хөтөлбөрийн өргөн далайц, эрх тэгш байдал ба тогтвортой байдлыг хангахад зориулагдсан болно.

Монгол улсын оюутны зээл тусламжийн хөтөлбөрийн тухай Засгийн газрын шинэ тогтоолоор үйл ажиллагааны журмыг бататган бэхжүүлж өгөх хэрэгтэй. Энэ тогтоол өмнөх холбогдох бүх тогтоол журмуудыг орлох юм.

Оюутны зээлийн хөтөлбөр дараах 2 төрлийн санхүүгийн тусламжийг хардаг байх. Үүнд:

- Эргэн төлөгдөх зээл
- Эргэн төлөгдөхгүй буцалтгүй тусламж

Урьд нь олгогдсон ихэнх зээл тусламжууд дээр дурдсан ангилалд хамрагдаж байсан. Гэхдээ, төрийн албан хаагчийн хүүхдэд олгодог тусламж одоо энэ хөтөлбөрөөс тусдаа, бие даасан сан, журамтай болсон.

Сургалтын 2 төрлийн зээл тусламжийг дараах байдлаар тодорхойлно.

Эргэн төлөгдөх зээл	Эргэн төлөгдөхгүй тусламж
<ul style="list-style-type: none">• Ядуу өрхийн суралцагч <i>Тодорхойлж өгнө</i>	<ul style="list-style-type: none">• Нэн ядуу өрхийн суралцагч <i>Тодорхойлж өгнө</i>
<ul style="list-style-type: none">• Тахир дутуу өрхийн суралцагч <i>Тодорхойлж өгнө</i>	<ul style="list-style-type: none">• Эмзэг блгийн өрхийн оюутан <i>Тодорхойлж өгнө</i>
<ul style="list-style-type: none">• Онцгой авъяастай оюутан <i>Тодорхойлж өгнө</i>	<ul style="list-style-type: none">• Онцгой авъяастай оюутан <i>Тодорхойлж өгнө</i>

Эргэн төлөгдөх зээлийн хэмжээг оюутны хэрэгцээнд зохицуулж тогтоох ба дараах зардлууд багтаж болно.

- Сургалтын төлбөр
- Амьжиргааны зардал
- Унааны зардал

Эргэн төлөгдөхгүй тусламжид дараах зардлууд багтана.

- Сургалтын төлбөр
- Амьжиргааны зардал

Зээл тусламжийг үргэлжлүүлэх, дахин сургээх эсэх нь суралцаж буй их, дээд сургуулийн тодорхойлсон суралцагчийн сурлагын амжилтаас хамаарна.

Оюутанд өгөх зээл тусламжийн хэмжээг дараах байдлаар тогтооно.

- Төлсөн сургалтын төлбөрийн хэмжээ
- Оюутны гэр бүлийн 7 хоногийн орлогын хэмжээ
- Оюутан гэртээ эсвэл гэрээсээ хол сурч байгаа эсэх.

Эргэн төлөгдөх зээлийн хувьд, оюутныг төгсөхөд нь эргэн төлөх төлөвлөгөөг боловсруулан, харилцан тохирно. Зээлийн хүү нь хичээлийн жил бүрийн эхэнд Монгол Банкны зээлийн хүү + 1 хувиар тогтооно. Зээл олгож эхэлсэн цагаас эхлэн хүүг тооцож төлүүлнэ.

Зээл тусламжаар төгссөн оюутнууд хаана ажилд орсноос шалтгаалан зээлээ эргэн төлөх юмуу эсвэл ажиллаж төлнө. Хувийн байгууллагад орсон төгсөгчийн цалингаас тогтмол хувиар суутгаж төлүүлнэ. Төрийн албанд ажилд орсон төгсөгчдийн хувьд зээл тэдний ажилласан сараар тооцогдон хасагдана.

Статистикийн судалгаа хийх

- Хөдөөлмөрийн зах зээл ба янз бүрийн мэргэжлүүдэд хүрч судалгаа хийх
 - Одоогийн ба ирээдүйд хэрэгцээтэй байгаа мэргэжлүүдийг олж тогтоох
 - Хөдөөлмөрийн зах зээл дээрх хэрэгцээнд тулгуурлан зээл авах талаар ялгавартай тогтоох
- Боловсролын талаар мэдээлэлтэй байх
 - Дээд боловсрол эзэмшүүлэгчид, тэргээрийн тоо ба мэргэжлийн чиглэл
 - Дээд боловсрол эзэмшиж буй оюутнуудын талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх (тоо, нас хүйс, үндэстэн ястан ба сурч буй мэргэжил г.м)
- Хүн амын мэдээлэлтэй байх
 - Ядуурлын түвшинг бататган тогтоох
 - Бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөж буй оюутнуудын тухай мэдээлэлтэй байх (хүйс, төгсөгчдийн тархалтын байдал аймаг хотоор, үндэстэн ястан)
 - Төгсөгчдийн төгсөлтийн шалгалтын дүнг мэдэж байх, дүн шинжилгээ хийх.

Зээл авах давуу эрхийг тодорхойлох

- Төсөв төлөвлөхдө:
 - Төсвийн урсгалын загварыг гаргах (зээлийн эргэн төлөлтийг оролцуулан)
 - Төвлөрсөн төсөв ба СТС-гийн төсвийг тогтоох
 - Зээл/тусламжийн харьцаа ба хуваарилалтыг ангилал тус бүрээр төлөвлөх
 - Мэргэжилд чиглэгдэх
- Зээл тусламж авах түвшинг тогтоох
 - Төсвийн хэмжээ ба эцсийн шалгалтын үр дүнд тулгуурлан зээл тусламж авч болох сурлагын доод түвшинг тогтоох
 - Одоогийн ядуурлын түвшинд тулгуурлан зээл тусламж авч болох санхүүгийн чадварын түвшинг тогтоох.

Оюутнуудын СТС-ын талаар мэдлэгийг дээшлүүлэх

- Оюутнуудад сурлагын амжилтаар зээл тусламж авч болно гэдгийг мэдүүлэх
 - Эцсийн шалгалтанд нь үндэслээд сурлагын амжилтаараа зээл тусламж авах болзол хангасан оюунуудыг тогтоох
 - Сурлагын өндөр амжилт үзүүлсэн доктор оюутнуудыг тогтоох
 - Оюутнуудын зээл тусламж авах эрхтэй гэдгийг бичгээр мэдэгдэх
 - Оюутнуудын сэтгэл ханамжийн тухай судалгаа хийх
 - Интернетээр мэдээлэл цацах, вэб хуудастай болох

- Мэдээллийн номыг дунд сургуулиудад тараах
- Бусад (маркетингийн стратегийг үндэслэн).
- Зээл тусламж хүсэх өргөдлийн загварыг гаргаж, оюутан сургуулиудад тараах
 - Зээл тусламж хүсэх өргөдөлд эргэн төлөх механизмын талаар хангалттай мэдээлэл тусгасан байх
 - Өргөдлийн загварын интернет ба электрон шуудангаар тараах.

Зээл тусламж авах эрхтэй эсэхийг тодорхойлох

- Их, дээд сургуулиудад төсвийг танилцуулах
 - Дээд боловсрол олгогчдод санхүүжилтийн хэмжээг мэргэжил, боловсролын байгууллага тус бүрээр мэдэгдэх
 - Дээд боловсрол олгогчдод зээл/тусламжийн харьцааг мэдэгдэх
 - Зээл тусламж авах сурлагын ба санхүүгийн түвшинг танилцуулах.
- Өргөдөл хүлээн авах, шийдэх
 - Өргөдлийг суралцагчийн сурлагын ба санхүүгийн чадвараар нь шийдвэрлэх
 - Тогтоосон түвшинд хамрагдаж чадаагүй оюутнуудад зээл тусламж олгохгүй болсныг бичгээр мэдэгдэх
 - Холбогдох бичиг баримтын бүрэн бүтэн байдлыг хянах
- Зээл тусламж авах эрхийг сонгон шалгаруулах шалгуурын дагуу тогтооно.
 - Зээл:

[Шалгуур]

- Тусламж:

[Шалгуур]

- Оюутнуудыг сонгон шалгаруулах
 - Оюутнуудыг зээл/тусламж авах эрхтэй эсэхийг нь тогтоох
 - Санхүүгийн хэрэгцээ ба сурлагын амжилтаар нь зээл/тусламж авах эрхтэй оюутнуудыг давуу эрхтэй эсэхийг тогтоох
 - Хэрэгцээнд зориулж санхүүжилтын хэмжээг тогтоох

Гэрээ байгуулах

- Холбогдох баримт бичгийг шалган судлах
 - Улсын бүртгэлийн гэрчилгээний түүвэр шалгалт хийх
 - Гарын үсэг үэн зөв эсэхийг тогтоох
 - Бичиг баримтын үнэн зөв эсэхийг тогтоох

- Санхүүгийн тусламжийн нөхцлүүдийг тохирох
 - Эргэн төлөх төлөвлөгөө гаргах
 - Тусламжийн нөхцлийг тогтоох
 - Сурлагын байдлыг тогтоох
 - Гурвалсан гэрээнд бүх гарын үсгүүдийг зуруулах
- Санхүүгийн тусламжийг үргэлжлүүлэх
 - Оюутны сурлагын байдлыг харгалзан үзэх
 - Оюутны өрхийн орлогыг харгалзан үзэх

Санхүүжилтийг сургуулиудад шилжүүлэх

- Зээлийн карт нээх
 - Зээлийн картын хийж, дугаарлах
 - Энэ мэдээллийн систем/өгөгдлийн хуудсанд оруулах
- СЭЗЯ-ны зөвшөрлөр санхүүжилтийг шилжүүлэх
 - СЭЗЯ -д өгөгдлийн хуудсыг илгээх
 - ...
 - ...
- Эргэн төлүүлэх явц
 - ...
 - ...
 - ...

Төгссөний дараахь орлогыг тодорхой мэдэж байх

- Төгсөгчидтэй байнгын холбоотой байх
 - Оюутныг тогтмол хяналтын системд оруулах
 - Оюутны зээлийн картыг тогтмол хянаж, тэдэнд сануулгын бичиг илгээх
 - Санхүүгийн/ажлын мэдээллийг шинэчилж байх
- Зээлийн картны ажил эрхлэл ба санхүүгийн байдлыг цаг тухайд нь шинэчлэх
 - Эргэн төлөх хувийг тогтоохдоо орлого нь амьжиргааны түвшний доод үзүүлэлтээс дээгүүр байхаар тогтоох
 - Ажлын шаардлага хангаж байгаа эсэхийг мэдэх
- Эргэн төлөх төлөвлөгөөг шинэчлэх

- Ажлын идэвхи, гүйцэтгэсэн үүргээр нь төлбөрөс хөнгөлөх
- Оюутны төлбөрийн чадвараас хамаарч эргэн төлөх төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах

Зээлийн хүүгийн тухай

- Хүүг дахин тооцох
 - ...
 - ...
 - ...
 - Хүүгийн хэмжээ ба төлөгдсөн байдлыг тайлагнах
- Хүүг төлөхгүй байх нөхцлийг тодорхойлох
 - ...
 - ...

Зээлийг эргэн төлүүлэх

- Эргэн төлөх төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтийг хянан шалгах
 - Эргэн төлөлтийг хянах
 - Эргэн төлөхгүй байгаа оюутнуудтай холбоо барих
 - Шаардлагатай бол төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах
- Холбоо барьж чадахгүй байгаа төгсөгчдийг олж тогтоох
 - Гадаадад сурч байгаа/сурсан оюутнууд
 - Дотоодод сурч байгаа/сурсан оюутнууд
- Зээлийг эргэн төлүүлэхгүй байх
 - Зээлийг эргэн төлүүлэхгүй байх нөхцлүүд
 - Зээлийг эргэн төлүүлэхгүй байх журам
- Шаардлагатай үед хуулиар шаардах
 - ...
 - ...
 - ...

Хавсралт 5.

СТС-гийн бүтэц, зохион байгуулалт



Хавсралт 6.

Сургалтын төрийн сангийн нэг хуудас стратеги бүдүүвч

